# ХЭНТИЙ АЙМГИЙН БАЯН-АДАРГА СУМЫН
# “СУМЫН НУТАГ ДЭВСГЭРИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ”
# БОЛОВСРУУЛАХ АЖИЛ

***I. Хээрийн судалгааны тайлан***

ЗАХИАЛАГЧ: ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭГЧ: “ВЕКТОР МЭП” ХХК

*Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, 6-р хороолол, 34-А байр, 1-р давхар,*
*Утас: 99039907, 99251610* *Веб:* www.vectormap.mn
*Имэйл. vectormapgeo@gmail.com8, Sh,naranochir@gmail.com,*

Улаанбаатар хот
2022 он

## АГУУЛГА

НЭГ. ЕРӨНХИЙ ХЭСЭГ ........ 4
1.1. Зорилго ........ 4
1.2 Баримтлах зарчим ........ 4
1.3 Ажлын иж бүрдэл ........ 5
1.4. Ажлын үе шат ........ 8
ХОЁР. БЭЛТГЭЛ АЖЛЫН ҮЕ ШАТ ........ 9
2.1. Сумын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж ........ 9
2.1.1. Сумын танилцуулга ........ 9
2.1.2. Сумын хилийн цэс ........ 10
2.1.3. Багийн хилийн зааг ........ 12
2.2. Хөгжлийн чиг хандлага, Бодлого хөтөлбөрүүд ........ 15
2.2.1. Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал ........ 15
2.2.2. "Алсын Хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого ........ 15
2.2.3. Хэнтий аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл ........ 16
2.2.4. Хэнтий аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр ........ 18
2.2.5. Баян-Адарга Сумын Засаг Даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр ........ 21
2.3. Сумын газар зүйн тогтоц, онцлог ........ 23
2.3.1. Сумын физик газар зүйн тогтоц, онцлог ........ 23
2.3.2. Газрын гадарга өндөржилт ........ 24
2.3.3. Газрын гадаргын налуужилт ........ 27
2.3.4. Гадаргын зүг зовхис ........ 29
2.4. Сумын уур амьсгалын онцлог ........ 31
2.5. Хөрс, хөрсөн бүрхэвч ........ 37
2.6. Ургамалжилт ........ 45
2.6.1. Ургамлын бүс, бүслүүр ........ 45
2.6.2. Ургамал газарзүйн мужлал ........ 48
2.6.3. Ургамлын экологийн хэв шинж ........ 51
2.6.4. Бэлчээрийн ургамалжилтын төрөл ........ 54
2.6.5. Бэлчээрийн төрх байдал ........ 56
2.6.6. Бэлчээрийн төлөв байдал ........ 58
2.7. Ойн нөөц, төлөв байдал ........ 61
2.8. Гадаргын болон гүний усны нөөц ........ 63
2.9. Инженер геологийн нөхцөл ........ 73
ГУРАВ. НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ ........ 75
3.1 Хүн ам зүй ........ 75
3.1.1 Хүн амын тоо ба өрхийн байдал ........ 75
3.1.2 Хүн амын амьжиргааны түвшин ба орлого ........ 79
3.1.3. Хүнсний хэрэгцээт байдал ........ 79
3.2 Хөдөө аж ахуйн салбар ........ 81
3.2.1 Мал аж ахуйн салбар ........ 81
ДӨРӨВ. СУМЫН ГАЗРЫН ТОХИРОМЖТОЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ ........ 87
ТАВ. БАЯН-АДАРГА СУМЫН ГАЗАР АШИГЛАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ ........ 91
4.1. ГАЗРЫН НЭГДМЭЛ САН ........ 91
4.2. СУМЫН ГАЗАР АШИГЛАЛТЫН ОДООГИЙН БАЙДАЛ ........ 93

4.2.1. Бэлчээр ашиглалт ........ 95
4.2.2. Тариалангийн газар ашиглалт ........ 98
4.2.3. Ойн сан бүхий газрын ашиглалт ........ 99
4.2.4. Уул уурхайн ашиглалт ........ 101
4.2.5. Аялал жуулчлалын газрын ашиглалт ........ 102
4.2.6. Тусгай хамгаалалттай газар ........ 103
4.2.7. Амьтны тархалт ........ 104
4.2.8. Түүх соёлын дурсгал ........ 107
4.3. АЖ АХУЙН ТӨРӨЛЖИЛТИЙН СУДАЛГАА ........ 110
ЗУРГАА. ХЭЭРИЙН СУДАЛГАА ........ 111
6.1. Эхний шатны хээрийн судалгааны ажил ........ 111
6.1.1. Уулзалт, танилцуулга ........ 111
6.1.2. Ярилцлага, хэлэлцүүлэг ........ 112
6.1.3. Статистик мэдээ цуглуулах ........ 114
6.1.4. Хил зааг, байршил тогтоох, зураглах ........ 118
6.1.5. Баян-Адарга сумын судалгааны нэгтгэл ........ 122
6.2. Хоёр дахь шатны хээрийн судалгааны ажил ........ 127
6.3. Сумын БИНХ хэлэлцүүлэх, санал авах ........ 132
6.3.1. Хөдөө аж ахуйн газрын төлөвлөгөө ........ 138
6.3.2. Хот тосгон, бусад суурин газрын төлөвлөгөө ........ 146
6.3.3. Зам, шугам сүлжээний газрын төлөвлөгөө ........ 147
6.3.4. Усны сан бүхий газрын төлөвлөгөө ........ 149
6.3.5. Ойн сан бүхий газрын төлөвлөгөө ........ 152
6.4.6. Тусгай хамгаалалттай газрын төлөвлөгөө ........ 154
АШИГЛАСАН НОМ, БҮТЭЭЛИЙН ЖАГСААЛТ ........ 155

# НЭГ. ЕРӨНХИЙ ХЭСЭГ

Манай "Вектор мэп" ХХК нь Хэнтий аймгийн Засаг даргын тамгын газар болон аймгийн газрын харилцаа барилга хот байгуулалтын газартай "Хэнтий аймгийн Баян-адарга, Баян-овоо, Норовлин сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах" зөвлөх үйлчилгээний ажлыг гүйцэтгэхээр 2022 оны 01 сарын 17-нд дугаар № ЗҮ2022/01 тоот гэрээ байгуулан ажиллаж байна. Энэхүү ажлаар бид 2018 онд боловсруулан өнөө мөрдөгдөж байгаа Норовлин сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг шинэчилсэн арга зүйгээр тодотгон боловсруулах, 2015 онд боловсруулсан Баян-Адарга сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний хугацаа дууссан тул дахин шинэчлэн боловсруулах, Баян-Овоо сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг анх удаа боловсруулах ажлыг тус тус гүйцэтгэнэ.

Мөн сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах явцад байгаль орчин, нийгэмд учруулж болзошгүй эрсдэлүүдээс сэргийлж, мөн хангалтгүй/зохицуулалтгүй төлөвлөлтөөс үүдэн ирээдүйд байгаль орчин, нийгэмд учруулж болзошгүй аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх/нөлөөллийг багасгах зорилгоор Байгаль орчин ба нийгмийн удирдлагын хүрээ (БОНУХ)-нд эрсдэл бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх явдал юм.

**Энэхүү тайланд бэлтгэл ажлын хүрээнд хийгдсэн ажил болон мэдээллүүдийг тусгалаа.**

## *1.1. Зорилго*

Төсөл хэрэгжих Хэнтий аймгийн Баян-Адарга сумын нийт газар нутгийн хэмжээнд Улс, аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулсан газар, байгалийн нөхцөл, нөөц, нийгэм, эдийн засгийн хэрэгцээ, орон нутгийн уламжлалт онцлогт нийцүүлэн олон төрөлт газар ашиглалтыг хөгжүүлэх, газрын нөөцийн үр өгөөж, бүтээмжийг дээшлүүлж урт хугацаанд тогтвортой ашиглахын зэрэгцээ экологийн тэнцвэрт байдлыг хангах замаар нутаг дэвсгэрийн тогтвортой хөгжлийг дэмжсэн дунд хугацаанд хэрэгжүүлэх газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулахад оршино.

## *1.2 Баримтлах зарчим*

- *Газрын доройтлыг бууруулах, биологийн олон янз байдлыг хамгаалах, газрын тогтвортой менежментийг дэмжихийн тулд ландшафтын түвшиний (эсвэл экосистемийн) хандлага, газрын доройтол, уур амьсгалын өөрчлөлт, биологийн олон янз байдлыг харгалзан үзэх;*
- *Газар зохион байгуулалтын төлөвлөлтийн шинэчилсэн аргачлалаар экосистем эсвэл ландшафтад суурилсан арга хэрэгсэл, LADA-WOCAT эсхүл холбогдох бусад арга*

*хэрэгслийг тусгах замаар сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах;*
- ❖ *Жендерийн мэдрэмжтэй, тэгш оролцоог хангасан байх;*
- ❖ *Иргэдийн аюулгүй орчинд, сайн сайхан амьдрах нөхцөлийг хангах;*
- ❖ *Иргэд, олон нийтийн оролцоотой, хэрэгжихүйц байх;*
- ❖ *Байгаль орчинд ээлтэй байх;*
- ❖ *Үр ашигтай байх;*
- ❖ *Орон нутгийн болон хувь хүний өрсөлдөх чадварыг дэмжсэн байх;*
- ❖ *Ил тод нээлттэй байх;*
- ❖ *Хяналт, үнэлгээ хийх боломжтой байх*

### *1.3 Ажлын иж бүрдэл*

Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажлаар Хэнтий аймгийн Баян-Адарга сумын газар нутгийг бүрэн хамруулж дараах иж бүрдэлтэйгээр хийж гүйцэтгэнэ.

1. Баян-Адарга сумын нөхцөл, нөөцийн судалгаа. Үүнд:
   - Байр зүйн мэдээ
   - Агаар сансрын зургийн мэдээ
   - Засаг захиргааны хилийн мэдээ
   - Уур амьсгалын мэдээ
   - Газрын гадаргын мэдээ
   - Байгалийн нөөц, дагалдах баялгийн мэдээ
   - Ургамалжилтын мэдээ
   - Хөрсний мэдээ
   - Ойн мэдээ
   - Инженер геологи, гидрологийн мэдээ
   - Газар ашиглалтын мэдээ
   - Нийгэм эдийн засгийн мэдээ
2. Мэдээлэлд дүн шинжилгээ хийж мэдээллийн сан үүсгэн, зохих боловсруулалтыг хийх.
   - Бэлтгэсэн тоон болон шинж чанарын мэдээлэлд тулгуурлан тухайн сумын нутаг дэвсгэрийн газар, байгалийн нөөц, газрын төлөв байдал, чанарт анализ дүн шинжилгээний тоон боловсруулалтыг хийж зурган мэдээг төрлөөр /ГНС, ашиглалтын байдал, хүрээлэн буй орчин г.м./ ангилж гаргах ба зохих дүгнэлт зөвлөмжийг гаргах.
   - Тоон мэдээлэлдээ тулгуурлан ашиглалт бүрээр тохиромжтой байдлын үнэлгээний арга зүйн дагуу тохиромжтой байдлын үнэлгээ хийж нийгэм эдийн

засаг, статистикийн мэдээг боловсруулж хэрэгцээт байдлыг урьдчилсан байдлаар тодорхойлж мэдээллийн сан үүсгэх.

- Хээрийн хэмжилт судалгааг холбогдох мэргэжилтэн, орон нутагтай хамтран гүйцэтгэж газар ашиглалтын тохиромжтой байдал, одоогийн ашиглалтыг газар дээр нь тодруулж зохих хэмжилт, өөрчлөлтүүдийг хийж иргэд, хуулийн этгээдээс санал авч, хэлэлцүүлэг хийх.
- Бэлтгэл болон хээрийн судалгааны ажлын үр дүнг боловсруулж мэдээллийн санг шинэчлэн сайжруулж улмаар газар ашиглалтын тохиромжтой болон хэрэгцээт байдлыг нарийвчлан тодорхойлж нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулж гаргах.
- Зүй ёсны эрхийн зориулалтаар газар ашиглах боломжтой нөөцийн байршил, хэмжээг тогтоож, зурагт буулган төлөвлөлтөд тусгах зэрэг болно.

**Хамрах хүрээ:** Хэнтий аймгийн Баян-Адарга сум – 302607.7 га газар нутгийг хамарна. /*Зураг 1*/



*Зураг 1. Төсөлд хамрагдаж буй сум*

3. Газар байгалийн нөөцийн мэдээллийн сан бүрдүүлэх, тэдгээрт дүн шинжилгээ хийхэд дараах журам зааврыг баримтлан ажиллана. Үүнд:

- Монгол улсын хууль, эрх зүйн орчинд нийцсэн байх;
- ГЗБГЗЗГ-ын даргын 2019 оны А/134 тоот тушаалаар батлагдсан "Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах арга зүй"
- ГХГЗЗГ-ын даргын 2015 оны А/200 тоот тушаалаар батлагдсан Газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээний арга зүй;
- ГХГЗЗГ-ын даргын 2011 оны А/497 тоот тушаалаар батлагдсан Сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал;
- ГХГЗЗГ-ын даргын 2013 оны А/140 тоот тушаалаар батлагдсан Сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөний зурган мэдээлэл боловсруулах заавар;
- "Үндэсний стандарт шинээр батлах тухай "Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2021 оны с/36 тоот тушаал;
- ГХГЗЗГ-ын даргын 2007 оны А/281 тоот тушаалаар батлагдсан хөрсний зургийг тоон хэлбэрт хөрвүүлэх заавар;
- Засгийн газрын 2003 оны 28-р тогтоолоор батлагдсан "Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх журам" болон холбогдох зааврууд;
- Төлөвлөлтийн зургийг Монгол улсын стандарт "Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний 1:500000, 1:2000, 1:5000 масштабын зургийн таних тэмдэг" MNS 6316:2012 мөрдөх,
- ГХГЗЗГ-ын даргын 2016 оны А/206 тушаалаар батлагдсан "Улс, бүс, аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний зургийн тоон мэдээлэл боловсруулах заавар";
- Газрын харилцаа, барилга, геодези, зураг зүйн газрын даргын 2009 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 224 тоот тушаалаар батлагдсан "Газрын нэгдмэл сангийн тоо бүртгэл хөтлөх журам";
- Газрын даргын 2015 оны 01 дүгээр сарын 22-ны А/22 тоот тушаалаар батлагдсан "Газар, байгалийн нөөц эдэлбэрийн зүй ёсны эрхийг бүртгэн баталгаажуулах түр заавар
- НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенцоос зөвлөмж болгосон LADA болон WOCAT зэрэг шинжээчийн дүгнэлтэд суурилсан үнэлгээний аргачлал;

- Экосистем эсхүл ландшафтад суурилсан арга хэрэгсэл, LADA-WOCAT арга хэрэгсэл эсвэл холбогдох бусад арга хэрэгслийг тусгасан газар зохион байгуулалтын төлөвлөлтийн шинэчилсэн аргачлал
- “Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний 1:1000, 1:100000 масштабын зургийн таних тэмдэг“ MNS 6315:2012 болон атрибут мэдээллийн тоон өгөгдлийн стандарт дагуу бүрдүүлэн.
- ArcGIS, Erdas imagine, Mapinfo, Quantum GIS, Land manager зэрэг программ хангамж дээр суурилсан боловсруулалт, дүн шинжилгээ хийх ба холбогдох стандарт, зааврын дагуу Geodatabase бүрдүүлж ажиллана.
- Засгийн газрын 2009 оны 25-р тогтоолоор батлагдсан WGS-84 солбицол, өндрийн сүлжээг Балтын тэнгисийн өндрийн тогтолцоонд байгуулж, тоон мэдээний боловсруулалт зураглалыг UTM тусгагаар хийнэ.

### *1.4. Ажлын үе шат*

Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажлыг ГЗБГЗЗГ-ын даргын 2019 оны А/134 тоот тушаалаар батлагдсан “Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах арга зүй”-н дагуу дараах үе шаттайгаар гүйцэтгэнэ. Үүнд:

- ✓ Бэлтгэл ажил (Хүрээлэн буй орчин, байгалийн нөхцөл, нөөц, төлөв байдал, нийгэм, эдийн засаг, газар ашиглалтын мэдээллийн сан бүрдүүлэх, хээрийн судалгаагаар тодруулах шаардлагатай мэдээллүүдийг тодорхойлох);
- ✓ Хээрийн судалгаа (Олон нийтийн оролцоотой судалгаа, хэмжилт зураглал, тодруулалтын ажил гүйцэтгэнэ);
- ✓ Судалгааны үр дүнг нэгтгэх, төлөвлөгөөний эхний хувилбар /төсөл/-ыг боловсруулах (Тухайн сумын газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээ, нийгэм эдийн засгийн хэрэгцээт байдлын үнэлгээний үр дүн, олон нийтийн санал, санаачилга болон бусад судалгаа тодруулалтын үр дүнд дүн шинжилгээ хийж төлөвлөлтийн хувилбарыг боловсруулна.);
- ✓ Багийн Иргэдийн нийтийн хурлаар төслийг хэлэлцүүлэх;
- ✓ Төлөвлөгөөний сүүлийн хувилбар /төсөл/-ыг боловсруулах
- ✓ ГЗБГЗЗГ-т төслийг хүргүүлж, дүгнэлт гаргуулах;
- ✓ Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг сумын Иргэдийн төлөөлөгчийн хурлаар батлуулах, холбогдох байгууллагуудад хүлээлгэн өгөх

Төлөвлөгөөний үе шат бүр дэх төлөвлөгөө боловсруулах үйл ажиллагааг ГЗБГЗЗГ-ын даргын 2020 оны А/40 тушаалаар батлагдсан “Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем ажиллуулах журам”-ын дагуу “Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем”-ийг ашиглан гүйцэтгэнэ.

# ХОЁР. БЭЛТГЭЛ АЖЛЫН ҮЕ ШАТ

## 2.1. Сумын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж

### *2.1.1. Сумын танилцуулга*

*Түүхэн хөгжлийн тойм:* Баян-Адарга сумын нутаг нь Халхын Сэцэн Хан аймгийн Хөвчийн жонон вангийн хошуу нь 1688 онд бий болсон гэж үзэж болох бөгөөд Хамаг Монголын Ханлиг Монголын Халиг-Чингисийн мэндэлсэн газар хэмээн түүхийн сурвалж бичгүүдэд тэмдэглэсээр ирсэн байдаг. Энэ хошуу нь Хэнтий, Онон, Хурх, Эг, Барх, Ужим, Жавхлант, Улз, Урт, Шуус зэрэг өргөн уудам нутгийн хамарч одоогийн Цэнхэрмандал, Баян-Адарга, Биндэр, Гурванбаян, Өмнөдэлгэр, Батширээт, Дадал, Норовлин, Төв аймгийн Мөнгөнморьт зэрэг сумуудад бүтнээр болон хагас багтаж байсан байна.

1923 онд Биндэръяа хан уулын хошуунд 1500 өрхтэй 10 сум буй болсны нэг нь Шуусын голын хөвөөний Баян-Өлзийт сум бөгөөд тэр нь одоогийн Баян-Адарга сум байгуулагджээ. Баян-Адарга сум нь баруунаараа Биндэр, зүүн хойгуураа Дадал, зүүнээрээ Норовлин, урдуураа Батноров сумтай хиллэн 302607.7 га талбай бүхий нутаг эзлэн оршино. Сумын төвийн өмнө байрлах Дуурлиг овоо нь Онон мөрний хөвөөнд далайн төвшнөөс дээш 1000 орчим метр өндөрт өргөгдсөн, Өндөрхаанаас хойш 154 км, Улаанбаатар хотоос 440 км зайтай байршина.

2020 статистикийн дүнгээр Баян-Адарга сум нь  нийт 2483 хүн, 771 өрхтэй байна. Нийт хүн амын 51,7 хувийг эрэгтэйчүүд, 48,3 хувийг эмэгтэйчүүд эзэлдэг байна. Сумын төвийн дэргэдэх Дуурлиг нарсанд том хэмжээний "хүннүгийн булш"-ийг илрүүлж судалгаа хийн улсын хамгаалалтад авсан. Сумын тахилгат уулсад  Адрагын овоо, Баян-Өлзийт, Авшиг овоо, Арангат овоо гэсэн гол тахилгат овоонууд багтдаг. Сумын нутаг дэвсгэр нь Хэнтийн нурууны зүүн зах, Эрээний нурууны баруун урд захын намхан уул толгодод байрлана. Сумын нутгийн зүүн хэсэгт орших 1437м өндөрт байрших Хөх чулуут уул нь сумын хамгийн өндөр уул бөгөөд хамгийн нам цэг нь тус сумаар 80 орчим км дайран өнгөрч байгаа Онон гол сумын нутгаас гарч буй хэсэгт далайн түвшнээс дээш 930 м орчим юм. Өнгөт төмөрлөг, жонш зэрэг баялагтай.

Онон голы цутгал Арангат, Шуус, Урт, Баруун булаг, Хүйтэн, Сайхан зэрэг гол горхи урсана. Сайн цагаан, Холбоо, Шийр-Улаан, Баян зэрэг нуруудтай. Гидрокарбонат – кальци- магнийн найрлагатай Арангатын рашаан бий.Тайгын ширэгт, Хар шороон, хар хүрэн, хүрэн хөрстэй, шинэст, нарс, хус, улиасан ойтой, мойл, улаалзгана, өрөл зэрэг жимсгэнэ элбэг. Уулын хээрийн бэлчээр хадлангийн ургамалтай. Нэн ховор амьтан Цэн тогоруу, ховор амьтадаас тоодог, буга, бусад амьтадаас дагуур зараа, гахай, шилүүс, чоно, үнэг, хярс, тарвага болон усны, нүүдлийн шувуудтай. Гол мөрнөөр нь тул, зэвэг, цагаан

хадар, амрын хадран, амрын цурхай, амрын сугас, улаан живэрт, морин загас, мөнгөлөг хэлтэг, булуу цагаан, цулбуурт гутаар зэрэг загас бий. Нутгийн хойд хэсэг Онон Балжийн байгалийн цогцолборт газарт багтана. Хувийн хэвшлийн 16 байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Сумын эдийн засгийн голлох салбар нь мал аж ахуй, газар тариалан, аялал жуулчлал, худалдаа үйлчилгээ юм. Сумын төвд ЗДТГ, бүрэн дунд сургууль, 15 ортой хүн эмнэлэг, Соёлын төв, Холбоо шуудангийн салбар, цаг уурын станц зэрэг төр төсвийн байгууллагууд, халуун ус, үсчин, шатахуун түгээх станц, эмийн сан, Хаан банк, болон зочид буудал, гурилын үйлдвэр, зэрэг худалдаа үйлчилгээний цэгүүд иргэддээ үйлчилж байна.

Сумын хэмжээгээр 2020 оны жилийн эцсийн малын тооллогоор нийт 189893 толгой мал байгаагаас 49.82 хувийг хонь, 31.8 хувийг ямаа, 8.9 хувийг үхэр, 9.23 хувийг адуу, 0.2 хувийг тэмээ тус тус эзэлж байна.

### *2.1.2. Сумын хилийн цэс*

Хэнтий аймгийн Баян-Адарга сум нь 1923 онд байгуулагдсан. 1977 оны 9-р сарын 30-нд Засгийн газрын 75-р тогтоолоор хилийн цэс нь батлагдсан. Сумын нутаг дэвсгэрийн хил хязгаарт 2012 онд ГХГЗЗГ-аас хийгдсэн “Улсын аймаг, сумдын хилийн цэсийн өөрчлөлт”-ийн ажлаар өөрчлөлт хийсэн тоон мэдээллийг Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газраас зохих журмын дагуу авч ашиглалаа. Энэхүү сумын хилийг зураглаж нэгтгэсэн мэдээллээр тус сумын нийт газар нутгийн талбай 302607.7 га байгаа ба нийт 37 хилийн эргэлтийн цэгээс бүрдэж байна.

*Хүснэгт 1. Сумын хилийн цэс*

| Эргэлтийн дугаар | Уртраг | Өргөрөг | Газрын нэр |
|---|---|---|---|
| 1 | 110°57'54.9" | 48°51'14.4" | Даянчийн даваагы адаг, Хөтөлжийн голын урд эргээр уруудаж |
| 2 | 111°04'56.2" | 48°52'32.9" | Нарийн хадтай |
| 3 | 111°09'46.2" | 48°50'55.7" | 1298.2 тоот |
| 4 | 111°13'05.3" | 48°45'48.9" | Долиогийн толгой |
| 5 | 111°15'02.5" | 48°41'49.2" | Цацын толгой, Онон голын урд эргээр уруудаж |
| 6 | 111°33'40.1" | 48°46'27.5" | Бэрхийн булан |
| 7 | 111°33'49.3" | 48°44'39.2" | 1188.6 тоот |
| 8 | 111°33'19.4" | 48°39'15.0" | Ханхат булаг |
| 9 | 111°32'47.7" | 48°35'02.4" | Шанаган булаг |
| 10 | 111°38'42.3" | 48°30'43.1" | Хялаацай |
| 11 | 111°40'29.1" | 48°28'48.3" | Хараат /1311.6 тоот/ |
| 12 | 111°37'37.3" | 48°26'45.4" | 1214.9 тоот |
| 13 | 111°32'19.1" | 48°22'52.8" | Сүүл өндөр /1444.8 тоот/ |
| 14 | 111°28'35.2" | 48°19'50.2" | 1399.6 тоот |
| 15 | 111°23'34.3" | 48°14'52.7" | Бор хоолойн даваа |
| 16 | 111°17'00.8" | 48°15'13.4" | Их өтөг /1424.8 тоот/ |
| 17 | 111°12'19.0" | 48°12'16.6" | Их модот /1460.7 тоот/ |
| 18 | 111°08'18.4" | 48°09'42.7" | 1233.7 тоот |
| 19 | 111°05'57.5" | 48°07'58.9" | 1362.7 тоот |

| | | | |
|---|---|---|---|
| 20 | 111°00'45.3" | 48°06'43.5" | Хөх чулуу /1356.8 тоот/ |
| 21 | 110°59'40.7" | 48°08'24.4" | 1272.6 тоот |
| 22 | 110°56'37.1" | 48°11'33.6" | 1236.3 тоот |
| 23 | 110°56'11.4" | 48°13'34.5" | Улаан нуурын гозгор /1256.3 тоот/ |
| 24 | 110°55'09.5" | 48°17'51.4" | Баруун өлзийт /хулст толгой/ |
| 25 | 110°52'42.7" | 48°21'32.1" | Доод өлийн даваа |
| 26 | 110°47'56.6" | 48°25'29.6" | Өвдөгийн булаг |
| 27 | 110°47'55.8" | 48°26'59.5" | 1338.1 тоот |
| 28 | 110°49'48.4" | 48°30'12.8" | Жинст даваа |
| 29 | 110°50'56.0" | 48°31'25.4" | Улиастай /1289.0 тоот/ |
| 30 | 110°50'56.8" | 48°33'53.7" | Элст даваа |
| 31 | 110°50'57.3" | 48°34'28.1" | Баян голын хавцал /1122.9 тоот/ |
| 32 | 110°54'57.6" | 48°35'25.4" | Тунгалагуудын адаг |
| 33 | 110°56'48.9" | 48°38'05.3" | Замын улаан өндөр |
| 34 | 110°59'52.1" | 48°42'33.3" | Хөх хавцал /1277.8 тоот/ |
| 35 | 111°01'48.2" | 48°43'16.1" | Харгиас нуур |
| 36 | 111°01'52.5" | 48°45'13.7" | 1145.1 тоот |
| 37 | 111°00'18.4" | 48°48'59.6" | Далхын толгой |




*Зураг 2. Сумын хилийн цэс*

### 2.1.3. Багийн хилийн зааг

Хэнтий аймгийн Баян-Адарга сум нь Хэнтийн нурууны зүүн салбар уулсын өвөр, ойт хээрийн бүсийн заагт, Онон голын сав газрын дунд, нийслэл Улаанбаатар хотоос 430 км, аймгийн төв Өндөрхаан хотоос 160 км-ийн зайтай оршдог.

Засаг захиргааны нэгжийн хувьд зүүн урд хэсэгт 1-р баг буюу Сайхан, баруун урд хэсэгт 2-р баг буюу Жаргалант баг, сумын хойд хэсэгт 3-р баг буюу Адарга баг байрладаг. Сумын төв Дуурлиг нь нутгийн төв хэсэгт хамгийн бага нутгийг хамран байрлана.

*Хүснэгт 2. Багуудын газрын хэмжээ, эзлэх хувь*

| № | Багийн нэр | Талбай, га | Эзлэх хувь |
|---|---|---|---|
| 1 | Сайхан | 113621.7 | 37.5 |
| 2 | Жаргалант | 72971.1 | 24.1 |
| 3 | Дуурлиг | 14329.5 | 4.7 |
| 4 | Адарга | 101685.4 | 33.6 |
| **Нийт** | | **302607.7** | **100** |

Багуудын газар нутгийг авч үзвэл Сайхан баг хамгийн их 133621.7 га газар буюу нийт сумын нутаг дэвсгэрийн 37.5 хувийг эзэлж байна. Жаргалант баг нь 72971.1 га газар буюу нийт нутаг дэвсгэрийн 24.1 хувийг, Адарга баг 101685.4 га газар буюу нийт газар нутгийн 33.6 хувийг эзэлж байна. Харин хамгийн бага газрыг сумын төв буюу Дуурлиг баг 14329.5 га газар буюу нийт нутаг дэвсгэрийн 4.7 хувийг тус тус эзэлж байна.




*Диаграмм 1. Багуудын газар нутгийн хэмжээ /хувиар/*




*Зураг 3. Багийн зааг*

## 2.2. Хөгжлийн чиг хандлага, Бодлого хөтөлбөрүүд

### *2.2.1. Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал*

Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг Их Хурлын 2001 оны 57 дугаар тогтоолын хавсралтаар баталжээ. "Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал"-д Монгол Улсыг бүсчлэн хөгжүүлэх /цаашид "бүсчилсэн хөгжил" гэх/ арга замыг боловсруулж, бүсчлэлээр дамжуулан нутаг дэвсгэрийн хөгжлийн тэнцвэрийг хангах төрийн байгуулалт, эдийн засаг, нийгэм соёл, хүн амын нутагшилт, хот байгуулалт, гадаад хамтын ажиллагааны таатай орчныг бүрдүүлэх, эдийн засгийн бүсүүдийн хүрээнд бүс нутаг-хот байгуулалтын уялдааг хангах замаар аймаг, орон нутгийн хөгжлийг дэмжих төрийн бодлого, зохицуулалтын тогтолцоог бий болгох чиглэл, үйл ажиллагааны зарчмын үндсийг тодорхойлсон билээ. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын зорилго, зорилтыг эдийн засгийн бүс, бүс нутаг, хот-хөдөөгийн хөгжлийн нэгдмэл тогтолцооны хүрээнд хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага нь Монгол Улсын тогтвортой хөгжлийн стратегиас урган гарсан байдаг. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын зорилгыг хэрэгжүүлэхийн тулд улсын хэмжээнд, эдийн засгийн бүс, бүс нутаг, хот-хөдөөгийн хөгжлийн харилцан уялдсан нэгдмэл тогтолцоо, эдийн засгийн бүсүүдийн хэмжээнд, бүс нутаг, хот-хөдөөгийн хөгжлийн харьцангуй бие даасан тогтолцоог бүрдүүлэх үйл явцыг төрөөс нэгдсэн, нутаг дэвсгэрийн ялгавартай бодлогоор дэмжин зохицуулахаар тусгасан байдаг. 2001 онд Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг баталснаас хойш улсын эдийн засаг, нийгэм, байгаль орчны төлөв байдалд ихээхэн өөрчлөлт гарснаас гадна хөрш орнууд болон гадаад эдийн засгийн орчин нөхцөл ихээхэн өөрчлөгдөж байна. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай Монгол Улсын хууль батлагдаж, энэ дагуу Монгол Улсын Тогтвортой хөгжлийн 2030 он хүртэлх үзэл баримтлалыг боловсруулан хэрэгжүүлэх эрх зүйн орчин баталгаажсан байна.

### *2.2.2. “Алсын Хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого*

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг Монгол Улсын Их хурлын 2020 оны 5-р сарын 13 ний өдрийн 52 дугаар тогтоолоор баталсан. Алсын хараа 2050 урт хугацааны хөгжлийн бодлого нь үндэсний дахин давтагдашгүй онцлогт суурилсан, дэлхийн дэвшилтэт үзэл санаатай хослуулсан Монгол Улсын хөгжлийн загвар юм. “Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлого буюу Монгол хөгжлийн загвар биеллээ олох суурь нөхцөл нь Монгол хүн байна гэж онцолжээ.

Бодлогын баримт бичиг нь 9 зорилго, 47 зорилттой бөгөөд 2020-2030 он, 2031-2040 он, 2041-2050 он гэсэн гурван 10 жилээр үе шаттайгаар хэрэгжүүлэхээр заажээ. Засгийн газар энэхүү төлөвлөгөөтэй уялдуулан Монгол улсыг 2020-2025 онд хөгжүүлэх 5 жилийн

үндсэн чиглэлийг баталсан. 5 жилийн үндсэн чиглэлийн дагуу аймаг үндсэн чиглэлээ баталж хэрэгжүүлж байна.

### 2.2.3. *Хэнтий аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл*

Хэнтий аймгийг 2020-2025 хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг Үндэсний нэгдмэл үнэт зүйл, Хүний хөгжил, Амьдралын чанар ба дундаж давхарга, Эдийн засаг, Ногоон хөгжил, Дэд бүтцийн хөгжил, Засаглалын бодлого, Амар тайван, аюулгүй нийгэм болон Бүс орон нутгийн хөгжил гэсэн 8 зорилгын хүрээнд 30 зорилт, 93 арга хэмжээтэй боловсруулжээ. Уг бодлогын баримт бичиг нь Алсын хараа 2050, Монгол улсын 2020-2025 хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлтэй нийцүүлэн гаргасан баримт бичиг болно. Хэнтий аймгийн 2020-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлээс газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд холбогдох үйл ажиллагааг уялдуулан тусгалаа. Үүнд:

- ✓ Хот суурины үерийн далан суваг, борооны болон хөрсний ус зайлуулах шугам сүлжээний ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
- ✓ Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулалтын түшинг өсгөж, малын гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрүүдийг барьж, экспортыг нэмэгдүүлнэ
- ✓ Аймгийн онцлог бүхий аялал жуулчлалыг хөгжүүлж, аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн бий болгох замаар олон улсын аялал жуулчлалын зах зээлээс жуулчид татаж, зорин ирэх жуулчдын тоог өсгөнө.
- ✓ Эдийн засгийн хөгжлийг дэмжсэн эрчим хүч, инженерийн дэд бүтцийг нэмэгдүүлнэ
- ✓ Жоншны баяжмал, шууд ангижруулсан төмрийн үйлдвэрийн бүтээн байгуулалтыг эхлүүлж, ашиглалтад оруулах, түүнд шаардлагатай дэд бүтэц болох авто зам, ус, эрчим хүчний төслүүдийг Бор-Өндөр, Дархан сум, Бэрх тосгоныг түшиглэж хэрэгжүүлнэ.
- ✓ Цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг барьж, цахилгаан эрчим хүчний хангалтыг өсгөнө.
- ✓ Зүүн бүсийн логистикийн төвийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр байгуулна,
- ✓ Улаанбаатар-аймаг-сум хоорондын нислэгийн чиглэл, тоог нэмэгдүүлнэ
- ✓ Түүхэн аялал жуулчлалын бус нутгийн сумд руу авто зам барина
- ✓ Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөж, цэнгэг усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийг улсын тусгай хамгаалалтад авах ажлыг эрчимжүүлнэ.
- ✓ Хөрсний үржил шим, чийгийг хамгаалж, газрын доройтол, хэрсний бохирдол, цөлжилтөөс сэргийлэн, эвдрэлд орсон, доройтсон газрыг нөхөн сэргээж, аж ахуйн эргэлтэд оруулна

- ✓ Нэн ховор, ховор амьтан, ургамлын нөөц, ховордсон зүйлийг хамгаалж, нөхөн сэргээж, ашиглалтад өртөмтгий амьтан, ургамлыг зориудаар үржүүлэн тарималжуулж ашиглалтын нөөц бий болгоно.
- ✓ Ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг нэмэгдүүлнэ.
- ✓ Усан сан бүхий газрын хамгаалалтын бус, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийн хэрэгжилтийг сайжруулж, усны бохирдол, хомсдолыг бууруулна.
- ✓ Газрын байгалийн тогтоц, голын татамд хур тунадас, хайлсан цас, мөсний усыг хуримтлуулах хөв цөөрөм, далд усан сангууд байгуулна.
- ✓ Аймгийн болон сумын төвүүдийн хог хаягдлын асуудлыг шийдэж, хог дахин боловсруулах үйлдвэрийг барьж эхлүүлнэ.
- ✓ Байгаль орчинд ээлтэй, эрэлтэд нийцсэн, тогтвортой, хүртээмжтэй, аюулгүй тээврийн үйлчилгээг хөгжүүлж, авто замын сүлжээг өргөтгөнө.
- ✓ Орон нутгийн нисэх буудлын хучин чадлыг сайжруулж, уйл ажиллагааг өргөжүүлж, агаарын тээврийн үйлчилгээг жигдрүүлнэ.
- ✓ Аялал жуулчлал, хөдөө аж ахуй, үйлдвэрлэл төвлөрсөн зарим сумдын төвүүдэд чиглэсэн хөрөнгө хэмжээг нэмэгдүүлж давуу талд тулгуурлан бүсчилж хөгжүүлнэ.
- ✓ Шилэн кабелийн сүлжээг өргөтгөж, интернэт, lPTV хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлнэ.
- ✓ “Мянганы суут хүн Чингис хаан цогцолбор” байгуулж, Монголын нууц товчооны дурсгалт газруудыг хамгаалах, олон улсад сурталчлан таниулах, дэд бүтцээр /автозам, эрчим хуч, инженерийн шугам сүлжээ/ холбох ажлуудыг үе шаттай зохион байгуулж, түүхэн аялал жуулчлалыг хөгжүүлнэ.
- ✓ Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төслийг Хэнтий аймагт хэрэгжүүлж, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын орлогыг нэмэгдүүлнэ.
- ✓ Орон нутгийн онцлогт тохируулан аялагч, амрагч, жуулчдыг татах төрөлжсөн аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг шинээр бий болгож, хөгшүүлнэ.
- ✓ Бэлчээрийг усжуулах, худагжуулах ажлыг үргэлжлүүлэн малын бэлчээрийн нөөцийг нэмэгдүүлж, тогтвортой байдлыг хангана.
- ✓ Малын чанар, ашиг шим, үүлдэр угсааг сайжруулж, малын тоог чанарт шилжүүлж, малын генийн санг хамгаалж, биотехнологийн ололтыг нэвтрүүлэх замаар эрчимжсэн мал аж ахуйн салбарыг идэвхжүүлнэ.
- ✓ Тариалангийн нийт эргэлтийн талбайн ашиглалтыг сайжруулж, голлох нэр төрлийн таримлаар дотоодын хэрэгцээг хангаж, бусад ашигт таримлын үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.

- ✓ Мал, малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэр байгуулж, ажлын байрыг нэмэгдүүлж, малчдын орлогыг өсгөж, хөдөө аж ахуйн гаралтай бараа, бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ.
- ✓ Усалгаатай тариалангийн талбайг нэмэгдүүлэх замаар тэжээл, төмс, хүнсний ногооны тариалангийн үйлдвэрлэлийг өсгөнө.

### *2.2.4. Хэнтий аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр*

Хэнтий аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны “Хэтийн Хэнтий 2024” хөтөлбөр нь Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл болон Засгийн газрын уйл ажиллагааны хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэхэд чиглэсэн иргэний нийгмийн байгууллага, иргэд, олон нийтийн саналуудад үндэслэн боловсруулсан.

Аймгийн Засаг дарга 2020-2024 оны уйл ажиллагааны хөтөлбөрөө боловсруулахдаа халдварт цар тахлын хүндрэлийг амжилттай даван туулах хүн, эдийн засаг, нийгмийн хөгжлийг хангах, байгаль орчны тэнцвэртэй байдал, засаглалыг сайжруулах, орон нутгийг хөгжүүлэх, бодлогын залгамж чанарыг хадгалахад онцгой анхаарч, дараах зургаан багц асуудлын хүрээнд хэрэгжүүлэх зорилго, зорилтуудаа дэвшүүллээ.

“Хэтийн Хэнтий 2024” хөтөлбөр нь ковид-19” халдварт цар тахлын хүндрэлийг даван туулах арга хэмжээ, хүний хөгжил, эдийн засаг, засаглал, ногоон хөгжил, аймгийн төв, сум тосгодын хөгжил гэсэн 6 бүлэг, 23 зорилгын хүрээнд, 142 арга хэмжээг тусгасан байна.

Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэхээр тусгасан үйл ажиллагааг тоймлон аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгахаар байна. Үүнд:

- ✓ Бэрх хотод олон улсын хөтөлбөртэй ерөнхий боловсролын сургалтын чанарын стандартыг дэлхийн жишигт нийцүүлэх зүүн бүсийн аймгуудын төв сургууль байгуулна.
- ✓ Аймгийн нутаг дэвсгэрт шинээр уул уурхайн лиценз нэмж олголгүй, хяналт мэдээллийг олон нийтэд ил тод болгож хууль бус зөвшөөрлийг хүчингүй болгуулна
- ✓ Жоншны баяжмал, шууд ангижруулсан төмрийн үйлдвэрийн төслүүдийг хэрэгжүүлнэ.
- ✓ Тариалангийн талбайн ашиглалтыг сайжруулан эргэлтэд оруулж, хөрсний үржил шимийг хамгаалах, хашаажуулах, сэлгээнд үр тарианы тариалалтыг нэмэгдүүлэх замаар тариалангийн тогтвортой хөгжлийг хангана.

✓ Төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлийг механикжуулж, усалгаатай тариалангийн талбайг нэмэгдүүлэн, хүлэмж, зоорины аж ахуйн хангамжийг сайжруулна.

✓ Малын тоог чанарт шилжүүлэх ашиг шимийг нэмэгдүүлэх, эрчимжсэн мал аж ахуйг дэмжиж, ”Монгол мал-II” арга хэмжээг хэрэгжүүлнэ.

✓ Бэлчээр хамгаалалт, ашиглалтыг сайжруулан, өвс тэжээлийн нөөц бүрдүүлэлт, усан хангамжийг нэмэгдүүлнэ.

✓ Түүхэн аялал жуулчлалыг хөгжүүлэх маршрутын дагуух сумдад байгаль орчинд ээлтэй, нутгийн иргэд /өрх/-ийг түшиглэсэн тогтвортой, эко аялал жуулчлалын үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн тоог 10 хувиар нэмэгдүүлнэ.

✓ Түүхэн аялал жуулчлалыг хөгжүүлэх ажлын хүрээнд “Мянганы суут хүн Чингис хаан” цогцолборуудын ажлыг /Дадал сум “Чингис хаан”, Биндэр сум “Их Хуралдай”, Батноров сум ”Хүлэг Боорчи-Андлалын өргөө”, Норовлин сум ”Шихихутаг Их засаг” Бэрх тосгон “ Монголын далд уурхайн музей, сургалт, судалгаа, аялал жуулчлалын төв” , Дэлгэрхаан сум “Монголын нууц товчоо”/ дуусгаж дэд бүтцээр холбох ажлыг эхлүүлнэ.

✓ Түүхэн аялал жуулчлалыг хөгжүүлэх маршрутын дагуу түр буудаллах цэг, мэдээлэл, үйлчилгээний төвийг байгуулж, эдийн засгийн эргэлтэд оруулна.

✓ Түүх, соёлын өв, байгалийн дурсгалт болон өвөрмөц тогтоц бүхий газруудад орон нутгийн онцлогт тохируулан аялагч, амрагч, жуулчдыг татах төрөлжсөн аялал жуулчлалын бүтээгдэхүүн /морин аялал, завь, агнуур, дугуйн, цанын, уулын спорт г.м/-ийг бий болгож хөгжүүлнэ.

✓ Аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинээр батлуулан мөрдүүлж, хүрээлэн буй орчинд ээлтэй суурьшлын болон үйлдвэрлэлийн бүсчлэлийг тогтоон хөгжүүлнэ.

✓ Чингис хотын ус хангамжийн эх үүсвэрийг нэмэгдүүлж барилга, байгууламж, тоног төхөөрөмжийг шинэчлэн өргөтгөх, шинээр худаг гаргах замаар баталгаат ундны усны тоог нэмэгдүүлнэ.

✓ Чингис хотын үерийн байгууламжийг ашиглалтад оруулж, хот доторх ус зайлуулах системийг бий болгоно.

✓ Шилэн кабелийн сүлжээг өргөтгөж, хурдыг сайжруулна.

✓ Дулааны станцыг ашиглалтад оруулна.

✓ Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр болох нар, салхины сэргээгдэх эрчим хүчний хэрэглээ ашиглалтыг нэмэгдүүлнэ.

✓ Шаардлагатай багийн төвүүд болон шинээр олгогдсон өмчлөлийн газруудад 04 кВ-н цахилгааны шугам тавина.

✓ Хэрлэн гол болон бусад голуудад шаардлагатай гүүрийг шинээр барьж, сэргээн засварлана.

✓ Аялал жуулчлалыг хөгжүүлэх маршрут бүхий сумдад нисэх буудлын зориулалтай газрын нөөцийг тогтоож, Чингис хот-Дадал сум-Чингис хот, Чингис хот-Улаанбаатар хот-Чингис хот чиглэлд тогтмол нислэгтэй болгоно.

✓ Хогны менежментийг үр дүнтэй хэрэгжүүлж, хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах ажлыг иргэд, аж ахуйн нэгжүүдийн дунд хэвшүүлж, дахин боловсруулах боломжтой хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах замаар төвлөрсөн хогийн цэгт очих хог хаягдлын хэмжээг 40 хүртэл хувиар бууруулна

✓ Төв суурин газрын ногоон байгууламжийн эзлэх талбайн хэмжээг жил бур нэмэгдүүлж, нийт 65 га-д хүргэнэ.

✓ Аймгийн хэмжээнд 1000 га талбайд ойжуулалт, байгалийн сэргэн ургалтад туслах ажлыг хийж, нийт ойн сангийн ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг 0.05 хувиар нэмэгдүүлнэ.

✓ Цэнгэг усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эх, түүний ай сав газар. ховор ан амьтан ургамлын тархац нөөц бүхий байгалийн унаган төрхийг хадгалж хамгаалах, эко системийн ач холбогдол бүхий газруудыг улсын болон аймаг, орон нутгийн тусгай хамгаалалтад авах ажлыг зохион байгуулж нийт нутаг дэвсгэрийн 47 хувьд хүргэнэ.

✓ Амьтны нөөцийг хамгаалах, өсгөж үржүүлэх, зохистой ашиглах менежмент зохион байгуулалтыг хийж, ховор амьтдын тоо толгойг 3 хүртэл хувиар өсгөнө.

✓ Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийн хэрэгжилтийг хангаж, 80-аас доошгүй булаг, шандын эхийг хашиж хамгаална.

✓ Элэгдэл, эвдрэлд орж эзэнгүй орхигдсон газар, түүний хэвлийд техникийн нөхөн сэргээлтийг 80 га газарт хийнэ.

✓ Хэрлэн суманд хэрэгжиж байгаа гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслийг дуусгана.

✓ Сумдын ундны усны эх үүсвэрийг нэмэгдүүлж, худгуудыг төвлөрсөн цэвэр усанд холбож, ухаалаг систем суурилуулна

✓ Сумын төвийн гэр хорооллын инженерийн болон ариутгах татуургын шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж, сум доторх зам, төмөр бетон гүүр, модон гүүрийг шинэчлэх, засварлах ажлыг гүйцэтгэнэ.

### *2.2.5. Баян-Адарга Сумын Засаг Даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр*

Баян-Адарга сумын Засаг даргын 2021- 2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт 5 бүлэг, 14 зорилго, 85 арга хэмжээг тусгасан байна.

Сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулахдаа халдварт цар тахлын хүндрэлийг амжилттай даван туулах, хүн, эрүүл мэнд, эдийн засаг, засаглалыг сайжруулах, орон нутгийг хөгжүүлэх ногоон хөгжил, сум, багийн хөгжил гэсэн дараах 5 багц асуудлын хүрээнд хэрэгжүүлэх зорилго, зорилтуудыг дэвшүүлсэн байна.

**НЭГ. КОВИД-19 ХАЛДВАРТ ЦАР ТАХЛЫН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ**

- Ковид- 19 болон халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, сургалт сурталчилгаа, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хариу арга хэмжээний бэлэн байдлыг 92%-д хүргэнэ.

**ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖИЛ**

- Эрүүл мэндийн салбар

*Зорилго: Өвчнөөс урьдчилан сэргийлэх хянах, эмчлэх арга хэмжээг эрчимжүүлэн, эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд цахим системийг нэвтрүүлэн чанар хүртээмжийг сайжруулж хамрагдалтыг нэмэгдүүлнэ.*

- Биеийн тамир, спортын салбар

*Зорилго: Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл идэвхитэй амьдрах дадал олгох нийтийн биеийн тамирыг хөгжүүлж, спортын салбарт амжилт гаргаж, уралдаан тэмцээнд амжилттай оролцсон баг тамирчдыг дэмжинэ.*

- Боловсролын салбар

*Зорилго: Хүн бүрийн сурах таатай орчинг бүрдүүлж, сургалтын чанарыг дээшлүүлнэ.*

- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбар

*Зорилго: Нийгмийн хамгааллыг оновчтой хүртээж, хүн амын хөгжлийг ханган хөдөлмөр эрхлэлтийн түвшинг нэмэгдүүлнэ*

- Соёл, урлагийн салбар

*Зорилго: Соён гэгээрүүлэх үйл ажиллагааг идэвхжүүлж, үндэсний агуулгатай соёлын бүтээлийг дэмжин соёл, урлагийн байгууллагын өрсөлдөх чадвар, нийгмийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.*

**ГУРАВ: ЭДИЙН ЗАСАГ**

- Санхүү, төсвийн хариуцлага

*Зорилго: Татварын суурийг нэмэгдүүлэх, төсөв, санхүүгийн цахим систем нэвтрүүлэн ил тод байдлыг хангаж, эх орончи худалдан авалтыг дэмжин, орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулна.*

❖ Хариуцлагатай уул уурхай

*Зорилго: Уул уурхайн үйл ажиллагаа, хяналтыг олон нийтэд ил болгож, хариуцлагатай уул уурхайг бий болгоно.*

❖ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр салбар

*Зорилго: Атарын "4"-р аяныг хэрэгжүүлэн улаан буудайн ургацын хэмжээг нэмэгдүүлж,эрчимжсэн мал аж ахуй болон зоорийн аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих замаар хүнс,төмс хүнсний ногооны хангамж,бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.*

❖ Түүхэн аялал жуулчлал хөгжил

*Зорилго: “Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл-I”-ийн хүрээнд Түүхэн аялал жуулчлал, үндэсний онцлог шингэсэн арга хэмжээнүүдийг сурталчилна.*

❖ Дэд бүтцийн салбар

*Зорилго: Газар зохион байгуулалтын төлөвлөлтийг сайжруулж, хөдөлгөөнт интернэт холбоо, цахилгаан, дулаан хангамжийн чанар хүртээмжийг сайжруулж, авто зам, гүүр ашиглалтыг нэмэгдүүлнэ.*

## ДӨРӨВ.ЗАСАГЛАЛ

❖ “Цахим Хэнтий” төрийн шуурхай үйлчилгээ

*Зорилго: Төрийн байгууллагад дотоод удирдлагын нэгдсэн систем* www.erp.e-mongolia.mn *болон иргэн, хуулийн этгээдэд төрийн үйлчилгээ мэдээлэл, лавлагааг шуурхай, чирэгдэлгүй хүргэх “emongolia” системийг үе шаттайгаар нэвтрүүлж, ил тод байдлыг нэмэгдүүлнэ.*

❖ Мэргэшсэн, хариуцлагатай төрийн алба

*Зорилго: Авилгатай тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлэн, төрийн үйлчилгээний чанар, төрийн албан хаагчийн мэдлэг, чадварыг сайжруулан, сахилга, хариуцлагыг чангатгана.*

❖ Амар тайван, орон нутгийн хамгаалалт

*Зорилго: Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх төр хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан хэрэгжүүлж нийт гэмт хэргийг 5 хувь, иргэдийн өмчийн эсрэг хулгайн гэмт хэргийг 15 хувиар бууруулан, гамшигтай тэмцэх чадавхыг нэмэгдүүлж, орон нутгийн хамгаалалтыг сайжруулна*

## ТАВ. НОГООН ХӨГЖИЛ

❖ Цэвэр орчин-ногоон бүс

*Зорилго: Байгаль орчныг хамгаалах, орчны бохирдол, доройтлыг бууруулж нөхөн сэргээнэ.*

**ЗУРГАА. СУМ, БАГИЙН ХӨГЖИЛ**

- ❖ Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны үр дүнг үнэлж дүгнэх, ил тод байдлыг сайжруулахад иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлнэ.
- ❖ Орон сууцны жишиг барилга барих, санал санаачилгыг дэмжинэ.
- ❖ Төрийн байгууллагуудын барилга, өргөтгөл, засвар, нийтийн эзэмшлийн талбай засварын ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.

## 2.3. Сумын газар зүйн тогтоц, онцлог

Энэхүү газрын гадаргын өндөржилтийн мэдээллийн Ландсат-8 хиймэл дагуулын 2013 онд Газрын харилцаа, геодези зураг зүйн газраас /хуучин нэрээр/ боловсруулсан 30 метрийн өндөржилттэй тоон мэдээллийг зохих журмын дагуу авч газрын гадаргын өндөржилт, налуужилт, зүг зовхисийг боловсруулж гаргалаа.

### *2.3.1. Сумын физик газар зүйн тогтоц, онцлог*

Баян-Адарга сумын газарзүйн тогтоц, онцлогийг Монгол орны физик газарзүйн мужлалыг үндэслэн харууллаа. Физик газарзүйн мужлал бол газар орныг байгалийн бүхий л нөхцөл буюу геологийн бүтэц, хотгор гүдгэр, уур амьсгал, ус зүй, хөрс, ургамалшил, амьтны аймгийн хам бүрдлийн талаар өөр хоорондоо тодорхой ялгаатай хэсгүүдэд хуваах явдал юм.

Монгол орны физик газарзүйн мужлал нь 4 их мужид хуваагддаг. Үүнд:

1. Хангай-Хэнтийн уулархаг их муж;
2. Алтайн уулархаг их муж;
3. Монголын Дорнод талын их муж;
4. Говийн их мужууд ордог;

Баян-Адарга сум нь физик газарзүйн мужлалаар Хангай-Хэнтийн уулархаг их мужид багтах бөгөөд Хэнтийн мужийн Хэнтийн нуруу ба түүний салбарууд тойрогт хамрагдана.

*Хангай- Хэнтийн уулархаг их муж* нь Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулсыг хамран Монгол орны хойд хагасыг эзэлж, ойт хээрийн бүс, түүн дотроо босоо бүслүүрүүдийг голчлон багтааж оршино. Тус мужийн хил баруун хойд талд улсын хилийн орчмоос эхэлж Тэсийн голыг хөндлөн огтлон түүний хөндийн урд биеийг барин баруун тийш чиглээд Хан Хөхийн нурууг ороож түүний урд биеэр зүүн тийшилнэ. Уг нурууны зүүн захаас зүүн урагш эргэж Улиастай хотын баруун талаар ороод Завхан, Түйн голын эхийг хөндлөн огтолж, Хангайн гол нурууны урд бэлээр гарна. Орхон голын эх хавиас зүүн хойшоо

чиглэж Зуун мод хотын урдуур өнгөрөн Хэрлэн голын их тохойн хойхнуур Баян-Улааны өврөөр гараад Өндөрхааны урдуур савлана. Тэндээс Идэрмэг сумын зүүн талаар Хэрлэн огтлон зүүн хойшоо эргээд Улз, Дөч голын бэлчээрээс баруун талаар гарч улсын хилд тулд очно.

Тус их мужийг бүрдүүлэгч уулт тогтолцоонууд ихэнхдээ урагш тохойрсон нэгдэх эгнээ уулст хамаарч гол нуруунд нь баруун талдаа баруун хойноос зүүн урагшаа, зүүн талдаа баруун урдаас зүүн хойшоо сунаж тогтсон байна.

Хангай, Хэнтийн уулт өндөрлөгт бэсрэг уулс голлож гол нуруудаар өндөр уулын хотгор гүдгэр харьцангуй бага газрыг хамарч оршино. Уулс хавтгай буюу бөмбөгөр оройтой, ихэвчлэн налуувтар мөлгөр хажуутай юм. Уул нурууд бүл цүл хөдөлгөөнөөр үүссэн том том ховдол гүвдлийн шинжтэй бөгөөд заримын захаар ихээхэн хэмжээний мөргөцөг тодорхой үзэгдэнэ.

*Хэнтийн муж* нь Монгол орны зүүн хойд захад оршино. Хил заагийн хувь тодорхой бус боловч баруун тал нь Туул, Орхон голын хөндий, хойд талд улсын хил, зүүн хэсэгтээ Онон голын зүүн талаас Хэрлэнгийн дунд бие хүртэл татаж болох шугам, өмнөд талынх нь Хэрлэнгийн хөндий ба Хэрлэнгийн урд тохойгоос Туулын урт тохой хүртэлх шугамаар тус тус зааглагдсан байна. Хэнтийн муж Төв, Сэлэнгэ, Хэнтий болон Чойбалсан аймгуудын нутаг дээр оршдог бөгөөд түүний баруун өмнө үзүүрт Туулын голын эрэг дээр Улаанбаатар хот оршдог. Хэнтийн муж нь ландшафтын талаар Байгал нуурын зүүн талын тайгат нутгаас Төв Азийн говь хээрийн нутаг руу шилжин орох завсрын нутаг юм. Хэнтийн муж өмнө ба зүүн талаараа аажмаар намсаж цав толгодод шилждэг ч гэсэн нийтдээ уулархаг ба өндрийн хэлбэлзэл 2751 метр /Асралт-Хайрхан уул/- аас 600 метр /Ерөө голын адаг/- ийн хооронд байна. Хэнтийн уулс дахь хамгийн өндөр оргил Асралт Хайрханаас гадна, Алтай-Өлгий /2600 метр/, Гүнт сарьдаг, Хийлийн сарьдаг /2589 метр/ уулууд Бага Хэнтийн нуруунд хамаарна.

*Хэнтий нуруу ба түүний гол салбарууд* тойрогт Хэнтийн гол нуруу, Бага Хэнтий, Их Хэнтийн нуруу тэдгээрийн томоохон салбаруудыг багтаана. Энэ тойргийн хилийн тоймлон заавал: Зүүн талд Барах голын алаг орчмоор гарч өмнө хэсэгтээ Хурах, Туул голыг дагасан тектоникийн гаралтай хөндийнүүд болон Улаанбаатар хотоос нэлээн хойгуур гарах ба баруун талдаа Хараа голын баруун гарын цутгалуудыг огтлон гарсан шугам, хойд талын улсын хил болно. Үнэмлэхүй өндөр нь 2000-2500 метр бөгөөд хамгийн өндөр цэг нь Асралт Хайрхан юм.

### ***2.3.2. Газрын гадарга өндөржилт***

Гадаргуу нь хотгор, гүдгэрээр нь тус бүсийн нутаг дэвсгэрийг Хэнтийн уулархаг бүс, Их Хянганы салбар уулсын бүс, ухаа гүвээт, толгодлог талын бүс гэж гурав ангилж

үздэг байна. Энэ бүсэд Их Хэнтийн нурууны зүүн хэсэг, түүний салбар уулс хамрагдах ба өндөрлөг нь далайн түвшнээс дээш 1100-1500м-ийн өндрийн хооронд хэлбэлзэх бөгөөд ихэнхдээ уулархаг, баруунаас зүүн тийш чиглэж тогтсон хавтгай оройтой ба гол уул нуруудад нь мөстлөгийн ул мөр элбэг тохиолдоно. Сибирийн ой тайгын өмнөд сэжүүрт буюу Хэнтийн нурууны зүүн салбар уулсын өвөр, ой хээрийн бүсийн заагт, Онон голын сав газрын дунд хэсэгт оршино.

Сумын нутаг дэвсгэр физик, газарзүйн хуваарилалтаар бүхэлдээ тал хээрийн бүсэд хамрагдах ба нутгийн ихэнх хэсгийг бөмбөгөр оройтой бэсрэг уулс, тэдгээрийн хоорондох хөндийнүүд эзэлнэ. Баян-Адарга сумын газрын гадаргын өндөржилтийг 4 хэсэгт 100 метрийн интервалаар хувааж дараах хүснэгтэд үзүүлэв.

*Хүснэгт 3. Сумын гадаргын өндөржилтийн талбай*

| № | Өндөржилт | Талбай, га | Эзлэх хувь |
|---|---|---|---|
| 1 | 900–1000 метр | 17941.1 | 5.9 |
| 2 | 1000–1200 метр | 227599.5 | 75.2 |
| 3 | 1200-1400 метр | 56923.7 | 18.8 |
| 4 | 1400 метрээс дээш | 72.2 | 0.02 |
| **Нийт** | | **302607.6** | **100** |

Сумын нутаг дэвсгэр нь дунджаар далайн түвшнээс дээш 1194.5 м өндөрт орших ба хойноосоо урагш сунасан тахир хэлбэр дүрстэй. Нутгийн 5.9 хувь нь далайн түвшнээс дээш 900-1000м, 75.2 хувь нь далайн түвшнээс дээш 1000-1200м, 18.8 хувь нь далайн түвшнээс дээш 1200-1400м, 0.02 хувь нь далайн түвшнээс дээш 1400м-ээс дээш өргөгдсөн байна.




*Диаграмм 2. Баян-Адарга сумын өндөржилтийн эзлэх хувь*




*Зураг 4. Гадаргын өндөржилт*

***Байгаль-нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцөлийн мужлал:*** Нутаг дэвсгэрийг геологийн бүтэц, уур амьсгал, хотгор гүдгэр, ус зүй, хөрс ба ургамжилт, амьтны аймгийн хам бүрдлийн ялгаа, харилцан үйлчлэлийн ижил төстэй нөхцөлүүдээр нь мужилж, ашиглалтын үндсэн чиглэлийг тодорхойлох нь газрыг шинжлэх ухааны үндэслэлтэй ашиглах нөхцөлийг бүрдүүлдэг. Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хүрээнд Монгол улсын нийт нутаг дэвсгэрийг 4 муж, 31 тойргоор хуваaж нөхцөл нөөцийг үнэлсэн байна. /Д.Даш, Ц.Бадам-УГЗБЕТ-2002/ Энэ үнэлгээгээр Хэнтий аймгийн Баян-Адарга сумын нутаг дэвсгэр нь байгаль-нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцөлийн мужлалаар бүхэлдээ Хэнтийн нурууны тайгын мужийн Улз голын савын ойт хээр, хээрийн тойрог, Хэнтийн зах хаяа уулсын ойт хээрийн тойрогт багтаж байна. Эндхийн уулс бөмбөгөр оройтой, налуу хажуутай, хад чулуу багатай байдаг. Энэ тойргийн үнэмлэхүй өндөр нь 1500–2000 орчим метр байх буюу хөндийнүүдийнх нь өргөн 800–1200 метр байна.

### 2.3.3. Газрын гадаргын налуужилт

Гадаргын налуужилтын хувьд 0-5 градусын налуу бүхий газар нийт нутаг дэвсгэрийн 55 хувь, 5-12 градусын налуу бүхий газар нийт нутаг дэвсгэрийн 34 хувь, 12-оос дээш градустай налуу бүхий газар нийт нутаг дэвсгэрийн 11 хувийн тус тус эзэлж байна.

*Хүснэгт 4. Сумын гадаргын налуужилтын талбай*

| № | Налуужилт | Талбай, га | Эзлэх хувь |
|---|---|---|---|
| 1 | 0 -3 | 106532.53 | 35.2 |
| 2 | 3-5 | 59838.08 | 19.7 |
| 3 | 5 -10 | 87311.56 | 28.8 |
| 4 | 10 -12 | 16390.08 | 5.4 |
| 5 | 12 дээш | 32313.1 | 10.7 |
| **Нийт** | | **302607.6** | **100** |

Дээрх хүснэгтээс үзэхэд сумын нийт газар нутгийн 54.9 хувийг 0-5 градусын налуутай газар нутаг эзэлж байгаа нь газар тариалан эрхлэх, шинээр суурин газар байгуулах, зам, шугам сүлжээ тавихад гадаргын налуужилтын хувьд тохиромжтой байна.




*Диаграмм 3. Баян-Адарга сумын налуужилтын эзлэх хувь*




*Зураг 5. Гадаргын налуужилтын зураг*

### *2.3.4. Гадаргын зүг зовхис*

Гадаргын зүг зовхисын хувьд сумын нутаг дэвсгэрийн 12 хувийг тариалан эрхлэхэд нэн тохиромжтой 157.5-202.5 градусын зүг зовхис, 27 хувийг тариалан эрхлэхэд тохиромжтой 202.5-292.5 градусын зүг зовхис, 24 хувийг хязгаарлагдмал тохиромжтой 67.5-157.5 градусын зүг зовхис, 37 хувийг тариалан эрхлэхэд тохиромжгүй болон нэн тохиромжгүй 292.5-67.5 градусын зүг зовхистой гадарга эзэлж байна.

*Хүснэгт 5. Сумын гадаргын зүг зовхисын талбай*

| № | Зүг зовхис | Талбай, га | Эзлэх хувь |
|---|---|---|---|
| 1 | Хавтгай | 1299.21 | 0.4 |
| 2 | Хойд зүг | 36294.56 | 12 |
| 3 | Зүүн хойд зүг | 38382.26 | 12.6 |
| 4 | Зүүн зүг | 38652 | 12.7 |
| 5 | Зүүн урд зүг | 34201.02 | 11.3 |
| 6 | Урд зүг | 34900.08 | 11.5 |
| 7 | Баруун урд зүг | 39095.28 | 12.9 |
| 8 | Баруун зүг | 42296.6 | 13.9 |
| 9 | Баруун хойд зүг | 37225.55 | 12.3 |
| **Нийт** | | **302607.6** | **100** |




*Диаграмм 4. Гадаргын зүг зовхис, эзлэх хувиар*




*Зураг 6. Сумын гадаргын зүг зовхисын зураг*

## 2.4. Сумын уур амьсгалын онцлог

Байгаль орчны эмзэг тогтоцтой, эрс тэс уур амьсгал нь байгаль орчны болон нийгэм эдийн засгийн амьдралд сөрөг нөлөө үзүүлж байна. Эрт дээр үеэс дан ганц нүүдлийн мал аж ахуйг эрхэж байсан нь байгаль орчин, уур амьсгалын нөхцөлтэй шууд холбоотой байсан ба өнөөгийн зах зээлийн чөлөөт эдийн засгийн орчинд газар ашиглалтын олон хэлбэр, зориулалт нэмэгдсэний зэрэгцээ хүн ам, малын тоо нэмэгдсэн нь газар, байгаль, цаг уурт өөрчлөлтөд ихээхэн орж байна. Иймд тухайн сумын уур амьсгалын өнөөгийн төлөв байдал, цаашдын өөрчлөлтийн чиг хандлагыг судлах нь сумын

нутаг дэвсгэрийн хөгжлийг чиглүүлэх ач холбогдолтой тул төлөвлөгөөнд тусгаж ашиглах шаардлагатай байна.

Баян-Адарга сумын нутаг дэвсгэр уур амьсгалын мужлалаар хагас чийглэг, сэрүүн уур амьсгалтай, өвлийн дундаж температур -23$^0$С, зуны сард дунджаар +18$^0$С. Жилийн дундаж температур -2.2$^0$С байдаг. Эх газрын эрс тэс уур амьсгалтай, хавар намартаа цочир хүйтэрдэг. Хойд болон баруун хойд зүгийн салхи зонхилдог. Сүүлийн жилүүдэд хуурайшилтаас болж унах тунадас багсаж байна. Дунджаар жилд 120-150 хоног цасан бүрхүүлтэй байдаг ба цасны зузаан сүүлийн 2 жилд 30-40 см орчим байсан.

***Агаарын температур:*** Олон жилийн агаарын дундаж температур -2 хэм, өвлийн хамгийн хүйтэн 1-р сард -35-40 хэм, зуны хамгийн халуун нь +30-35 хэм хүрэх тохиолдол байдаг. Харин өнгөрсөн оны Баян-Адарга харуулын станцын мэдээнээс харвал жилийн дундаж температур -0.1$^0$С бөгөөд 1 сард хамгийн хүйтэн буюу -21.4$^0$С бол 7-р сард хамгийн халуун буюу +18.3$^0$С байна.

*Хүснэгт 6. Сумын сарын дундаж агаарын температур*

| Станц, харуулын нэр | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | Жилийн дундаж |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Баян-Адарга | -21.4 | -18.3 | -8.3 | 2.7 | 11.3 | 17.9 | 18.3 | 16.5 | 9.2 | 0.3 | -11.2 | -18.2 | -0.1 |

10$^0$С-аас их температуртай өдрийн тоог сүүлийн 5 жилийн дундаж нь 132 хоног байгаа нь жилийн 3-ний 1 нь 10$^0$С-аас дээш дулаан өдрүүд байна. 10$^0$С-аас дээш температуртай өдрүүд нь 7 сард хамгийн их буюу таван жилийн дунджаар 31 хоног байна.

*Хүснэгт 7. Сумын 10$^0$ С-аас их температуртай өдрийн тоо*

| Он | Сарууд | | | | | | | | | | | | ЖД |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | I | II | III | IV | V | VI | VII | VIII | IX | X | XI | XII | |
| 2010 | | | | 1 | 23 | 29 | 31 | 31 | 21 | 3 | | | 139 |
| 2011 | | | | 5 | 18 | 30 | 31 | 30 | 15 | 1 | | | 130 |
| 2012 | | | | 4 | 22 | 30 | 31 | 30 | 23 | 1 | | | 141 |
| 2013 | | | | 3 | 28 | 29 | 31 | 17 | 1 | | | | 109 |
| 2014 | | | | 11 | 21 | 29 | 31 | 31 | 17 | 2 | | | 142 |
| Дундаж | | | | 5 | 22 | 29 | 31 | 28 | 15 | 2 | | | 132 |




*Зураг 7. Сумын олон жилийн агаарын дундаж температурын зураг*

***Хур тунадас:*** Агаар мандлын орчил урсгал, орон нутгийн хотгор гүдгэрийн байдал, дэвсгэр гадаргын ууршилт зэргээр хур тунадасны горим тодорхойлогдоно. Хур тунадасны хэмжээ нь олон жилийн дунджаар тус аймгийн хойд уулархаг нутгаар жилд 317-400 мм, өмнөд нутгаар 250 мм-ээс бага хур тунадас ордог байна. Баян-Адарга сумын харуулын станцын мэдээнээс харвал хар тунадасны нийлбэр 288.5 мм бол үүний 259.5 мм нь дулааны улиралд унадаг бол үлдсэн 29 мм нь хүйтний улиралд унасан байна. Хамгийн их хур тунадас унадаг сар нь 7-р сар бөгөөд дунджаар 80 мм орчим байна.

*Хүснэгт 8. Сумын сарын хур тунадас*

| Станц, харуулын нэр | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | Нийлбэр | Дулаан үе | Хүйтэн үе |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Баян-Адарга | 1.0 | 3.4 | 3.2 | 9.7 | 19.4 | 62.1 | 80.6 | 74.5 | 22.9 | 6.9 | 3.0 | 1.8 | 288.5 | 259.5 | 29.0 |




*Зураг 7. Сумын хур тунадасны зураг*

***Чийгийн хангамж:*** Чийгийн хангамж нь тухайн бүс нутагт унасан хур тунадаснаас шалтгаалах бөгөөд сүүлийн 5 жилийн дунджаас харвал жилийн дундаж чийгийн хангамж

53 хувь байна. Үүний хамгийн их нь 7-р сард 64 хувь байгаа бол 11-3-р сард чийгийн хангамж 0 байна.

*Хүснэгт 9. Сумын харьцангуй чийг*

| Он | Сарууд | | | | | | | | | | | | ЖД |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | I | II | III | IV | V | VI | VII | VIII | IX | X | XI | XII | |
| 2010 | | | | 38 | 40 | 43 | 57 | 47 | 45 | 56 | | | 47 |
| 2011 | | | | 55 | 54 | 54 | 58 | 60 | 53 | 47 | | | 54 |
| 2012 | | | | 43 | 39 | 51 | 71 | 68 | 60 | 52 | | | 55 |
| 2013 | | | | 40 | 39 | 58 | 68 | | 57 | 63 | | | 54 |
| 2014 | | | | 42 | 40 | 65 | 67 | 62 | 59 | 55 | | | 56 |
| Дундаж | | | | 44 | 42 | 54 | 64 | 59 | 55 | 55 | | | 53 |

Сумын цасан шуургатай өдрийн тоог сүүлийн 5 жилийн дунджаас харвал 16 өдөр байгаа бөгөөд 2-р сард хамгийн их цасан шуургатай өдрүүд байна.

*Хүснэгт 10. Сумын цасан шуургатай өдрийн тоо*

| Он | Сарууд | | | | | | | | | | | | Нийт |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | I | II | III | IV | V | VI | VII | VIII | IX | X | XI | XII | |
| 2010 | 5 | 4 | 6 | 3 | | | | | | | 2 | 4 | 24 |
| 2011 | 1 | | 2 | 2 | | | | | | | | 2 | 7 |
| 2012 | 6 | 6 | 1 | 2 | | | | | | | 3 | 4 | 22 |
| 2013 | 1 | 5 | 2 | 2 | 1 | | | | | 2 | 2 | 1 | 16 |
| 2014 | | 3 | 1 | 1 | | | | | | | 2 | 4 | 11 |
| Дундаж | 3 | 5 | 2 | 2 | 1 | | | | | 2 | 2 | 3 | 16 |

Сумын цасан бүрхүүлтэй өдрийн тоог сүүлийн 5 жилийн дунджаас харвал 132 өдөр бөгөөд 2010 онд хамгийн их буюу 143 өдөр цасан бүрхүүлтэй өдрүүд байсан байна.

*Хүснэгт 11. Сумын цасан бүрхүүлтэй өдрийн тоо*

| Он | Сарууд | | | | | | | | | | | | Нийт |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | I | II | III | IV | V | VI | VII | VIII | IX | X | XI | XII | |
| 2010 | 31 | 28 | 31 | 19 | | | | | | | 3 | 31 | 143 |
| 2011 | 31 | 28 | 16 | | | | | | | | 20 | 31 | 126 |
| 2012 | 31 | 29 | 18 | | | | | | | | 20 | 31 | 129 |
| 2013 | 31 | 28 | 17 | | | | | | | 10 | 30 | 31 | 147 |
| 2014 | 31 | 28 | 24 | | | | | | | | | 31 | 114 |
| Дундаж | 31 | 28 | 21 | 19 | | | | | | 10 | 18 | 31 | 132 |




*Зураг 8. Агаарын даралт*

## 2.5. Хөрс, хөрсөн бүрхэвч

***Хөрс үүсгэгч эх чулуулаг:***

Ерөнхий чулуулгийн өнгөн гадаргад тэрүүхэн хэсэгтээ хөрс залган үүсэж байгааг хөрс үүсгэгч эх чулуулаг гэнэ. Өөрөөр хэлбэл чулуулгийн өгөршилд илүүтэй өртсөн сэвсгэр зөөлөн ба хөрсний хатуу хэсгийн эх материалыг шууд бүрэлдүүлэх үеийг "эх" хэмээн нэрлэнэ. Хөрс үүсгэгч эх чулуулгийн 20 гаруй хувь тунамал гаралтай. Гэхдээ уулархаг нутагт хөрс үүсгэгч эх чулуулаг нь магмынх байх тохиолдол нэлээд бий. Эх чулуулгийн эрдэс, хими, механик бүрэлдэхүүн хөрсөнд ургамал ургах нөхцөл ба тэнд явагдах үндсэн үйл явцыг, тухайлбал хумус хуримтлал, намагжилт, давсжилт, угаагдал зэргийг тодорхойлно. Эх чулуулаг, түүнээс үүсэх хөрсний хувь заяанд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэнэ. Хөрсний наанадаж 90 хувь нь (органик бодисоос бусад) эх чулуулгаас гаралтай. Хөрс үүсгэгч эх чулуулгийн зузаан нь хэдэн сантиметрээс 5 м хүртэл байна. Хөрс үүсгэгч эх чулуулгийг гарал үүслээс нь хамаарч 10 хуваадаг.

Баян-Адарга сум нь хотгор, гүдгэрийн олон хэв шинжтэй учраас сэвсгэр хурдасны төрөл, тэдгээрийн тархалт, зузаан, геотехникийн үндсэн хэв шинж зэрэг харилцан өөр өөр байна.

*Хүснэгт 12. Сумын хөрсний эх чулуулаг, талбайгаар*

| № | Эх чулуулаг | Талбай, га | Эзлэх хувь |
|---|---|---|---|
| 1 | Аллювийн хурдас | 37459.0 | 12.4 |
| 2 | Делювийн хурдас | 148917.2 | 49.2 |
| 3 | Элюви-Делювийн хурдас | 9182.6 | 3.0 |
| 4 | Элювийн хурдас | 107048.7 | 35.4 |
| **Нийт** | | **302607.6** | **100** |

Хүснэгтээс үзэхэд Хэнтий аймгийн Баян-Адарга сумын нутагт гарал үүслээс хамаарч дөрвөн хөрс үүсгэгч эх чулуулагт тархсан бөгөөд аллювийн хурдас 37.4 мян.га буюу 12.4 хувь, делювийн хурдас 148.9 мян.га буюу 49.2 хувь, элюви-делювийн хурдас 9.1 мян.га буюу 3.0 хувь, элювийн хурдас 107.0 мян.га буюу 35.4 хувийг эзэлж байна.



*Диаграмм 5. Хөрс үүсгэгч чулуулгийн эзлэх хувь*

*Аллювийн хурдас:* Аллювийн хурдас нь Баян-Адарга сумын томоохон голын хөндий ба татмын нугаар 37.4 мян.га буюу 12.4 хувийг эзэлнэ. Усны үйлчлэлээр зөөгдөж тогтсон хурдсыг хэлнэ. Үүний гол төлөөлөл нь татмын нугын хуримтлал юм. Энэ хуримтлал голын хөндий ба хажуу хөв татмаар үүснэ. Энэний зэрэгцээ мөн дельта үүсгэнэ. Ингэснээр голын дэнж үүсэж тогтоно. Голын хурдсыг эртний орчин үеийн гэж ангилна. Тэдгээрийн онцлог нь үелэн тогтсон үе нь ширхгүүд нь сайтар ангилагдсан байдлаар оршино. Энэ нь голын усны үе үеийн үерлэлт буюу урсгалын хүч, түүний үйлчлэлийн цар хүрээтэй холбоотой. Аллювийн хурдасны чулуун хэсэг нь урсгал усны үйлчлэлээр мөлгөр болсон нь байдаг

*Делювийн хурдас:* Делювийн хурдас нь Баян-Адарга сумын уулс хоорондын хөндий, хотгороор 148.9 мян.га буюу 49.2 хувийг эзлэх бөгөөд орчмын нутгаар тархана. Уул толгодын хоорондох өргөн, нарийн хөндий, уулын хормой бэл, хужирлаг мараат нуга зэрэг газраар тархана. Энэ хурдас нь байгалийн янз бүрийн хүчин зүйлийн /салхи, ус, газар хөдлөлт/ нөлөөгөөр нэг байрнаас нөгөө байранд шилжин гулсах замаар анхныхаа байршлыг өөрчилдөг онцлогтой. Хурдасны бүрэлдэхүүнд элс хайрга, шавар жижиг чулуу, хурц ирмэг бүхий чулуулгууд хамрагдана.Делювийн хурдас гол төлөв карбонатлаг шинж чанартай байхаас гадна түүний орчин нь гол төлөв шүлтлэгдүү байна. Энэ хурдсан дээр ихэнх тохиолдолд цайвар хүрэн, цөлөрхөг хээрийн бор, цайвар бор, цөлийн бор саарал нугын хөрсний янз дүрсүүд тархжээ. Механик бүрэлдэхүүний хувьд тоос ба элс давамгайлсан шавранцар эсвэл элсэрхэг ба элсэнцэр байдаг. Ийм хурдас нь нэлээд зузаантайгаар хотгор газраар тархах ба голдуу карбонатлаг байна. Карбонат дахь нүүрсхүчлийн агууламж үлэмж их.

*Элюви-делювийн хурдас:* Элюви-делювийн хурдас нь Баян-Адарга сумын ихэвчлэн уулархаг хэсгээр буюу уулын тэгшивтэр уулын тэгшивтэр орой, налуугийн дээд хэсэг мөн тал нутагт 9.1 мян.га буюу 3.0 хувийг эзэлнэ. Делювийн болон элювийн процессын хосолмол үр дүнд үүссэн ба үе давхаргын зузаан харьцангуй богино, голдуу элс давамгайлсан элсэнцрээс хөнгөн шавранцар заримдаа үйрмэг чулуутай холимог элсэн механик бүрэлдэхүүнтэй.

*Элювийн хурдас:* Элювийн хурдас нь Баян-Адарга сумын ихэвчлэн уулархаг хэсгээр буюу уулын тэгшивтэр уулын тэгшивтэр орой, налуугийн дээд хэсэг мөн тал нутагт 107.0 мян.га буюу 35.4 хувийг эзлэх бөгөөд орчмын нутгаар тархана. Чулуулгийн өгөршлийн янз бүрийн бүтээгдэхүүн анх үүссэн байрандаа зөөгдөлгүй үлдсэнийг нэрлэнэ. Иймээс элювийн хурдсыг байран хурдас гэдэг. Элювийн хурдасны онцлог анхны чулуулгийн найрлагаас бүрэн хамааралтай. Элюви аажим гүндээ яг л чулуулагтайгаа

адилхан болно. Ялангуяа цул чулуулаг дээр тогтсон элювийн хурдас эрдсийн ба механик бүрэлдэхүүнээрээ нэн жигд бус ба чулуулгийн хэмхдэснээс бүрдэнэ. Элювийн нимгэн хурдас дээр тогтсон хөрс ихэвчлэн жижиг үйрмэг чулуутай байна.




*Зураг 9. Сумын хөрсний эх чулуулгийн тархалтын зураг*

***Хөрсний хэв шинж:*** Монгол орон газарзүйн байршлын хувьд Дорнод Монголын цэвдэгт тайгаас төв Азийн хуурай цөлд завсрын нутгийг эзлэх тул байгалийн нөхцөлийн ялгаа эрс тэс, гадаргын төрх байдал жигд биш өндөр нам уул нуруу, хотгор хонхор, ухаа гүвээ, хөндий хоолой нуд алдам тал хөндий хосолсон учраас хөрс, хөрсөн бүрхэвч нь олон янзын харилцан адилгүй хөрс үүсэх нөхцөл бүрджээ.

Манай бүх нутгийн 80.0 хувь нь далайн түвшнээс дээш, 1000 метрээс өндөрт оршиж, том жижиг уул нуруу эзэлдэг учраас хөрсний тархалт үүсэл хөгжлийн үйл явц, хотгор гүдгэрийн хүчин зүйл шийдвэрлэх үүрэгтэй. Ийм учраас Монгол орны хөрсийг уулын болон талын хөрс ялган тэдгээрийн нийтлэг болон ялгаатай шинжийг илрүүлэх явдал чухал байдаг. Уулын болон талын хөрс нь геоморфологийн хувьд ялгаатай төдийгүй хөрс үүсэх үйл явцаар ялгаа их байдаг. Уулын хөрс нь гадаргын хэрчигдтэл ихтэй, налуу хэвгий байрлалтай, хажуугийн элэгдэл эвдрэлтэй байдаг бол талын хөрс нь гарал үүслийн хувьд харьцангуй тогтвортой төдийгүй аж ахуйн ач холбогдолтой.

Тус сум нь хөрсөн бүрхэвчийн хувьд нийт нутаг дэвсгэрийн 77.9 хувь буюу 235842.0 га талбайг уулын хөрс, 9.5 хувь буюу 28834.4 га талбайг тал хөндийн хөрс, 12.5 хувь буюу 37931.2 га талбайг бүс дундын хөрс тус тус эзэлж байна.

*Хүснэгт 13. Сумын нутаг дэвсгэрт тархсан хөрсний төрөл, талбайгаар*

| № | Хөрсний хэв шинж | Талбайн хэмжээ, га | Эзлэх хувь |
|---|---|---|---|
| 1 | Уулын ойн ширэгт бараан хөрс | 4897.9 | 1.6 |
| 2 | Уулын хар хүрэн хөрс | 213337.2 | 70.5 |
| 3 | Уулын хүрэн хөрс | 17606.9 | 5.8 |
| 4 | Далд глейрхэг хар шороон хөрс | 18840.5 | 6.2 |
| 5 | Нугын хүрэн хөрс | 2602.5 | 0.9 |
| 6 | Хар хүрэн хөрс | 4341.7 | 1.4 |
| 7 | Жинхэнэ хүрэн хөрс | 3049.7 | 1.0 |
| 8 | Аллювийн нуга-намгийн хөрс | 21036.6 | 76.9 |
| 9 | Аллювийн хүлэрлэг ялзмагт глейт хөрс | 727.4 | 0.2 |
| 10 | Аллювийн нугын хөрс | 16167.1 | 5.3 |
| **Нийт** | | **302607.6** | **100** |

*Аллювийн нуга-намгийн хөрс:* Энэ хэв шинжийн хөрс нь сумын нутаг дэвсгэрт 21036.6 га буюу нутаг дэвсгэрийн 6.9 хувийг эзлэн тархсан байна. Хөрс нь шим тэжээлийн бодисоор харьцангуй баялаг, байгалийн үржил шимээр сайн, чийг ихтэй, гагцхүү дулааны горимын хувьд тааламж муутай юм. Ялзмагийн хуримтлал өнгөн давхаргын доод үед 4-12% байх ба гүн рүүгээ алгуур багасаж хагас метрийн гүнд 2-6%-ийн ялзмагтай байна. Ширхгийн бүрэлдэхүүний хувьд хөнгөн ба дунд, хүнд шавранцар хөрс зонхилно. Хөрсний өнгөн хэсгийн 0-20 см үе дэх ялзмагийн нөөц 160-170 т/га, нийт азотын нөөц 10-12 т/га, фосфорын нөөц 3,5-4,2 т/га, калийн нөөц 25-32 т/га байдаг бол 0-50 см зузаан үед агуулагдах эдгээр бодис тус бүрийн нөөц 270-325 т/га, 19-20 т/га, 11-12 т/га, 98-123 т/га байна (Убугунов, Убугунова, Баатар, 1994, 1998).

Эндээс үзэхэд ургамалд ашигтай шимт бодисын нийт нөөц хангалттай бөгөөд түүнээс ургамалд хялбар шимэгдэх хөдөлгөөнт хэлбэрийн элементүүдийн эзлэх хувь бага, ялангуяа хөдөлгөөнт азот, калийн дутагдал ургамлын ургалтын бүх хугацаанд дутагдалтай

байна. Ийм хэв шинжийн хөрсөнд эрдэс бордоог /NPK/ зохистой тун хэмжээгээр хэрэглэсэн тохиолдолд хадлангийн гарцыг эрс нэмэгдүүлэх боломжтой юм.

*Аллювийн нугын хөрс:* Энэ хэв шинжийн хөрс нь сумын нутаг дэвсгэрт 16167.12 га буюу нутаг дэвсгэрийн 5.34 хувийг эзлэн тархсан байна. Хөрс нь дулаан хангамжийн хувьд намгийн хөрснөөс хавьгүй илүү, зуны туршид хангалттай сайн халдаг бөгөөд энэ нь түүний ус чийгийн горимд нөлөөлдөг. Чийг, дулааны хангамж тэгш хүрэлцээтэй учир ургамлын үлдэгдэл задарч ялзмагжих үйл явц эрчимтэй явагддаг. Аллювийн нугийн хөрс нь байгалийн үржил шимээр өндөр, шим тэжээлийн бодис болон ялзмагийн нөөц арвинтай бөгөөд 0-20 см үе дэх ялзмагийн нөөц 144-241т/га, нийт азотын нөөц 10-15 т/га, фосфорын нөөц 3,3-4,4 т/га, калийн нөөц 40-49 т/га хүрдэг бол 0-50 см зузаан үед агуулагдах эдгээр бодис тус бүрийн нөөц 285-322 т/га, 19-21 т/га, 8,5-10,5 т/га, 111-131 т/га байна (Убугунов, Убугунова, Баатар, 1994, 1998). Шим тэжээлийн бодис ерөнхийдөө их боловч түүнээс ургамалд хялбар шимэгдэхүйц хөдөлгөөнт элементүүдийн нөөц нь аллювийн намгийн хөрснөөс өндөр байна. Уг хөрсийг азот, фосфорын бордоогоор бордвол ургац нэмэгдүүлэх сайн талтай.

*Жинхэнэ хүрэн хөрс:* Энэ хэв шинжийн хөрс нь сумын нутаг дэвсгэрт 3049.749 га буюу нутаг дэвсгэрийн 1.01 хувийг эзлэн тархсан байна. Хөрсний ялзмагт үе давхаргын зузаан дунджаар 16 см, ялзмагийн хэмжээ нь 3%-иас хэтрэх нь бараг үгүй бөгөөд агрохимийн шинж, байгалийн үржил шимээр хар хүрэн хөрсийг гүйцэхгүй. Хөрсний дээд 0-20 см үе дэх ялзмагийн нөөц 40-60 т/га, азотын нөөц 4-5 т/га, хөдөлгөөнт азотын нөөц 50-70 кг/га, ургамалд ашиглагдах боломжтой фосфорын нөөц 50-200 кг/га, кали 200-400 кг/га, харин 0-50 см үе дэх ялзмагийн нөөц 80-110 т/га хүрнэ. Хүрэн хөрстэй газар голчлон бэлчээрт ашиглагдах боловч хадлан, тариалангийн зориулалтаар ашиглах явдал бага бий.

*Нугын хүрэн хөрс:* Энэ хэв шинжийн хөрс нь сумын нутаг дэвсгэрт 2602.474 га буюу нутаг дэвсгэрийн 0.86 хувийг эзлэн тархсан байна. Хөрсний ялзмаг хуримтлалын А үе давхарга нь бараан саарал өнгөтэй, бөөмөрхөг бүтэцтэй, дээд хэсэг нь заримдаа ургамлын үндсээр барьцалдаж нягт ширэгжсэн, зузаан нь 8-45 см байдаг. Нугын хүрэн хөрс нь үргэлж карбонаттай байдаг ч карбонатын хуримтлалын хэмжээ, илрэх байдал нь харилцан адилгүй байна. Хөрсний профильд хялбар уусах давс ямар нэг хэмжээгээр (0,1-0,3%) агуулагдаж, ихэнхдээ сулавтар хужирлаг шинжтэй байх боловч заримдаа давсжилтын хэмжээ нь дунд зэрэг буюу их (0.4-0.5%) түвшинд хүрдэг. Энэ хэв шинжийн хөрс нь голдуу хотос хонхор нам дор газраар байрлах тул гадаргын урсцын усаар байнга чийглэгдэж байдаг байна.

*Уулын ойн ширэгт бараан хөрс:* Энэ хэв шинжийн хөрс нь сумын нутаг дэвсгэрт 4897.933 га буюу нутаг дэвсгэрийн 1.62 хувийг эзлэн тархсан ба ойн бүсийн доод захаар тархсан байдаг. Хөрсний шинж төрх нь олон янз бөгөөд заримдаа хээрийн хөрстэй адил нунтаг карбонатын хуримтлалтай, нугын хөрсний глейрхэг шинжийг хадгалсан, мөн дарагдмал хөрсний үетэй ч байдаг. Ойн ширэгт бараан хөрс нь голдуу дундаж өндөр уулсын ар хажуугаар 850-1700 м–ийн үнэмлэхүй өндөрт, Хангайн нурууны захын уулст 1800-2000 м-ийн өндөрт шинэс, шинэс-хус, шинэс-нарс, шинэс-нарс-хус, хус, хус-улиасан ойд тогтворжино.

*Уулын хар хүрэн хөрс:* Энэ хэв шинжийн хөрс нь сумын нутаг дэвсгэрт 213337.188 га буюу нутаг дэвсгэрийн 70.5 хувийг эзлэн  тархсан байна. Хөрс нь нунтаг карбонатын хэвийн хуримтлалтай, ялзмагт үе давхаргын зузаан нь дунджаар 16 см, 3,5-5,0%-ийн агууламжтай.  Байгалийн үржил шимээр сайн, өвслөг ургамлын бүрхэц 50-70% хүрнэ. Хөрсний дээд талын 0-20 см үед ялзмагийн нөөц 70-90 т/га, нийт азотын хэмжээ 6-7 т/га орчим байна. Ийм хөрстэй газрыг жилийн турш бэлчээрт ашиглахаас гадна зарим тохиолдолд хадлан авч болно.

*Уулын хүрэн хөрс:* Энэ хэв шинжийн хөрс нь сумын нутаг дэвсгэрт 17606.9 га буюу нутаг дэвсгэрийн 5.82 хувийг эзлэн тархсан байна. Хөрсний ялзмаг хуримтлалын давхарга нь дунджаар 14 см, 2-3%-ийн ялзмагтай. Ширхгийн бүрэлдэхүүнээр хөнгөн шавранцар, хөнгөн шавранцар, элсэнцэр хөрс зонхилно. Карбонатын хуримтлалын давхаргуудад $CaCO_3$ –ийн нэвчмэл цайвар толботой, $CO_2$-ийн хэмжээ 2-5% байна. Урвалын орчин хөрсний дээд давхаргуудад саармаг буюу түүнтэй ойролцоо, доод давхаргуудад шүлтлэг шинжтэй. Уулын хүрэн хөрс нь байгалийн үржил шимээр хангалттай, дээд талын 0-20 см үе дэх ялзмагийн бодисын нөөц 50-70 т/га, нийт азотын хэмжээ 5-6 т/га орчим байна. Өвслөг ургамлын бүрхэц 30-50% хүрэх бөгөөд ийм хөрстэй бэлчээрийг жилийн 4 улиралд сэлгэж ашиглах боломжтой.

*Хар хүрэн хөрс:* Энэ хэв шинжийн хөрс нь сумын нутаг дэвсгэрт 4341.696 га буюу нутаг дэвсгэрийн 1.43 хувийг эзлэн тархсан байна. Хөрс нь алаг өвс-үетэнт хуурай хээрийн ургамалжилтын доор тогтворжих бөгөөд өвслөг ургамлын бүрхэц 50-80%-ийг эзэлнэ. Чийг багатай, хөнгөн механик бүрэлдэхүүнтэй учир улирлын цэвдэг нь мөсгүй байдаг онцлогтой. Ялзмагт давхаргын зузаан нь дунджаар 23 см, ялзмагийн агууламж бага учраас шингээх багтаамжийн хэмжээ их биш, шингээгдсэн сууриудын нийлбэр хөнгөн шаврацар хөрсөнд 100гр-д 16-26 мг-экв, элсэнцэр ба элсэн хөрсөнд 6-16 мг-экв байна. Энэ хөрс нь агрохимийн шинжээр харьцангуй сайн, шим тэжээлийн элементийн агууламж хангалттай тул газар тариалангийн зориулалтаар ашиглахад тохиромжтой.  Хөрсний дээд 0-20 см үе дэх ялзмагийн нөөц 60-80 т/га, нийт азотын нөөц 5-6 т/га, хөдөлгөөнт азотын

нөөц 80-100 кг/га, ургамалд ашигтай фосфорын нөөц 100-250кг/га, хөдөлгөөнт калийн нөөц 250-450 кг/га  байгаа нь хөрсний үржил шимээр өндөр үзүүлэлттэйд орно.




*Зураг 10. Хөрсний хэв шинж*

***Хөрсний механик бүрэлдэхүүн:*** Хөрсний механик бүрэлдэхүүн гэж хөрсөн дэх элс, тоос, шавар гурвын тооны харьцангуй агууламжийг хэлнэ. Механик бүрэлдэхүүнээс юуны өмнө хөрсний ус - физик, физик - механикийн шинж чанар болох агаар, дулааны, исэлдэлд - ангижралтын горим, шингээх чадвар, хөрсөн дэх ялзмаг ба шимт элементийн хуримтлал хамааралтай.

Хөрсний механик бүрэлдэхүүнээр сумын нутгийн ихэнх нутаг дэвсгэрт 52.7 хувь буюу 159745.3 га талбайг хөнгөн шаврансар хөрс, 38.4 хувь буюу 116457.6 га талбайг

элсэнцэр, багахан хэсгээр 6.5 хувь буюу 19769.8 га талбайг дунд шавранцар, 0.9 хувь буюу 2731.0 га талбайг  шаварлаг, 1.3 хувь буюу 3903.7 га талбай элс тус тус тархсан байна.

*Хүснэгт 14. Сумын хөрсний механик бүрэлдэхүүний талбай*

| № | Хөрсний механик бүрэлдэхүүн | Талбайн хэмжээ, га | Эзлэх хувь |
|---|---|---|---|
| 1 | Шаварлаг | 2731.0 | 0.9 |
| 2 | Хөнгөн шавранцар | 159745.3 | 52.8 |
| 3 | Дунд шавранцар | 19769.8 | 6.5 |
| 4 | Элсэнцэр | 116457.7 | 38.5 |
| 5 | Элс | 3903.7 | 1.3 |
| **Нийт** | | **302607.6** | **100** |




*Диаграмм 6. Сумын хөрсний механик бүрэлдэхүүний эзлэх хувь*




*Зураг 11. Сумын хөрсний механик бүрэлдэхүүн*

## 2.6. Ургамалжилт

Сумын ургамал, бэлчээрийн төрх байдал, ургамлын экологийн мэдээллүүдийг сумын хэмжээнд боловсруулан гаргалаа. Тус мэдээллийг бэлчээрийн газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны судалгааны тайлангаас авч ашигласан болно. Боловсруулалтад сумын хилийн цэс болон бусад ашиглалтуудын хамаарлыг ялган бэлтгэлээ.

### *2.6.1. Ургамлын бүс, бүслүүр*

Монгол орон өргөн уудам нутаг дэвсгэртэй, уул нуруу, хотгор гүдгэр гадаргатай, эх газрын эрс тэс уур амьсгалтай учраас ургамалжилтын хувьд нэлээд өвөрмөц бөгөөд

умардаас урагшлахад ой тайга, тал хээр, говь цөл гэсэн 3 үндсэн бүсэд хуваагддаг. Монгол орны газрын гадарга, уур амьсгалын өвөрмөц онцлогтой зохицсон ургамалжилтын өндөр уулын бүслүүр; уулын тайгын бүслүүр; ойт хээрийн бүс; хуурай хээрийн бүс; говийн бүс; цөлийн бүс зэрэг 6 бүс, бүслүүр бий болжээ.

*Хүснэгт 15. Байгалийн бүс, бүслүүр*

| № | Байгалийн бүс, бүслүүр | Талбай, га | Эзлэх % |
|---|---|---|---|
| 1 | Ойт хээрийн | 132695.9 | 43.9 |
| 2 | Хуурай хээрийн | 169911.7 | 56.1 |
| **Нийт** | | **302607.6** | **100** |

Хүснэгтээс үзэхэд Хэнтий аймгийн Баян-Адарга сум нь ургамалжилтын бүс, бүслүүрийн ойт хээрийн бүсэд 132.6 мян.га буюу 43.9 хувь, хуурай хээрийн бүсэд 169.9 мян.га буюу 56.1 хувийг эзэлж байна.




*Диаграмм 7. Байгалийн бүс, бүсүүр*

<u>*Ойт хээрийн бүслүүр*</u> Хэнтий аймгийн Баян-Адарга сумын нутаг дэвсгэрийн 43.9 хувь нь ойт хээрийн бүсэд хамаарна. Энэ бүслүүрийн гол онцлог бол уулархаг нутагт илэрч буй хээр, ойн элементүүдийн өвөрмөц хослолоос бүрддэгт оршино. Өөрөөр хэлбэл уулархаг нутагт хээр ой хоёр зэрэгцэн оршиж бие биедээ нөлөөлдгийг үзэх бодит жишээ юм. Уулын арын ой, уулын хээртэй зүй ёсоор ээлжлэн солигдож, харилцан хосолсны улмаас уулын ойт хээр гэж нэрлэгдэх хоёрдмол шинжтэй завсрын бүслүүрийг буй болгоно. Энэ бүслүүрт тохиолдох ургамлыг экологийн бүлгээр нь авч үзвэл дийлэнх нь чийгсэг, чийгсүү-хуурайсаг, хуурайсаг, хүйтсэг бүлгийн ургамал байна. Уулс бүхий нутгуудад чулуурхаг, хайргархаг хөрстэй, ил гарсан хад чулуу ихтэй байх тул хуурайсаг-чулуусаг, чийгсүү-чулуусаг, хүйтсүү-чулуусаг ургамал нэлээд хувийг эзэлнэ. Бас ус, нуур, гол, нуга, намаг олонтой, чийг хүрэлцээтэй нутгууд багагүй тул уссаг, намагсаг булгийн ургамал нэлээд элбэг юм. Энэ бүслүүрийн захын нутгуудаар гол, нуурын эрэг, хөвөө дагаж эрдэсжилт багагүй илрэх тул түүнийг дагаж давссаг бүлгийн ургамлууд нэвтрэн орсон байдаг. Ойт хээрийн хэв шинжид хамаарах элдэв өвс-үетэнт, хялганат, хазааргана-

хялганат, агь-хялганат, ботууль-агьт уулын хээр; ойн үндсэн хэв шинжид хамаарах өвслөг ургамалт саруул шинэсэн ой, нарсан ой, хус-шинэс-нарсан холимог ой тохиолдоно. Уулын амны эх, чийглэг хажуу, хөндийдөө нугат хээртэй. Голын хөндий, татам дагаж татмын нуга, голын хөндийн шугуй, сөөгөн ширэнгэтэй. Харин элсэрхэг далан, хайрга чулуу ихтэй хөндий, хажуу дагаж саман өрхөг (*Agropyron cristatum*), саман дурваа (*Koeleria cristata*) зонхилсон хээржсэн нуга тааралдана, Уулын хээрт голдуу үет ургамал зонхилох боловч хөрс, газрын гадаргатай уялдан олон зүйл үетний эзлэх арви өөр өөр болсноор хээрийн үндсэн эвшлүүд ялгагдана.

*Хуурай хээрийн бүслүүр* Хэнтий аймгийн Баян-Адарга сумын нутаг дэвсгэрийн 56.1 хувь нь ойт хээрийн бүсэд хамаарна. Хуурай хээрийн бүс нь Хэнтий аймгийн Баян-Адарга сумын газар нутгийг нэлэнхийд нь хамаарна. Хуурайсаг олон наст дэгнүүлт ба үндэслэг ишт үетэн, алаг өвст ургамал зонхилсон нутгийг хээр гэдэг. Хуурайсаг, чийгсүү-хуурайсаг, хуурайсуу-чулуусаг бүлгийн ургамлууд зонхилон ургадаг. Хээрийн бүсэд үржил шим сайтай нунтаг карбонаттай ба карбонатгүй хүрэн, заримдаа элсэнцэр цайвар хүрэн хөрстэй. Хуурай хээрт Криловын хялгана (*Stipa krylovii*), Дэрвээн хазаар өвс (*Cleistogenes squarrosa*), Том хялганат (*Stipa grandis*), Нангиад түнгэт (*Leymus chinensis*), Саман ерхөгт (*Agropyron cristatum*), Жижигнавчит харгана (*Caragana microphylla*) бүхий бүлгэмдлүүд зонхилдог.




*Зураг 12. Ургамалжлын бүс, бүслүүр*

### *2.6.2. Ургамал газарзүйн мужлал*

Монгол орны ургамал газарзүйн мужлалын хуваарийг ашиглав. Хэнтий аймгийн Баян-Адарга сумын нутгийн ихэнх хэсэг ургамал; газар зүйн мужлалын Гол Арктикийн их мужийн Эртний газар дундын тэнгисийн дэд их мужийн Иран-Тураны мужийн Төв азийн цөл, хээрийн дэд муж, Монголын хээр, цөлийн хошууны Монголын хээрийн дэд хошуу

Дундад Халхын хээрийн тойрогт 336.8 мян.га буюу 100 хувийг эзэлдэг. (Өлзийхутаг, 1989)

*Хүснэгт 16. Ургамал-газарзүйн мужлал*

| № | Тойрог | Ургамал газарзүйн тойрог | Талбай, га | Эзлэх % |
|---|---|---|---|---|
| 1 | 4 | Монгол-Дагуурын уулын ойт хээрийн тойрог | 18900.5 | 6.2 |
| 2 | 8 | Дундад Халхын хээрийн тойрог | 283707.1 | 93.8 |
| **Нийт** | | | **302607.6** | **100** |




*Диаграмм 8. Ургамал газарзүйн тойрог, %*

*Монгол-Дагуурын уулын ойт хээрийн тойрог:* Баян-Адарга сумын нутгийн 6.2 хувь буюу 18.9 мян.га талбай Монгол-Дагуурын уулын ойт хээрийн тойргийн баруун урд хэсэгт хамаарах бөгөөд Дундад халхын хээрийн тойргийг түрж байрлана. Энд Шар Хад уул, Улаан Хошуу уул, Цагаан Нуранга уул, зэрэг бэсрэг уулс тохиолдох бөгөөд тэдгээрийн оргилууд голдуу 1000-1400м-т оршино. Энэ тойрогт хамаарах Туул гол урсана. Ургамалжлын хувьд өрнөд ба дорнод хэсэгтээ уулсын арыг дагасан элдэв өвст шинэсэн ой хэсэг хэсгээр тохиолдохоос гадна хус нарсан, хус-шинэсэн холимог ой, хусан ой сөөгөн ширэнгэ тохиолдоно. Энэ тойрогт голллож навчит ба холимог ой, хэсэгхэн саруул шинэсэн ой тохиолдох бөгөөд захын сэжүүр уулсад улиангаран төгөл бий. Энэ тойрогт төрөл бүрийн хувилбараар тохиолдох уулын хээрийн ургамалжилт зонхилно. Зонхилох хээрийн хэвшлүүдэд шивээт хялгана-хазаарганат, шивээт хялгана-хазаар өвс-алаг өвст, хялгана-навтуулт хээр багтах бөгөөд дорно талдаа нангиад түнгэ, шивээт хялгана-түнгэт, шивээт хялгана-зүр өвст хээр гол байрыг эзэлнэ. Бас баялаг өвстэй нугат хээр, , татмын нуга нэлээд тохиолдоно. Үйрмэг чулуутай, хайргархаг хөрстэй газар их тул тийм газраараа хээрийн чулуурхаг хувилбар тохиолдоно. Элсэнцэр хөрстэй хэсгээр нь жижиг навчит харгана бүхий элдэв өвст хээртэй.

*Дундад халхын хуурай хээрийн тойрог:* Дундад халхын хээрийн тойргийн зүүн хойд хэсэгт Баян-Адарга сумын нутгийн 93.8 хувь хамаарна. Хад чулуутай өндөрлөг газраар

шивээт хялганын *(Stipa krylowii)* олон эвшил тохиолдоно. Тухайлбал: Хялгана – хиагт, Хялгана – үетэнт, Хялгана – харганат хуурай хээр тааралдана. Элсэнцэр хөрстэй газар нь харганатай, Сөөг-үетэнт хээртэй бөгөөд тэнд саман ерхөг(*Agropyron cristatum*), саман дурвaa (*Koeleria cristata*), агь(*Artemisia frigida*) алтан шар шарилж(*Artemisa palustris*), жижиг навчит(*Caragana stenophylla*) ба одой харгана(*Caragana pygmaea*) зонхилогч болно. Гол нуур орчмын хужир, марцлаг хотгорт нангиад түнгэ, дэрс бүхий Үетэн-улалж-алаг өвст, Үетэн-алаг өвст хээржсэн нуга, Улалж-үетэн-алаг өвст, Үетэн-жижиг улалжит, Дэрс-жижиг улалжит хээр тааралдана. Тус тойргийн ургамал өвөрмөц онцлогоор бага, Монгол-Дагуурын уулын ойт хээрийн тойргийн ургамлууд холилдон ургана.




*Зураг 13. Ургамал-газарзүйн мужлал*

### *2.6.3. Ургамлын экологийн хэв шинж*

Ургамлын экологийн хэв шинжийн зургийг ургамалжилтын зургаас бэлчээрийн ангилааг ерөнхийлөл хийж боловсруулсан. Ургамлын ангилааг боловсруулахдаа тэжээлийн эдэлбэрийн үндсэн шинж чанар, түүнийг тодорхойлогч ургамалжилт, хөрс, хотгор, гүдгэр, цаг уурын хүчин зүйлүүдийн онцлогийг системчлэн нэгтгэсэн. Бэлчээрийн ургамалжилтын хамгийн том нь бэлчээрийн төрөл юм. Хадлан бэлчээрийн нэг төрөлд зүйлийн бүрэлдэхүүн, бүтэц, тэжээлийн шимт чанараараа ойролцоо, ашиглаж хамгаалахад

ижил арга шаарддаг. Баян-Адарга сумын газар нутгийг гадаргын байдлаар дундаж өндөр болон нам, бэсрэг уулын, нам бэсрэг уулсын хоорондох нуга хөндийн, тал хээрийн, бүс дундын голын хөндий, нам хотосын нугын, ой, сумын төв гэсэн төрлүүдэд ялгана.

*Хүснэгт 17. Ургамлын экологийн хэв шинж, талбай, эзлэх хувь*

| **№** | **Экологийн хэв шинж** | **Талбай /га/** | **Эзлэх хувь** |
|---|---|---|---|
| 1 | Н, Бүс дундын голын хөндийн, нам хотосын нугын бэлчээр | 44751.6 | 14.8 |
| 2 | Х, Тал хээрийн бэлчээр | 75735.1 | 25 |
| 3 | У, Дундаж өндөр болон нам, бэсрэг уулын бэлчээр | 156925.7 | 51.9 |
| 4 | УХ, Нам бэсрэг уулсын хоорондох нуга хөндийн бэлчээр | 25197.4 | 8.3 |
| **Нийт талбай** | | **302607.7** | **100** |




*Диаграмм 9. Ургамлын экологийн хэв шинжийн эзлэх хувь*

*Дундаж өндөр болон нам, бэсрэг уулын бэлчээр*: Баян-Адарга сумын нутагт 156.9 мян.га буюу 51.9 хувийг эзлэх бөгөөд бөгөөд уулын хар хүрэн ба нугын улирлын цэвдэгт хар шороон хөрстэй нугархаг хээр, уулын сул хөгжилтэй хар хүрэн ба хар шороон хөрстэй хээр, уулын хүрэн заримдаа хар хүрэн хөрстэй хээр, уулын сул хөгжилтэй хүрэн, цайвар хүрэн хөрстэй хээр, уулын цайвар хүрэн ба бор хөрстэй цөлөрхөг хээрийн бэлчээрийн ангиуд хамаарна. Ургамлын зүйлийн бүрэлдэхүүнд гол төлөв хялгана, ботууль, зүр өвс зонхилж, хоёрдогчоор алаг өвс, сибирь зүр өвс, дэрвээн хазаар өвс, жижиг дэгнүүлт үетэн оролцсон төрлүүд нэлээд тааралдана.

*Нам бэсрэг уулсын хоорондох нуга хөндийн бэлчээр*: Баян-Адарга сумын сумын нутагт 25.1  мян.га буюу 8.3 хувийг эзлэх бөгөөд уулсын хоорондох гүндээ цэвдэгтэй хар шороон ба хар хүрэн хөрстэй уулын нугын бэлчээрийн анги хамаарна.. Ургамлын зүйлийн бүрэлдэхүүнд үетэн, алаг өвс, улалж зонхилж, хоёрдогчоор үетэн, улалж, алаг өвс тархалттай.

*Тал хээрийн бэлчээр:* Баян-Адарга сумын нутагт 75.7 мян.га буюу 8.3 хувийг эзлэх бөгөөд тэгшивтэр болон нугачаат хөндийн шавранцар хүрэн хөрстэй хээр, тэгшивтэр

хөндийн элсэнцэр хүрэн хөрстэй хээрийн бэлчээрийн ангиуд хамаарна. Ургамлын зүйлийн бүрэлдэхүүнд гол төлөв крыловын хялгана, ленийн ботууль, ширэг улалж, алаг өвс, жижиг дэгнүүлт үетэн, хиаг, үетэн зонхилж, хоёрдогчоор хиаг, жижиг дэгнүүлт үетэнт, хазаар өвс тааралдана.

*Голын хөндий нам хотосын бэлчээр*: Баян-Адарга сумын нутагт 44.7 мян.га буюу 14.8 хувийг эзлэх бөгөөд голын хөндий нуурын захын аллювийн нутагт намгийн хөрстэй нуга намгийн бэлчээр, аллювийн нугын болон хээржсэн нугын үелсэн сулавтар хөгжилтэй хөрстэй татамын нуга, голын хөндий, нам хотосын аллювийн нугын ба нугын хээржсэн хөрстэй давсархаг нугын бэлчээрийн ангиуд хамаарна. Ургамлын зүйлийн бүрэлдэхүүнд гол төлөв үетэн, улалж, дэрс, улаан толгой зонхилж, хоёрдогчоор алаг өвс, үетэн, жижиг улалж тааралдана.




*Зураг 14. Сумын ургамлын экологийн хэв шинжийн зураг*

### 2.6.4. Бэлчээрийн ургамалжилтын төрөл

Сумын нутаг дэвсгэрийн 17.2 хувийг ой, нуурын талбай, үлдэх 82.8 хувийг бэлчээр эзэлж байна. Үүнээс нутгийн 33.9 хувь буюу 95223.3 га талбайд жижиг дэгнүүлт үетэн-алаг өвст бэлчээр тархсан байна.

*Хүснэгт 18. Сумын бэлчээрийн ургамлын анги, төрөл зүйл*

| Анги | Бүлэг, төрөл | Ургамал | Талбайн хэмжээ /га/ |
|---|---|---|---|
| голын хөндий, нам хотосын болон хээржсэн нугын үелсэн сулавтар хөгжилтэй | Алаг өвст | Алаг өвс - уалжит | 847.9 |
| | | Уалж - үетэн - алаг өвст | 5953.1 |
| | Уалжит | Уалж - үетэн - алаг өвст, уалж - үетэнт | 1927.76 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | Улалж - үетэн - алаг өвст, хялгана - жижиг дэгнүүлт, үетэнт | 1387.08 |
| | | Дэгнүүлт үетэнт | Улалж - үетэн - алаг өвст, шарилжит | 7637.11 |
| | | | Үетэн - улалж - алаг өвст | 3933.35 |
| | | | Үетэн - улалж - алаг өвст, улалжит | 4565.98 |
| | | | Үетэн - улалж - алаг өвст, улалжит, хялгана - зүр өвс | 666.48 |
| | | | Үетэн - цахирлаг - алаг өвст | 0.14 |
| | Тэгшивтэр болон нугачаат хөндийн шавранцар хүрэн хөрстэй хээр Дэгнүүлт үетэнт | Алаг өвст | Алаг-үетэнт | 281.78 |
| | | Улалжит | Жижиг улалж - үетэнт, шарилжит | 338.12 |
| | | Алаг өвст | Зүр өвс - алаг өвст | 6682.28 |
| | | Дэгнүүлт үетэнт | Биелэг - үетэнт, биелэг - хиагт, шарилжит | 624.26 |
| | | | Ботууль - жижиг дэгнүүлт үетэн - алаг өвст | 1870.15 |
| | | | Ботууль - жижиг дэгнүүлт үетэн - алаг өвст, шарилж | 953.49 |
| | | | Хялгана - жижиг дэгнүүлт үетэнт, хялгана-алаг өвст, шарилжит | 2095.68 |
| | | | Хялгана - жижиг дэгнүүлт үетэнт, шарилжит | 758.09 |
| | | | Хялгана - жижиг дэгнүүлт, үетэнт, хялгана - алаг өвст | 634.07 |
| | | | Хялгана - зүр өвст | 7035.81 |
| | | | Хялгана - хиагт, алаг өвст, шарилжит | 2173.14 |
| | | | Хялгана - хиагт, дааган сүүлт, шарилжит | 243.21 |
| | | | Хялгана - хиагт, шарилжит | 5370.33 |
| | | | Хялганат, хялгана - алаг өвст | 5294.02 |
| | | | Хялганат, хялгана - алаг өвст, хиагт | 835.18 |
| | | | Хялганат, хялгана - алаг өвст, шарилжит | 6681.48 |
| | | | Хялганат, хялгана - алаг өвст, шарилжит, жижиг дэгнүүлт үетэнт | 6953.09 |
| | | | Хялганат, хялгана - алаг өвст, шарилжит, хиагт | 2579.58 |
| | | Үндэслэг ишт үетэнт | Хиагт, хиагт - алаг өвст | 384.18 |
| | | | Хиагт, хиагт - алаг өвст, шарилжит | 1381.44 |
| Нам бэсрэг уулсын хоорондох нуга хөндий | Уулсын хоорондох хөндийн гүндээ цэвдэгтэй хар шороон ба хар хүрэн хөрстэй уулын нуга | Алаг өвст | Зүр өвс -алаг өвс - үетэнт | |
| | | | Зүр өвст - хялганат | 507.23 |
| | | | Зүр өвст - хялганат, хянганат - зүр өвст | 1068.7 |
| | | Улалжит | Улалж - үетэнт | 2051.88 |
| | | Дэгнүүлт үетэнт | Улалж - үетэнт, шарилжит | 687.29 |
| | | | Улаан толгой - улалж - алаг өвст | 158.78 |
| | | Үндэслэг ишт үетэнт | Үетэн - алаг өвст | 1950.56 |
| Дундаж өндөр болон нам, бэсрэг уулын бэлчээр | Уулын сул хөгжилтэй хар хүрэн ба хар шороон хөрстэй нугархаг хээрийн сийрэг ургамалтай чулуурхаг бэлчээр | Дэгнүүлт үетэнт | Ботууль - алаг өвст, ботууль - зүр өвст | |
| | | | Ботууль - алаг өвст, ботууль - хялганат | 5495.74 |
| | | | Ботууль - алаг өвст, зүр өвст - жижиг дэгнүүлт үетэнт | 6909.72 |
| | | | Ботууль - алаг өвст, зүр өвст - хялганат | 18057.97 |
| | | | Ботууль - алаг өвст, хялгана - зүр өвст | 4014.28 |
| | | | Жижиг дэгнүүлт үетэн - алаг өвст, зүр өвс - хялганат | 5368.56 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | Уулын сул хөгжилтэй хүрэн, цайвар хүрэн хөрстэй сийрэг ургамалтай | Дэгнүүлт үетэнт | Жижиг дэгнүүлт үетэнт - алаг өвст - агьт | 920.75 |
| | Уулын хар хүрэн ба нугын улирлын цэвдэгт хар шороон хөрстэй нугархаг хээр | Дэгнүүлт үетэнт | Ботууль - зүр өвс, алаг өвст | 3442.07 |
| | | Алаг өвст | Зүр өвс - хялганат, ботууль - зүр өвст | 7186.61 |
| | | | Зүр өвст, зөр өвс - алаг өвст | 1316.17 |
| | | Дэгнүүлт үетэнт | Хялгана - зүр өвст | 7.82 |
| | | | Хялгана - зүр өвст, ботууль - зүр өвст | 3381.08 |
| | Уулын хүрэн заримдаа хар хүрэн хөрстэй хуурай хээрийн бэлчээр | Дэгнүүлт үетэнт | Ботууль - алаг өвст | 2395.78 |
| | | | Ботууль - алаг өвст, хялгана - зүр өвст | 11341.47 |
| | | | Ботууль - алаг өвст, хялгана - үетэнт | 10361.87 |
| | | | Ботууль - алаг өвст, хялганат, хялгана - алаг өвст | 5499.07 |
| | | | Ботууль - хялганат | 960.24 |
| | | | Ботууль - хялганат, ботууль алаг өвст | 488.32 |
| | | | Ботууль - хялганат, хялганат, хялгана - алаг өвст | 9964.19 |
| | | | Хялгана - зүр өвст | 9562.56 |
| | | | Хялгана - зүр өвст, ботууль алаг өвст | 4744.04 |
| | | | Хялгана - зүр өвст, жижиг дэгнүүлт үетэнт - алаг өвст | 9509.28 |
| | | | Хялгана - зүр өвст, зүр өвс - алаг өвст | 3745.73 |
| | | | Хялгана - зүр өвст, зүр өвс - жижиг дэгнүүлт үетэнт | 3393.14 |
| | | | Хялгана - зүр өвст, хялганат, хялгана - алаг өвст | 3815.69 |
| | | | Хялганат, хялгана - алаг өвст | 865.62 |
| | | | Хялганат, хялгана - алаг өвст, биелэг - алаг өвст | 1360.37 |
| | | | Хялганат, хялгана - алаг өвст, хялгана - зүр өвст | 9082.95 |
| | | | Жижиг дэгнүүлт үетэн - алаг өвст | 2134.53 |
| | | | Жижиг дэгнүүлт үетэн - хялганат | 3636.29 |

### *2.6.5. Бэлчээрийн төрх байдал*

Хэнтий аймгийн Баян-Адарга сумын бэлчээрийн газрыг цэвэр бэлчээр, сөөгтэй, чулуутай, довонтой гэж байгалийн унаган төрх байдлаар ангилсан.

*Хүснэгт 19. Бэлчээрийн төрх байдал*

| № | Бэлчээрийн төрх | Талбай, га | Эзлэх хувь |
|---|---|---|---|
| 1 | Цэвэр бэлчээр | 100038.8 | 33.1 |
| 2 | Чулуутай бэлчээр | 89377.3 | 29.5 |
| 3 | Сөөгтэй бэлчээр | 66271.8 | 21.9 |
| 4 | Довонтой бэлчээр | 46921.9 | 15.5 |

| | | |
|---|---|---|
| **Нийт** | **302607.7** | **100** |

Хүснэгтээс үзэхэд Хэнтий аймгийн Баян-Адарга сумын бэлчээрийн газрыг цэвэр бэлчээр 100.0 мян.га буюу 33.1 хувь, чулуутай бэлчээр 89.3 мян.га буюу 29.5 хувь, сөөгтэй бэлчээр 66.2 мян.га буюу 21.9 хувь, довонтой бэлчээр 46.9 мян.га буюу 15.5 хувийг эзэлнэ.




*Диаграмм 10. Бэлчээрийн төрх байдал*

*<u>Цэвэр бэлчээр</u>* Цэвэр бэлчээр нь 100.0 мян.га буюу нийт бэлчээрийн 33.1 хувийг эзэлнэ. Бэлчээрийн ангилалд чулуурхаг биш, сөөггүй, довонгүй, ургамлын нөмрөгтэй буюу 10000 $м^2$ талбайд байх чулууны хэмжээ 5 хувиас бага, сөөгийн оролцоо 5 хувиас бага, довон 5 хувиас бага бол цэвэр гэж зэрэглэн авч үзнэ.

*<u>Чулуутай бэлчээр</u>* Чулуутай бэлчээр нь 89.3 мян.га буюу нийт бэлчээрийн 29.5 хувийг эзэлж байна. Бэлчээрийн ангилалд ургамлын нөмрөгтэй боловч чулуурхаг гадаргатай талбайг чулуутай бэлчээрт хамааруулах бөгөөд 10000 $м^2$ талбайд байгаа чулуужилт 31 хувиас дээш бол их чулуутай, 16-30 хувь байвал дунд зэрэг чулуутай, 5-15 хувь байвал бага чулуутай гэж зэрэглэнэ. Энэ төрлийн бэлчээр өндөр уулын ба уулын сийрэг ургамалтай чулуурхаг хээрт ихэвчлэн тохиолдоно.

*<u>Сөөгтэй бэлчээр</u>* Сөөгтэй бэлчээр нь 66.2 мян.га буюу нийт бэлчээрийн 21.9 хувийг эзэлж байна. Бэлчээрийн ургамлын бүрхэцтэй, сөөг зонхилох бэлчээр хамаарна. Сөөгийн эзлэх хувиар 10000 $м^2$ талбайд байгаа сөөг 31 хувиас дээш бол их сөөгтэй, 16-30 хувь байвал дунд зэрэг сөөгтэй, 5-15 хувь байвал бага сөөгтэй гэж зэрэглэж ялгав.

*<u>Довонтой бэлчээр</u>* Довонтой бэлчээр нь 46.9 мян.га буюу нийт бэлчээрийн 15.5 хувийг эзэлж байна. Бэлчээрийн ангилалд ургамлын бүрхэцтэй, голын нугын ба элсэн довонтой бэлчээр хамаарах бөгөөд 10000 $м^2$ талбайд байгаа довон 31 хувиас дээш бол их довонтой, 16-30 хувь байвал дунд зэрэг довонтой, 5-15 хувь байвал бага довонтой гэж ялгана.




*Зураг 15. Бэлчээрийн төрх байдал*

### 2.6.6. *Бэлчээрийн төлөв байдал*

Газар ашиглалтын зориулалт нэмэгдэх, уур амьсгалын өөрчлөлт болон бусад хүчин зүйлийн нөлөөгөөр хөдөө аж ахуйн газрын тооны болон чанарын өөрчлөлтөд ихээхэн орж байна. Үүнээс шалтгаалж нэгж талбайн ургац, тэжээлийн шимт чанар буурах, ургацад малын тэжээлийн ургамлын эзлэх хувь багасах, хөрсний үржил шим буурах, хөдөө аж ахуйн газар доройтолд нэрвэгдэх үзэгдэл манай орны аль ч бүс нутагт түгээмэл байна. Өнөө үед ХАА-н газар нь эрчимжсэн газар тариалан, бэлчээр ашиглалт, ой хээрийн түймэр, зам барилгын байгууламж зэрэг хүний олон талт үйл ажиллагааны нөлөөгөөр

доройтолд өртөж байна. Монгол орон нь газар зүйн байршил, эх газрын эрс тэс уур амьсгал зэргээс хамааран дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлтөд эрчимтэй өртөөд байгаа орны нэг бөгөөд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр дулааны улирлын хур тунадасны хэмжээ буурч хуурайшиж ган болох, цөлжих явц илүү ажиглагдаж байна.

***Бэлчээрийн талхлагдалт*** гэдэг нь малыг хэт олноор удаан хугацааны туршид нэг дор давтан бэлчээснээр ургамлан нөмрөг өөрчлөгдөн, тэжээлийн чанар муутай ургамал ихсэж, малд идэмж сайтай ургамлын тоо цөөрч, хөрсний өнгөн хэсэг бүтцээ алдах үйл явц бөгөөд хүн, мал амьтан, автогенийн нөлөөгөөр бэлчээрийн ургамлын үндсэн төрөл, бүрхэвч өөрчлөгдөн чанар чадавхи нь муудахыг хэлнэ. [О.Чогний, 1999, С.Бадрах, 2005 он]. Хэнтий аймгийн Баян-Адарга сумын бэлчээрийн газрын талхагдлын хэмжээг дараах байдлаар гаргасан.

*Хүснэгт 20. Бэлчээрийн талхлагдал, зэрэглэлээр*

| № | Төрөл | Байршил | Талбай | Эзлэх % |
|---|---|---|---|---|
| 1 | Хүчтэй талхлагдсан | 35 | 36180 | 52.9 |
| 2 | Дунд зэрэг талхлагдсан | 11 | 12005 | 17.6 |
| 3 | Сул талхлагдсан | 28 | 20162 | 29.5 |
| **Нийт** | | | **68346.5** | **100** |

Хэнтий аймгийн Баян-Адарга сумын 68.3 мян.га буюу 22.6 хувь нь талхлагдсан, үүнээс Сул талхлагдсан 20.1 мян.га буюу 29.6 хувь, дунд зэрэг талхлагдсан 12.0 мян.га буюу 17.6 хувь, хүчтэй талхлагдсан 36.1 мян.га буюу 52.9 хувийг эзэлж байна.




*Диаграмм 11. Бэлчээрийн талхлагдал, %*




*Зураг 16. Талхлагдсан бэлчээр, нөлөөлөлд өртсөн бэлчээр*

## 2.7. Ойн нөөц, төлөв байдал

Баян-Адарга сумын нутаг дэвсгэрийн 9.56 хувийг ойн сан бүхий газар эзлэх бөгөөд үүнээс ойгоор бүрхэгдсэн талбай 18868.2 га буюу нийт ойн сан бүхий газрын 55.3 хувийг, ойгоор бүрхэгдээгүй талбай 14056.6 га буюу 45.7 хувийг эзэлж байна.

*Хүснэгт 17. Сумын ойн сан бүхий газар, талбайгаар*

<table>
<tr><th>№</th><th colspan="2">Ойн сан бүхий газрын төлөв байдал</th><th>Талбай ,га</th><th>Нийт ОСБГ-т эзлэх хувь</th></tr>
<tr><td rowspan="3">1</td><td colspan="2">Ойгоор бүрхэгдсэн</td><td>18868.22</td><td>55.29%</td></tr>
<tr><td rowspan="2">Үүнээс</td><td>Байгалийн ой</td><td>18677.88</td><td></td></tr>
<tr><td>Бут сөөг</td><td>190.34</td><td></td></tr>
<tr><td rowspan="6">2</td><td colspan="2">Ойгоор бүрхэгдээгүй</td><td>14056.636</td><td>44.71%</td></tr>
<tr><td rowspan="5">Үүнээс</td><td>Шатанги</td><td>2406.27</td><td rowspan="5"></td></tr>
<tr><td>Тармаг ой</td><td>10381.2</td></tr>
<tr><td>Мод бэлтгэсэн талбай</td><td>21.28</td></tr>
<tr><td>Цагаан энгэр</td><td>283.44</td></tr>
<tr><td>Ойжих талбай</td><td>964.446</td></tr>
<tr><td colspan="3">Сумын нийт ойн сан бүхий газар</td><td>32924.856</td><td>100%</td></tr>
</table>

Адарга баг хамгийн их буюу 19487.9 га талбай бүхий ойн нөөцтэй, хамгийн бага нь Сайхан баг 1508.5 га талбайд ой тархсан байна. Нийт ойн сан бүхий газрын 60 гаруй хувийг нарс, 30 орчим хувийг улиас, 10 орчим хувийг бусад мод болон бутлаг ургамлууд эзэлдэг.




Зураг 14 . Сумын ойн төлөв байдлын зураг

## 2.8. Гадаргын болон гүний усны нөөц

Баян-Адарга сумын ихэнх хэсэг нь Онон голын сав газрын захиргаанд хамаарагддаг ба Сайхан багийн урд талаар багахан хэсэг нь улз голын сав газрын захиргаанд хамаарагдана. Онон болон Улз голын сав газрууд нь хойт гидрогеологийн системд хамаарагдана. Сумын төвд нэгдүгээр сарын дундаж температур нь -20°С -25°С, долдугаар сарынх +16°С - +18°С, жилд дунджаар 200-400 мм тунадас орно. Хур тунадасны 18-30% нь гол мөрний урсац болдог ба үлдсэн хэсэг нь ууршилт болон газрын доорх усны тэжээлд зарцуулагддаг.

Сумын нутгаар Онон гол 80 орчим км урсдаг. Онongийн цутгал Арангат, Шуус, Урт, Баруун-булаг, Хүйтэн, Сайхан зэрэг гол горхитой. Сайн-цагаан, Холбоо, Шийр, Улаан, Баян зэрэг нуруудтай. Гидрокарбонат-кальц-магнийн найрлага бүхий Арангатын рашаантай.

Тус сумын хувьд гадаргын болон газрын доорх усаар харьцангуй баялаг сумд тооцогдоно. Газрын доорх усны ихэнх нөөц голын хөндийн аллювийн хурдас дахь ус агуулагч бүрдэл дотор хуримтлагддаг ба локал тархалттай ундрага ихтэй эсвэл их тархалттай бага, дунд ундрагатай голын элс хайрга, элсэнцэр шаврын үеүүд агуулсан уст давхаргуудад байдаг. Онон мөрний ай савын газрын доорх усны ашиглалтын баримжаат нөөцийн хуваарилалтаар Баян-Адарга суманд ус хурах тайлбайг 17792 км$^2$, ашиглах боломжит нөөцийг 10,3 м$^3$/с, 0,325 км$^3$/жил гэж Н.Жадамбаа /газрын доорх ус судлаач Sc.D/ гуай тооцсон байдаг.

<u>Сумын ус хангамж.</u> Энэхүү бүс нутагт өрөмдмөл худаг, бэлчээрт гаргасан худгууд, энгийн худгууд, Онон болон түүний цутгал голууд, булаг, шанд нь хүн амын ус хангамжийн эх үүсвэрүүд болдог. Сумын төвд хүн амын ус хангамжид 4-5 өрөмдмөл худаг ашиглагдаж байна.

Хээрийн судалгааны явцад хөдөөгийн малчин өрхийн нэг хүний хоногийн усны бодит хэрэглээ 7-9 литрээр хязгаарлагдаж, энэ нь Дархан, Эрдэнэт, Чойбалсан хотын ус хангамжийн нэгдсэн сүлжээнд холбогдсон сууцанд амьдарч байгаа хүмүүсийн ус хэрэглээнээс 20 дахин, аймгийн төвийн ус хангамжийн нэгдсэн сүлжээнд холбогдсон боловч халуун усгүй байранд амьдарч байгаа хүмүүсийн усны хэрэглээнээс 10 дахин, сумын төвийн хүмүүсийн усны хэрэглээнээс 2-3 дахин бага байна.

*Хүснэгт 21. Баян-Адарга сумын таван хошуу малын ус хэрэглээ*

| № | Малын төрөл | Малын тоо толгой | 1 малын ус хэрэглээ л/хон | Нийт ус хэрэглээ м3/хон | Жилийн хэрэглээ м3 |
|---|---|---|---|---|---|
| 1 | Хонь, ямаа | 87794 | 3.5 | 307.2 | 112128 |
| 2 | Үхэр | 10159 | 23 | 233.6 | 85264 |
| 3 | Адуу | 6752 | 24 | 162 | 59130 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 4 | Тэмээ | 66 | 57 | 3.7 | 1350.5 |
| Бүгд | | 104771 | - | 706.5 | 257872.5 |

*Хүснэгт 22. Баян-Адарга сумын ХАА-н тариалангийн ус хэрэглээ*

| **№** | **ХАА-н таримал** | **Талбайн хэмжээ га** | **Усалгаатай газар тариалангийн усалгааны норм м3/га** | **Нийт ус хэрэглээ м3/га** |
|---|---|---|---|---|
| 1 | Үр тарианы төрлийн ургамал | 1370 | 2200 | 3014000 |
| 2 | Төмс | 11 | 2750 | 30250 |
| 3 | Хүнсний ногоо | 9 | 2900 | 26100 |
| | Бүгд | 1390 | 7850 | 3070350 |

Хүн ам болон малын тоог 2014 оны тооллогын дүнгээр тооцов.

Тариалангийн талбайн хэмжээг хээрийн судалгааны ажлын үр дүнгээр сумын захиргаанаас авсан тоон дээр үндэслэн тооцов. Хүн ам, мал аж ахуй, ХАА-н тариалангийн усны хэрэглээг Байгаль орчны Сайдын 1995 оны 153-р тушаалаар батлагдсан түр нормыг ашиглан тооцсон болно.

/Сумын төвийн оршин суугчдыг дуурлпг багийн хүн амын тоогоор авав/.

Худаг, булаг, нуур голуудын 2011 оны тооллогоор нийт сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд 53 худгийг бүртгэн тоолсон байдаг ба үүнээс 39-г ажилтай буюу ашиглаж байгаа гэж бүртгэн авчээ. Энэхүү бүс нутагт сүүлийн жилүүдэд болсон хуурайшилтаас болж булгийн 49.4% хатаж ширгэсэн. 2011 оны усны тооллогод уст цэгийн солбицлыг л оруулсан байна.

*Хүснэгт 20. Баян-Адарга сумын 2011 оны усны мэдээлэл /нэгтгэснээр/*

| **№** | **Тооцсон он** | **Хөдөө оршин суугчид** | **Нэг хүний хоногийн хэрэглээ (л)** | **Хоногийн хэрэглээ (л)** | **Сумын төвд оршин суугчид (л)** | **Нэг хүний хоногийн хэрэглээ (л)** | **Хоногийн хэрэглээ (л)** | **Хоногийн нийт хэрэглээ (м3)** | **Жилийн хэрэглээ (м3)** |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2010 он | 1633 | 15 | 24495 | 690 | 25 | 17250 | 41.7 | 15220.5 |
| 2 | 2014 он | 1502 | 15 | 22530 | 908 | 25 | 22700 | 45.2 | 16498 |

| **№** | **Төрөл** | **Ширгэсэн Ажилгаагүй** | **Устай, ажиллагаатай** | **Нийт тоологдсон** |
|---|---|---|---|---|
| 1 | Нуур | тодорхойгүй | тодорхойгүй | 56 |
| 2 | Булаг | 37 | 38 | 75 |
| 3 | Худаг | 15 | 39 | 54 |

Хээрийн ажлаар орон нутагт ажиллах явцад 15 худгийн пасспортай танилцсан ба бусад худгийн талаарх мэдээлэл байхгүй байлаа. Эдгээр пасспорттай худгуудыг сумын удирдлагаас малчидтай гэрээ байгуулан хариуцуулж өгсөн байна. Пасспорттай худгийн мэдээлэлийг хүснэгт 5-д нэгтгэв.

*Хүснэгт 23. Баян-Адарга сумын пасспорттой худгийн мэдээлэл*

| № | Эзэмшигч | Худгийн хийц | Цооногийн зүсэлт | Усны тогтсон түвшин | Зориулалт | Ундарга | Бүртгэсэн огноо |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Эрхэмчухал | өрөмдмөл | 0-3.5м бул чулуу, 3.5-6 м хүрэн шавар, 6-38м улаан шавар, 38-42 м элс хайрга уст үе, 42-69м нягт шавар. | 36 | усалгаа | 1.5 л/с | 2008 |
| 2 | Ж.Болдбаатар | өрөмдмөл | 0-2.5м бул чулуу элс, 2.5-14м хүрэн шавар, 14-20м нарийн ширхэгтэй элс уст үе, 20-28м нягт улаан шавар, 28-33м саарал шавар, 33-38м сиенит ан цав | 12м | усалгаа | 1л/с | 2008 |
| 3 | Ц.Мижидсамдан | өрөмдмөл | 0-12 м бул чулуутай элс, 12-13.5м элс устай, 13.5-15.5м улаан шавар, 18.5м ан цавтай сиенит, 18.5-33.5 м сиенит | 11.5м | | 0.8л/с | 2008 |
| 4 | ЗДТГ | өрөмдмөл | | 20м | | 1л/с | 2007 |
| 5 | Сайхан баг | өрөмдмөл | | 8м | | 1л/с | 2007 |
| 6 | Ж.Бат-Эрдэнэ | өрөмдмөл | | 5.5 | | 1.3л/с | 2007 |
| 7 | Ц.Цогтбаатар | богино яндант | 0-3м хайрга сайрга, 3-12м нягт улаан шавар, 12-22м хайрга бул чулуу уст үе, 22-24м шавар | 6.1 | бэлчээрийн | 1.1л/с | |
| 8 | Дамдинсүрэн | өрөмдмөл | 0-20м бул чулуу хүрэн шавар чигжээстэй, 20-29м хайрга элс жижиг шаврын үеүүдтэй, 29-34м нягт хүрэн шавар нягт бул чулуутай | 22 | | 0.6л/с | 2008 |
| 9 | | өрөмдмөл | 0-21м бул чулуутай элс, хайрга, 21-33м элс хайргатай шавар, 33-42м жижиг шаврын үеүдтэй бул чулуу | 31 | бэлчээрийн | 0.83л/с | 2007 |
| 10 | | өрөмдмөл | 0-14м элсэнцэр бага зэрэг шавартай, 14-32м элсэн чулуу, 32-77м хүрмэн чулуу | 9.5 | | 1.2л/с | |
| 11 | Содном | өрөмдмөл | | 12 | бэлчээрийн | 1.0л/с | 2007 |
| 12 | Шүхэр | өрөмдмөл | 0-5м хайрга дайрга шавар элстэй, 5-17м устай хайрга дайрга, бул чулуу шаварлаг элс, 17-22м шаварлаг хайрга элс, 22-28м устай бул чулуу хайрга дайрга шавартай | 5 | бэлчээрийн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 13 | | өрөмдмөл | 0-10м янз бүрийн ширхэгтэй элс, 10-40м элс шаврын хурдас, песлано | 8.5 | бэлчээрийн | 1л/с | 2010 |
| 14 | ЗДТГ | өрөмдмөл | | 8 | ус хангамж | 4л/с | 2014 |
| 15 | ЗДТГ | өрөмдмөл | | 16 | | | 2013 |

Эдгээр цооногуудад ихэвчлэн нарийн ширхэгтэй элс, элс, элстай хайрга, хайрга дайрга, бул чулуун зэргүүдэд уст үеүүд илэрсэн ба цуулбар шүүрийн хийцтэй байна. Цооногуудын ундарга 0,6 – 4 л/с ба ус илэрсэн гүн геологийн тогтоцоосоо хамааран 5,5-36 м байна.

Баян-Адарга сумын нутагт нийт 8 гол, 19 булаг, 14 нууртай, Онон гол 80 км урсах бөгөөд тус Онон голд цутгадаг Шуусын гол, түүний цутгал болох Сайхан, Арангат зэрэг голууд урсана. Мөн Улаан, Хүйтний зэгст, Шийрийн, Холбоогийн зэрэг нууруудтай. 1992 оны усны тооллогоор 6 гол, 6 нуур, 23 булаг шанд, 86 худаг бүртгэгдсэнээс өнөөдрийн байдлаар 4 гол, 5 нуур, 17 булагтай. Булагнаас 10-г нь хашиж хамгаалсан. 1995 оноос хойш 2 гол, 2 нуур, 6 булаг хатаж ширгэсэн дүн байна.

*Хүснэгт 24. Сумын уст цэгийн бүртгэл*

| № | Багийн нэр | Гар худаг | Гүний худаг | Булаг | Эвдэрсэн худаг |
|---|---|---|---|---|---|
| 1 | Сайхан баг | 7 | 11 | 9 | 18 |
| 2 | Жаргалант баг | 4 | 6 | 4 | 5 |
| 3 | Адарга баг | 3 | 4 | 5 | 2 |

Жаргалант багийн нутгаар урсдаг Арангатын голын эхэнд гидрокарбонат-кальци-натрийн найрлага бүхий рашаантай. Хүн амын усан хангамжинд ашиглагдаж байгаа ундны усны эх үүсвэрүүд нь өрөмдмөл худаг, бэлчээрт гаргасан худгууд, гол, булаг, гар худгууд болно. Сумын төвд хүн амын усан хангамж ахуйн хэрэгцээнд зориулан 3 инженерийн хийцтэй гүн өрмийн худаг, 1 богино яндант худаг ашиглагдаж байна. Хөдөөгийн ард иргэд, малын усан хангамж хэрэгцээнд 6 инженерийн хийцтэй гүн өрмийн, 22 богино яндант худаг ашиглаж байна. Өнгөрсөн хугацаанд 20 гаруй худаг эвдэрч тоногдон ашиглах боломжгүй болжээ.

*Хүснэгт 25. Сумын голуудын бүртгэл*

| № | Голын нэр | Цутгал гол | Тайлбар |
|---|---|---|---|
| 1 | Хөтөлжийн горхи | Балжийн гол | Устай |
| 2 | Хавхагтын гол | Шуус гол | Хавхагтын ардаас эх авна. /усгүй/ |
| 3 | Арангатын гол | Онон гол | Арангатын овооны өвөр устай |
| 4 | Сайхан гол | Шуус гол | Сайхны овооны өвөр энгэр устай |
| 5 | Хүйтний гол | Шуус гол | Хүйтний овооны баруун урдаас устай |
| 6 | Шуус гол | Онон гол | Хутаг уулын баруун хойноос устай |
| 7 | Хөлийн гол | Шуус гол | Хөлийн хар чулууны зүүн хойноос устай |
| 8 | Онон гол | Номхон далай | Устай |

*Хүснэгт 26. Сумын нуурын бүртгэл*

| № | Нуурын нэр | Нуурт цутгах гол | Нуурaас эх авсан гол | Нуурын мандалын талбай км |
|---|---|---|---|---|
| 1 | Шилийн нуур | | | 1.2 |
| 2 | Хойд өвдгийн нуур | | | 6.2 |
| 3 | Цагаан нуур | | | |
| 4 | Тахир нуур | | | |
| 5 | Хулстайн нуур | | | |
| 6 | Бага хонхорын нуур | | | |
| 7 | Хөдөө нуур | | | |
| 8 | Нуур | | | |
| 9 | Сайн цагаан нуур | | | |
| 10 | Их хонхор нуур | | | |
| 11 | Хялаацай нуур | | | |
| 12 | Улаан нуур | | | |
| 13 | Буурлын нуур | | | |
| 14 | Хавтгайн бүрд | | | |

Баян-Адарга сумын Дунд булгийн ухаа, сумын төвийн булаг, Жугант Цацын толгойн булгаас тус тус дээж авч усны химийн шинжилгээ хийлгэсэн.

Адарга багийн Жугант Цацын толгойн булгийн (X=48$^{0}$41’43.2”, Y=111$^{0}$14’43.2”) усны шинжилгээний дүгнэлт: Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, холимог бүлгийн, 1-р төрлийн, чанарын хувьд цэнгэгдүү, зөөлөвтөр ус байна. Уг усыг гадаргын усны цэврийн зэргийн ангиллын нормтой харьцуулахад перманганатын исэлдэх чанарын агууламжаараа “Бага зэргийн бохирдолтой” гэсэн ангилалд хамаарч байна.

Дуурлиг багийн булгийн (X=48$^{0}$43’04.1”, Y=111$^{0}$05’53.7”) усны шинжилгээний дүгнэлт: Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, кальцийн бүлгийн, 1-р төрлийн, чанарын хувьд цэнгэгдүү, зөөлөвтөр ус байна. Уг усыг гадаргын усны цэврийн зэргийн ангиллын нормтой харьцуулахад аммоны ионы агууламжаараа “Бага зэргийн бохирдолтой” гэсэн ангилалд хамаарч байна.

Сайхан багийн Дунд булгийн ухаа, гүний худгийн (X=48$^{0}$23’08.1”, Y=111$^{0}$30’11.2”) усны шинжилгээний дүгнэлт: Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, кальцийн бүлгийн, 1-р төрлийн чанатын хувьд нэн цэнгэг, зөөлөн ус байна, Шинжилсэн бүх үзүүлэлтүүд нь ундны усны стандарт MNS900:2010-ын шаардлага хангаж байна.

ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ ГАЗАРЗҮЙ-ГЕОЭКОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН УСНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ

Усны химийн шинжилгээний тодорхойлолт

Шинжилгээ хийсэн: 2015 оны 08 сарын 19 өдөр
Сорьц авсан газрын нэр:
Хэнтий, Баян-Адарга сум, Сайхан баг
Дунд булгийн ухаа, гүний худаг
Сорьц шинжлүүлсэн байгууллага, хувь хүн: МГЭБХолбоо

Солбицлол X= 48°243'08.1" Гүн : м
Y= 111°30'11.2" Ундарга: л/с

Тодорхойлсон нь:

| Анион | 1 дм³ -д байгаа | | | Катион | 1 дм³ -д байгаа | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мг | мг-экв | мг-экв% | | мг | мг-экв | мг-экв% |
| $Cl^-$ | 3.6 | 0.10 | 4.38 | $Na^++K^+$ | 5.3 | 0.23 | 10.14 |
| $SO_4^{--}$ | 6.0 | 0.13 | 5.48 | $Ca^{++}$ | 27.1 | 1.35 | 59.17 |
| $NO_2^-$ | 0.00 | 0.00 | 0.00 | $Mg^{++}$ | 8.5 | 0.70 | 30.68 |
| $NO_3^-$ | 0.4 | 0.01 | 0.28 | $NH_4^+$ | 0.0 | 0.00 | 0.00 |
| $CO_3^{--}$ | 0.0 | 0.00 | 0.00 | $Fe^{++}$ | 0.0 | 0.00 | 0.00 |
| $HCO_3^-$ | 125.1 | 2.05 | 89.86 | $Fe^{+++}$ | 0.0 | 0.00 | 0.00 |
| Дүн | 135.0 | 2.28 | 100.00 | Дүн | 40.9 | 2.28 | 100.00 |

$HCO_3^-$ ийн хагасыг хассан анион катионуудын нийлбэр: 113.4 мг/ дм³
Анион катионуудын нийлбэр: 175.9 мг/ дм³

Ерөнхий хатуулаг: 2.05 мг-экв/ дм³
pH: 7.5
Исэлдэх чанар: 4.16 мг/ дм³
EC: 202 µS/cm
TDS: 101 ppm

Физик чанар:
Тунгалаг: 30 см
Өнгө: үгүй
Үнэр: 0 балл
Амт: 0 балл
Тунадас: үгүй

Усны найрлагын томъёо: $M_{0.18}\dfrac{HCO_3^-90}{Ca^{2+}59\ Mg^{2+}31\ Na^++K^+10}$

**Дүгнэлт**

Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, кальцийн бүлгийн, I-р төрлийн, чанарын хувьд маш цэнгэг, зөөлөн ус байна. Шинжилсэн бүх үзүүлэлтүүд нь ундны усны стандарт MNS900:2010-ын шаардлага хангаж байна.

*Жич: Энэхүү усг цэгээс дээж авах үйл явцыг сорьц шинжлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцан гүйцэтгэсэн болно.*

Шинжилгээ хийсэн:
ЭШДА: Магистр (M.Sc) ________ /Т.Энхжаргал/

Шалгаж, дүгнэсэн:
УШ лабораторийн эрхлэгч: Доктор (Ph.D) ________ /Ч. Жавзан/

*Зураг 17. Сайхан багийн Дунд булгийн усны химийн шинжилгээний тодорхойлолт*

ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ ГАЗАРЗҮЙ - ГЕОЭКОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН УСНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ

**Усны химийн шинжилгээний тодорхойлолт**

Шинжилгээ хийсэн: 2015 оны 08 сарын 19 өдөр
Сорьц авсан газрын нэр:
Хэнтий, Баян-Адарга сум, Дуурлиг баг сумын төвийн булаг
Сорьц шинжлүүлсэн байгууллага, хувь хүн: МГЗБХолбоо

Солбицлол X= 48°433'04.1" Y= 111°05'53.7" Гүн: м
Ундарга: л/с
Уст цэгийн төрөл ба дугаар: булгийн ус

Тодорхойлсон нь:

| Анион | 1 дм³ -д байгаа | | | Катион | 1 дм³ -д байгаа | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мг | мг-экв | мг-экв% | | мг | мг-экв | мг-экв% |
| $Cl^-$ | 5.3 | 0.15 | 4.94 | $Na^++K^+$ | 24.9 | 1.08 | 35.60 |
| $SO_4^{--}$ | 4.0 | 0.08 | 2.74 | $Ca^{++}$ | 29.1 | 1.45 | 47.75 |
| $NO_2^-$ | 0.00 | 0.00 | 0.00 | $Mg^{++}$ | 6.1 | 0.50 | 16.47 |
| $NO_3^-$ | 0.2 | 0.00 | 0.11 | $NH_4^+$ | 0.1 | 0.01 | 0.18 |
| $CO_3^{--}$ | 0.0 | 0.00 | 0.00 | $Fe^{++}$ | 0.0 | 0.00 | 0.00 |
| $HCO_3^-$ | 170.8 | 2.80 | 92.21 | $Fe^{+++}$ | 0.0 | 0.00 | 0.00 |
| Дүн | 180.3 | 3.04 | 100.00 | Дүн | 60.1 | 3.04 | 100.00 |

$HCO_3^-$ ийн хагасыг хассан анион катионуудын нийлбэр: 155.0 мг/ дм³
Анион катионуудын нийлбэр: 240.4 мг/ дм³

Ерөнхий хатуулаг: 1.95 мг-экв/ дм³
pH: 7.6
Исэлдэх чанар: 3.76 мг/ дм³
EC: 271 µS/cm
TDS: 135 ppm

Физик чанар:
Тунгалаг: 30 см
Өнгө: үгүй
Үнэр: 0 балл
Амт: 0 балл
Тунадас: үгүй

Усны найрлагын томъёо: $M_{0.2}\dfrac{HCO_3^-92}{Ca^{2+}48\ Na^++K^+36\ Mg^{2+}16}$

**Дүгнэлт**

Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, кальцийн бүлгийн, I-р төрлийн, чанараа хувьд цэнгэг, зөөлөн ус байна. Уг усыг гадаргын усны цэвэрийн зэргийн ангилалтай харьцуулахад химийн нэмэлт агууламжаараа "Бага зэргийн бохирдолтой" гэсэн ангилалд хамаарч байна.

*Жич: Энэхүү усл цэгээс дээж авах үйл явцыг сорьц шинжлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцан гүйцэтгэсэн болно.*

Шинжилгээ хийсэн:
ЭШДА: Магистр (M.Sc) ________ /Т.Энхжаргал/

Шалгаж, дүгнэсэн:
УШ лабораторийн эрхлэгч: Доктор (Ph.D) ________ /Н. Жавзан/

*Зураг 18. Дуурлиг багийн сумын төвийн булгийн усны химийн шинжилгээний тодорхойлолт*

ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ ГАЗАРЗҮЙ - ГЕОЭКОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН УСНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ

Усны химийн шинжилгээний тодорхойлолт

Шинжилгээ хийсэн: 2015 оны 08 сарын 19 өдөр
Сорьц авсан газрын нэр:
Хэнтий, Баян-Адарга сум, Адарга баг
Жугант Цацын толгойн булаг
Сорьц шинжлүүлсэн байгууллага, хувь хүн: МГЗБХолбоо

Солбицлол X= 48°41'41.4" Гүн : м
Y= 111°14'43.2" Ундарга: л/с
Уст цэгийн төрөл ба дугаар: булгийн ус

Тодорхойлсон нь:

| Анион | 1 дм³ -д байгаа | | | Катион | 1 дм³ -д байгаа | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мг | мг-экв | мг-экв% | | мг | мг-экв | мг-экв% |
| $Cl^-$ | 7.1 | 0.20 | 2.74 | $Na^++K^+$ | 68.8 | 2.99 | 41.01 |
| $SO_4^{--}$ | 4.0 | 0.08 | 1.14 | $Ca^{++}$ | 48.1 | 2.40 | 32.92 |
| $NO_2^-$ | 0.00 | 0.00 | 0.00 | $Mg^{++}$ | 23.1 | 1.90 | 26.06 |
| $NO_3^-$ | 0.4 | 0.01 | 0.09 | $NH_4^+$ | 0.0 | 0.00 | 0.00 |
| $CO_3^{--}$ | 0.0 | 0.00 | 0.00 | $Fe^{++}$ | 0.0 | 0.00 | 0.00 |
| $HCO_3^-$ | 427.0 | 7.00 | 96.02 | $Fe^{+++}$ | 0.0 | 0.00 | 0.00 |
| Дүн | 438.5 | 7.29 | 100.00 | Дүн | 140.0 | 7.29 | 100.00 |

$HCO_3^-$ ийн хагасыг хассан анион катионуудын нийлбэр: 365.0 мг/ дм³
Анион катионуудын нийлбэр: 578.5 мг/ дм³

Ерөнхий хатуулаг: 4.30 мг-экв/ дм³
pH: 7,6
EC: 688 µS/cm
Исэлдэх чанар: 5.28 мг/ дм³
TDS: 343 ppm

Физик чанар:
Тунгалаг: 30 см
Өнгө: үгүй
Үнэр: 0 балл
Амт: 0 балл
Тунадас: үгүй

Усны найрлагын томъёо: $M_{0.5}\frac{HCO_3^-96}{Na^++K^+41Ca^{2+}33\,Mg^{2+}26}$

**Дүгнэлт**

Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, кальцийн бүлгийн, I-р төрлийн, чанарын хувьд цэнгэнгүү, зөөлөвтөр ус байна. Уг усыг газарын усны цэврийн зэргийн ангиллын нормтой харьцуулахад перманганатын исэлдэх чанарын агууламжаар "Бага зэргийн бохирдолтой" гэсэн ангилалд хамаарч байна.

***Жич:** Энэхүү уст цэгээс дээж авах үйл явцыг сорьц шинжлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцан гүйцэтгэсэн болно.*

Шинжилгээ хийсэн:
ЭШДА: Магистр (M.Sc) ____________ /Т.Энхжаргал/

Шалгаж, дүгнэсэн:
УШ лабораторийн эрхлэгч: Доктор (Ph.D) ____________ /Ч. Жавзан/

Зураг 19. *Адрага багийн Жугант Цацын толгойн булгийн усны химийн шинжилгээний тодорхойлолт*




*Зураг 20. Гадаргын ус*




*Зураг 21. Гүний ус*

## 2.9. Инженер геологийн нөхцөл

***Геоморфологийн тогтоц:*** Монгол орны газар нутгийн геологийн түүх, хотгор гүдгэрийн хэв шинжийг авч үзэхэд геоморфологийн хэд хэдэн гол мужийг ялган тогтоож болох юм. Үүнд: 1. Хөвсгөлийн уулс, 2. Хангай-Хэнтийн уулст өндөрлөг, 3. Монгол ба Говь алтайн уулт тогтолцоо, 4. Алтайн ар говийн цав толгод, 5. Алтайн өвөр говийн цав толгод, 6. Хянганы уулс болно. Үүнээс Баян-Адарга сум нь геоморфологийн мужлалтаар Монголын дорнод хэсгийн өндөрлөг талд хамрагдана. Монголын дорнод хэсгийн өндөрлөг тал, далайн түвшнээс дээш нэлээн өргөгдсөн бөгөөд ихэнхдээ ухаа гүвээт гадаргатай юм. Мөн бэсрэг уулс энд тэнд жижиг тарамцагийн хэлбэрээр оршино. Янз бүрийн хэмжээний хотос хонхор цөөнгүй тохиолдоно. Зарим газарт эртний хөндий тодорхой үзэгдэнэ. Геологийн тогтцод дунд төрмөлийн ба гуравдагч галавын хурдас зонхилно. Цэгмэд.Ш "Монгол орны физик газарзүй" УБ., 1967, Шагдар.Ш "Монголын газарзүйн нэрийн товч толь бичиг" УБ., 2007.



*Зураг 22 . Геоморфологийн зураг*

***Цэвдгийн тархалт:*** Сумын нийт нутаг дэвсгэрийн 76.8 хувь нь олон жилийн цэвдэг чулуулаг ховор алаг цоог тархалттай, 21.3 хувь нь олон жилийн цэвдэг чулуулаг тохиолдлын тархалттай, 1.9 хувь нь олон жилийн цэвдэг чулуулаг алаг цоог тархалттай байна.

*Хүснэгт 27. Сумын олон жилийн цэвдгийн тархалтын талбай*

| № | Цэвдгийн тархалт | Талбай, га | Эзлэх хувь |
|---|---|---|---|
| 1 | Олон жилийн цэвдэг чулуулаг алаг цоог тархалттай | 5729.5 | 1.9 |
| 2 | Олон жилийн цэвдэг чулуулаг тохиолдлын тархалттай | 64458.3 | 21.3 |
| 3 | Олон жилийн цэвдэг чулуулаг ховор алаг цоог тархалттай | 232419.5 | 76.8 |




*Зураг 23. Сумын олон жилийн цэвдгийн тархалтын зураг*

# ГУРАВ. НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ

## 3.1 Хүн ам зүй

Хүн амын тоог сумын нийт хүн ам болон сүүлийн арван жилийн статистик мэдээлэлд үндэслэн бэлтгэлээ. Энэхүү мэдээллийг Статистикийн мэдээллийн нэгдсэн сангаас авч боловсруулсан /2020оны байдлаар/.

### *3.1.1 Хүн амын тоо ба өрхийн байдал*

Хэнтий аймгийн Баян-Адарга сум нь 2021 оны байдлаар нийт 2527 хүн, 786 өрхтэй байна. Нийт хүн амын 51.4 хувийг эрэгтэйчүүд, 48.5 хувийг эмэгтэйчүүд эзэлдэг байна.

*Хүснэгт 28. Хүн амын хүснэгт, сүүлийн 10 жилээр*

| Үзүүлэлт | | Оноор | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020 | 2021 |
| Нийт | Тоо | 2343 | 2319 | 2410 | 2418 | 2394 | 2496 | 2524 | 2462 | 2483 | 2527 |
| | Өсөлтийн хувь | - | -1 | 4 | 0 | -1 | 4 | 1 | -2 | 1 | 2 |
| Хүйс | Эрэгтэй | 1165 | 1151 | 1220 | 1229 | 1211 | 1262 | 1279 | 1254 | 1275 | 1300 |
| | Эмэгтэй | 1178 | 1168 | 1190 | 1189 | 1183 | 1234 | 1245 | 1208 | 1208 | 1227 |
| | Харьцаа | 99 | 99 | 103 | 103 | 102 | 102 | 103 | 104 | 106 | 106 |
| Сумын төвийн иргэд | | | | 908 | 887 | 863 | 871 | 863 | 839 | 822 | 838 |
| Хөдөөгийн иргэд | | | | 1502 | 1531 | 1531 | 1625 | 1661 | 1623 | 1661 | 1689 |
| Хувийн жин | Сумын төв | - | - | 38 | 37 | 36 | 35 | 34 | 34 | 33 | 33 |
| | Хөдөө | - | - | 62 | 63 | 64 | 65 | 66 | 66 | 67 | 67 |

Хүснэгтээс үзэхэд хүн амын тоо 2018 он хүртэл тогтмол өссөн байна. Түүнчлэн 2019 онд хүн амын тоо -2 хувиар буурсан байсан. 2021 оны байдлаар хүн амын тоо өмнөх оноосоо 1.8 хувиар өссөн байна.

Хүн амыг хүйсээр нь харьцуулж үзвэл сүүлийн 2016-2021 оны хооронд эрэгтэйчүүд илүү буюу хүйсийн харьцаа нь 102-106 байсан байна. Харин эмэгтэйчүүд 2016 оноос хойш тогтмол өсч 106 гэсэн харьцаатай байна.




*Диаграмм 12. Хүн амын хүйсийн харьцаа*

Баян-Адарга сумын хүн амын өсөлтийн хувийг 10 жилээр харьцуулахад хүн амын тогтмол өсөлт эсвэл тогтмол буурралт ажиглагдахгүй байгаа хэдий ч 2014 оноос 2018 оны хооронд өсөлттэй байна. Өсөлтийн хувийг сүүлийн 10 жилийн дунджаар жилд дунджаар 0.9 хувиар өссөн байна. Үүнийг цаашдын 5-7 жилийн төлөвлөгөөгөөр тооцоолоход 205 онд 2638 болон өсөх хандлагатай байна.

*Хүснэгт 29. Хүн амын өсөлт*

| Он | 2012 | 2020 | Өсөлтийн хувь | 2025 | 2027 |
|---|---|---|---|---|---|
| **Нийт хүн ам** | 2343 | 2527 | 0.9 | 2638 | 2707 |

Мөн сумын төвд нийт иргэдийн 33.2 хувь амьдарч байна. Энэ нь өмнөх оноос 1.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Хүн амын тоо өссөн хэдий ч суурин газар амьдрах иргэдийн хувийн жин багассан байна. Хүн амын нягтралын хувьд сумын хэмжээнд 1 хүн ноогдох газар 0.01 км$^2$ байна.

*Хүснэгт 30. Хүн амын нягтрал, хүн/км.кв*

| Огноо | Огноо | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2014 | 2015 | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020 | 2021 |
| **Хүн амын тоо** | 2410 | 2418 | 2394 | 2496 | 2524 | 2462 | 2483 | 2527 |
| **Нягтрал** | 0.01 | 0.01 | 0.01 | 0.01 | 0.01 | 0.01 | 0.01 | 0.01 |

Хүн амыг багийн хэмжээнд авч үзвэл Төвийн баг сүүлийн 10 жилд хамгийн их хүнтэй бөгөөд энэ нь суурин газарт амьдрах иргэд их байгааг харуулж байна. 2021 оны жилийн эцсийн байдлаар 1-р баг 647 хүнтэй, 2-р баг хамгийн бага буюу 440 хүнтэй, 2-р баг 602 хүнтэй, 4-р баг хамгийн их хүнтэй буюу 838 хүн амтай тус тус байна.

Сумын хэмжээнд сүүлийн жилүүдэд  хамгийн бага хүн амтай байсан жил нь 2013 онд 2319 хүн амтай байсан ба хамгийн их хүн амтай байсан жил нь 2021 онд 2527 хүн бүртгэгдсэн нь хүн амын өсөлт нэмэгдэж байгааг харуулж байна.

Хүн амын суваргаар хүн амыг насны бүлэг болон хүйсээр нь гаргалаа. Хүн амын хамгийн их хувийг эрэгтэйчүүдээс 0-4 насны хүүхдүүд эзэлж байна. Харин эмэгтэйчүүдээс 5-9 насны хүмүүс эзэлж байна. Харин хамгийн бага хувийг эрэгтэйчүүдээс 65-69 насны хүмүүс эзэлж байгаа бол эмэгтэйчүүдээс хамгийн бага хувийг 65-69 насны хүмүүс байна. Хүйсийн байдлаар эрэгтэйчүүд 1227 бол эмэгтэйчүүд 1300 хүн байгаа хэдий ч эрэгтэйчүүд залуу хүмүүс ихэнх хувийг эзэлж байна.




*Диаграмм 13. Хүн амын суварга*

Хүн амын багаар нь авч үзвэл хамгийн их хүн амтай баг нь сумын төвийн буюу Дуурлиг баг 838 хүн амтай байгаа ба тус баг нь 2014 оноос хүн амын тоо буурсан байна.

*Хүснэгт 31. Багийн хүн амын тоо, сүүлийн 10 жилээр*

| № | Багийн нэр | 2014 | 2015 | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020 | 2021 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Баян-Адарга | 2410 | 2418 | 2394 | 2496 | 2524 | 2462 | 2483 | 2527 |
| 2 | 1-р баг, Сайхан | 576 | 586 | 583 | 603 | 628 | 614 | 628 | 647 |
| 3 | 2-р баг, Жаргалант | 420 | 420 | 441 | 452 | 456 | 435 | 447 | 440 |
| 4 | 3-р баг, Адарга | 506 | 525 | 507 | 570 | 577 | 574 | 586 | 602 |
| 5 | 4-р баг, Дуурлиг | 908 | 887 | 863 | 871 | 863 | 839 | 822 | 838 |




*Диаграмм 14. Багийн хүн амын тоо*

Одоогийн хүн амын тоог 2014 онтой харьцуулахад Сайхан баг 576 хүнтэй байсан бол 2021 оны байдлаар 647 хүн болж 71 хүнээр өссөн, Жаргалант баг 420 хүнтэй байсан бол 440 болж 20 хүнээр өссөн, Адарга баг 506 хүнтэй байсан бол 602 болж 86 хүнээр өссөн, төвийн баг буюу Дуурлиг баг 908 хүнтэй байсан бол 2021 онд 838 иргэнтэй болж 70 хүнээр буурсан үзүүлэлттэй байна. Үүнээс үзэхэд хөдөөний багийн хүн амын тоо өсөлттэй байгаа нь харагдаж байна.

*Хүн ам зүйн ачаалал:* Хөдөлмөрийн насны 100 хүнд ногдох тэжээгдэгчийн тоо /15-аас доош, 65 ба түүнээс дээш насны хүн амын тоо/ буюу хөдөлмөрийн бус насны хүн амын нийгэмд үзүүлж буй ачааллыг хүн амын насны бүлгийн бүтцээр илэрхийлсэн үзүүлэлт юм.

*Хүснэгт 32. Хүн амд хөдөлмөрийн насны хүмүүсийн эзлэх хувь*

| **Нийт хүн амын тоо** | | **Үүнээс: насны бүлэг** | | | | | **Хөдөлмөрийн насны хүн ам** |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 0-14 | 15-29 | 30-54 | 55-69 | 70+ | 15-65 |
| 2021 | 2527 | 768 | 625 | 810 | 260 | 64 | 1654 |
| Эзлэх хувь | | 30.4 | 81.4 | 129.6 | 32.1 | 24.6 | 2584.4 |

Тус суманд сүүлийн 10 жилд 531 хүүхэд шинээр төрж, 140 хүн нас барж ердийн цэвэр өсөлт 3.3-66.6 байна.

*Хүснэгт 33. Хүн амын ердийн цэвэр өсөлт*

| **Үзүүлэлт** | **Он** | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | **2013** | **2014** | **2015** | **2016** | **2017** | **2018** | **2019** | **2020** | **2021** |
| **Нийт хүн ам** | 2319 | 2410 | 2418 | 2394 | 2496 | 2524 | 2462 | 2483 | 2527 |
| **Төрсөн хүүхэд** | 53 | 56 | 56 | 49 | 54 | 53 | 72 | 77 | 61 |
| **Нас барсан иргэд** | 18 | 11 | 13 | 10 | 12 | 21 | 20 | 17 | 18 |
| **Ердийн цэвэр өсөлт** | 15.1 | 18.7 | 17.8 | 16.3 | 16.8 | 12.7 | 21.1 | 24.2 | 17.0 |
| **Өсөлт хувь** | - | 23.7 | -4.8 | -8.4 | 3.3 | -24.7 | 66.6 | 14.4 | -29.6 |

Сумын хэмжээнд өрхийн тоо жил бүр харилцан адилгүй хэмжээгээр өсөж буурсан үзүүлэлттэй байна. Сүүлийн 10 жилийн статистикийн мэдээнээс үзэхэд өрхийн тоо 2021 онд хамгийн их 786 хүрсэн байна. 2013 он хамгийн бага буюу 687 өрхтэй байсан байна. Харин төвийн нэг өрхөд дунджаар 4 иргэн ноогдож байна. Сүүлийн 9 жилийн хугацаанд нэг өрх дунджаар 3-4 иргэнтэй байна.

*Хүснэгт 34. Нийт өрхийн тоо, сүүлийн 9 жилээр*

| **Баг, хороо** | **2013** | **2014** | **2015** | **2016** | **2017** | **2018** | **2019** | **2020** | **2021** |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1-р баг, Сайхан | 156 | 164 | 172 | 178 | 186 | 196 | 194 | 200 | 202 |
| 2-р баг,Жаргалант | 121 | 128 | 129 | 135 | 139 | 145 | 140 | 144 | 144 |
| 3-р баг, Адарга | 133 | 138 | 145 | 145 | 161 | 167 | 168 | 167 | 169 |
| 4-р баг, Дуурлиг | 277 | 273 | 280 | 273 | 277 | 279 | 270 | 260 | 271 |
| **НИЙТ** | 687 | 703 | 726 | 731 | 763 | 787 | 772 | 771 | 786 |
| Өсөлтийн хувь | | 2.3 | 3.3 | 0.7 | 4.4 | 3.1 | -1.9 | -0.1 | 1.9 |




*Диаграмм 15. Өрхийн тоо, багаар*

### *3.1.2 Хүн амын амьжиргааны түвшин ба орлого*

Хүн амын амьжиргааны түвшин судлахдаа өрхийн ам бүлийн гишүүдийн тоо, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, өрхийн тэргүүлэгчдийн шинж чанар, боловсролын байдал, ажил эрхлэлт, орон сууцны нөхцөл, үйлчилгээ, удаан хэрэгцээт бараа, нийгмийн үйлчилгээний хүртээмж зэрэг үзүүлэлтээр амьжиргааны түвшинд нөлөөлөх үзүүлэлтийг сонгосон.

*Хүснэгт 35. Нийт өрхөд ноогдох хүн амын тоо, сүүлийн 10 жилээр*

| Он | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020 | 2021 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Сумын дүн | 690 | 687 | 703 | 726 | 763 | 763 | 787 | 772 | 771 | 786 |
| Нэг өрхөд оногдох ам бүл | 3.4 | 3.4 | 3.4 | 3.3 | 3.1 | 3.2 | 3.3 | 3.1 | 3.2 | 3.2 |

Сумын нийт өрхийн тоо 786 байгаа бөгөөд үүнээс 271 өрх сумын төвд, 515 өрх хөдөөд амьдардаг.

Нийтийн орон сууцны зориулалттай орон сууц байхгүй. Сууцны хамгийн их хувийг буюу 69.3 хувийг гэрт амьдардаг өрх эзэлж байна. Үлдсэн хувь нь байшинд амьдарч байна.

*Хүснэгт 36. Сумын өрхийн тоо, сууцны төрлөөр*

| Байршил | Бүгд | Үүнээс | | |
|---|---|---|---|---|
| | | Гэр | Байшин | Зориулалтын бус |
| Нийт | | 535 | 234 | 3 |

### *3.1.3. Хүнсний хэрэгцээт байдал*

Тус сумын хүн амын хүнсний хэрэгцээг хангахад хүн ам хэрэгцээний өсөлтөөс, орон нутгийн хөгжлийн өсөлтийг тусгасан байх хэрэгтэй юм.

Хүн амыг насны бүлэг, эрхэлж байгаа ажил төрөл, эрэгтэй, эмэгтэй хүйсийн байдлаар нь бүлэглэж нэгж хүнд хоногт шаардагдах калорийн хэмжээг тогтоосон нормоор тооцож үзэхэд аймгийн нэг хүнд хоногт дунджаар 2864.5 калори бүхий хүнс, тэжээл хэрэглэх

шаардлагатай байна. Үүнийг хангахад 10 хувийн нэмэгдэл нөөцтэй байх нь зүйтэй гэж үзвэл 2864.5 калорийн илчлэг өгөх хүнсний нөөцтэй байх хэрэгцээ гарна.

*Хүснэгт 37. Нэг хүнд шаардагдах хүнсний илчлэгийн хэмжээ*

| № | Хүнсний бүтээгдэхүүний төрөл | 1 хүний хэрэгцээний норм | | Хоногт оногдох шимт бодис, илчлэг | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Хоногт /гр/ | Жилд /кг/ | Ураг | Өөх тос | Нүүрс ус | Илчлэг |
| 1 | Сүү-сүүн бүтээгдэхүүн | 233 | 85.0 | 23.80 | 34.30 | 30.80 | 542.85 |
| 2 | Цөцгийн тос | 20 | 7.3 | - | 19.01 | - | 176.83 |
| 3 | Мах, махан бүтээгдэхүүн | 374 | 136.5 | 28.42 | 38.70 | - | 476.44 |
| 4 | Өндөг | 30 | 11.0 | 11.83 | 1.42 | - | 61.72 |
| 5 | Загас-загасан бүтээгдэхүүн | 4.4 | 1.6 | 0.40 | 0.28 | - | 4.24 |
| 6 | Ургамлын тос | 225 | 82.1 | 0.03 | 4.93 | - | 45.95 |
| 7 | Гурил- Гурилан бүтээгдэхүүн | 770 | 281.1 | 32.17 | 2.23 | 230.13 | 1096.20 |
| 8 | Будаа | 269 | 98.2 | 2.25 | 0.29 | 23.02 | 105.92 |
| 9 | Төмс | 123 | 44.9 | 1.68 | - | 19.60 | 87.25 |
| 10 | Хүнсний ногоо | 28 | 10.2 | 1.71 | - | 5.76 | 30.61 |
| 11 | Сахар, чихрийн зүйл | 92 | 33.6 | - | - | 56.99 | 233.66 |
| 12 | Жимс, жимсгэнэ | 265 | 96.7 | 10.03 | 0.16 | 0.25 | 2.88 |
| 13 | Буурцагт ургамал | 84 | 30.7 | 1 | | 20 | |
| | Бүгд | 2517.4 | 918.9 | 113.32 | 101.32 | 386.55 | 2864.55 |
| | Калори | - | - | 430.616 | 891.616 | 1542.32 | 2864.55 |

Нэг хүнд хоногт буюу жилд оногдох хүнсний бүтээгдэхүүний өсөлт нь хүн амын хүнсний хэрэгцээний өсөлтийг тодорхойлох хэмжигдэхүүн болж байна. Баян-Адарга сумын хүн амд шаардагдах хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хэрэгцээг хүнсэндээ ихэвчлэн хэрэглэж буй мах, сүү, гурил гэх зэрэг 13 гол бүтээгдэхүүний нэр төрөл тус бүрээр төлөвлөлтийн 3 үе шатуудаар тодорхойллоо.

*Хүснэгт 38. Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хэрэгцээ, хэтийн төлөв*

| № | Хүнсний бүтээгдэхүүний төрөл | Жишсэн 1 хүний жилийн хүнсний хэрэгцээ /кг/ | Хүнсний бүтээгдэхүүнийг нэг бүтээгдэхүүнд шилжүүлэн тооцох коэффициент | | 2018-2020 он | | 2021-2025 он | | 2026-2030 он | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Хүн амын тоо | Хүнсний хэрэгцээ /кг/ | Хүн амын тоо | Хүнсний хэрэгцээ /кг/ | Хүн амын тоо | Хүнсний хэрэгцээ /кг/ |
| 1 | Мах, махан бүтээгдэхүүн | 73 | 5 хошуу малын мах | 1 | 17053 | 1244869 | 18268 | 1333564 | 19484 | 1422332 |
| | | 73 | Гахай шувуу загасны мах | 1 | 17053 | 1244869 | 18268 | 1333564 | 19484 | 1422332 |
| 2 | Сүү | 54.8 | Үйлдвэрийн аргаар боловсруулсан сүү | 1 | 17053 | 934504.4 | 18268 | 1001086.4 | 19484 | 1067723.2 |
| | | 54.8 | Уламжлалт аргаар боловсруулсан сүү | 1 | 17053 | 934504.4 | 18268 | 1001086.4 | 19484 | 1067723.2 |
| 3 | Сүүн бүтээгдэхүүн | 73 | | | 17053 | 1244869 | 18268 | 1333564 | 19484 | 1422332 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | Гурил | 36.5 | Буудайн гурил | 1 | 17053 | 622434.5 | 18268 | 666782 | 19484 | 711166 |
| 5 | Гурилан бүтээгдэхүүн | 80.3 | талх | 0.74 | 17053 | 1013323.3 | 18268 | 59422 | 19484 | 1157778.2 |
| 6 | Төрөл бүрийн будаа | 28.5 | | 1 | 17053 | 486010.5 | 18268 | 520638 | 19484 | 555294 |
| 7 | Сахар, чихрийн зүйл | 8.4 | | 1 | 17053 | 143245.2 | 18268 | 153451.2 | 19484 | 163665.6 |
| 8 | Төмс | 51.1 | | 1 | 17053 | 871408.3 | 18268 | 933494.8 | 19484 | 995632.4 |
| 9 | Хүнсний ногоо | 73 | | 1 | 17053 | 1244869 | 18268 | | 19484 | 1422332+ |
| 10 | Жимс, жимсгэнэ | 65.7 | | 1 | 17053 | 1120382.1 | 18268 | 1200207.6 | 19484 | 120098.8 |
| 11 | Буурцагт ургамал | 32.9 | | 1 | 17053 | 561043.7 | 18268 | 601017.2 | 19484 | 641023.6 |
| 12 | Өндөг | 6.9 | | 1 | 17053 | 117665.7 | 18268 | 126049.2 | 19484 | 134439.6 |
| 13 | Хүнсний тос | 9.1 | | 1 | 17053 | 155182.3 | 18268 | 166238.8 | 19484 | 177304.4 |

## 3.2 Хөдөө аж ахуйн салбар

### *3.2.1 Мал аж ахуйн салбар*

Баян-Адарга сумын эдийн засгийн нэг хүчин зүйл нь мал аж ахуйн салбар юм. 2021 оны эцсийн тооллогоор 217990 толгой мал тоолуулсаны 60 тэмээ, 12080 адуу, 18830 үхэр, 114560 хонь, 72450 ямаа байна.

*Хүснэгт 39. Малын тооны өсөлт 2013-2020 оны байдлаар*

| № | Малын төрөл | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020 | 2021 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **1** | **Бүгд** | **86570** | **104770** | **115830** | **129750** | **163710** | **182350** | **195180** | **188110** | **217990** |
| 2 | Адуу | 6140 | 6750 | 7100 | 7760 | 9490 | 10390 | 10670 | 10770 | 12080 |
| 3 | Үхэр | 8650 | 10160 | 11330 | 11820 | 14600 | 16110 | 17400 | 16630 | 18830 |
| 4 | Тэмээ | 80 | 70 | 60 | 60 | 60 | 70 | 70 | 70 | 60 |
| 5 | Хонь | 41230 | 51340 | 58150 | 65560 | 84100 | 92470 | 98660 | 94520 | 114560 |
| 6 | Ямаа | 30470 | 36460 | 39200 | 44560 | 55460 | 63310 | 68380 | 66120 | 72450 |

Сүүлийн 9 жилийн байдлаар малын тоог авч үзэхэд 2013-2019 онуудад тогтмол өссөн үзүүлэлттэй байна. 2020 оны хувьд өмнөх оноосоо 7070 толгой мал буюу -3.6 хувиар буурсан бол 2021 оны байдлаар 217990 болж 15.8 хувиар өссөн байна.




*Диаграмм 16. Малын тооны өсөлт*

2021 оны байдлаар 76550 төл бойжуулсан нь өмнөх оноос 860 толгой малаар буюу 1.1 хувиар буурсан байна. Нийт төлийн 0.01 хувь нь ботго, 3.3 хувь нь унага, 6.8 хувь нь тугал, 55.4 хувь нь хурга, 34.5 хувь нь ишиг байна.

*Хүснэгт 40. Сумын бойжуулсан төл*

| № | Багийн нэр | Бойжуулсан төл | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020 | 2021 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 1-р баг, Сайхан | Бойжуулсан ботго | | 3 | 5 | 10 | 10 | | 10 | 10 | |
| 2 | | Бойжуулсан унага | 1 | 721 | 539 | 590 | 810 | 910 | 940 | 940 | 990 |
| 3 | | Бойжуулсан тугал | 730 | 792 | 947 | 920 | 1 | 1240 | 1360 | 1210 | 1390 |
| 4 | | Бойжуулсан хурга | 7130 | 7598 | 8673 | 9450 | 10180 | 11420 | 13210 | 15480 | 13810 |
| 5 | | Бойжуулсан ишиг | 5150 | 5572 | 5768 | 6620 | 7210 | 6600 | 9140 | 9940 | 7390 |
| 6 | 2-р баг, Жаргалант | Бойжуулсан ботго | 10 | 3 | 3 | | 10 | 10 | 10 | 10 | 10 |
| 7 | | Бойжуулсан унага | 40 | 491 | 503 | 550 | 60 | 810 | 680 | 650 | 720 |
| 8 | | Бойжуулсан тугал | 740 | 857 | 979 | 950 | 1190 | 140 | 1430 | 1190 | 1270 |
| 9 | | Бойжуулсан хурга | 3950 | 4545 | 6467 | 7310 | 8950 | 10580 | 8720 | 10520 | 12580 |
| 10 | | Бойжуулсан ишиг | 2680 | 3234 | 4096 | 4640 | 5610 | 6720 | 5140 | 7970 | 8730 |
| 11 | 3-р баг, Адарга | Бойжуулсан ботго | | | 10 | | | | | | |
| 12 | | Бойжуулсан унага | 170 | 216 | 236 | 280 | 390 | 430 | 320 | 420 | 550 |
| 13 | | Бойжуулсан тугал | 730 | 818 | 905 | 990 | 1350 | 1530 | 1600 | 1750 | 1720 |
| 14 | | Бойжуулсан хурга | 2900 | 3112 | 4200 | 5490 | 6820 | 9910 | 9420 | 9300 | 11260 |
| 15 | | Бойжуулсан ишиг | 2290 | 2417 | 3262 | 4010 | 4190 | 6510 | 5100 | 6520 | 7600 |
| 16 | 4-р баг, Дуурлиг | Бойжуулсан ботго | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 17 | | Бойжуулсан унага | 70 | 76 | 99 | 130 | 210 | 210 | 20 | 230 | 270 |
| 18 | | Бойжуулсан тугал | 480 | 548 | 637 | 640 | 73 | 850 | 850 | 790 | 850 |
| 19 | | Бойжуулсан хурга | 2320 | 3105 | 3304 | 4740 | 5480 | 5410 | 5010 | 5800 | 4740 |
| 20 | | Бойжуулсан ишиг | 1450 | 1777 | 2378 | 2490 | 2580 | 3280 | 2790 | 2960 | 2670 |
| **21** | **Сумын нийт** | **Бойжуулсан ботго** | **10** | **6** | **18** | **10** | **20** | **10** | **20** | **20** | **10** |
| **22** | | **Бойжуулсан унага** | **281** | **1504** | **1377** | **1550** | **1470** | **2360** | **1960** | **2240** | **2530** |
| **23** | | **Бойжуулсан тугал** | **2680** | **3015** | **3468** | **3500** | **2614** | **3760** | **5240** | **4940** | **5230** |
| **24** | | **Бойжуулсан хурга** | **16300** | **18360** | **22644** | **26990** | **31430** | **37320** | **36360** | **41100** | **42390** |
| **25** | | **Бойжуулсан ишиг** | **11570** | **13000** | **15504** | **17760** | **19590** | **23110** | **22170** | **27390** | **26390** |
| **Нийт** | | | **30841** | **35885** | **43011** | **49810** | **55124** | **66560** | **65750** | **75690** | **76550** |

Сумын хэмжээнд том малын зүй бус хорогдол 2021 онд хамгийн их буюу 21430 толгой мал зүй бусаар хорогдсон байна. Тайлант оны байдлаар Сайхан баг хамгийн их 4970 толгой мал хорогдсон бөгөөд Жаргалант баг 770 толгой мал, Адарга баг 1310 толгой мал, Дуурлиг баг 690 толгой малаар тус тус хорогдсон байна.

*Хүснэгт 41. Том малын зүй бус хорогдол*

| № | Багийн нэр | Малын төрөл | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020 | 2021 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 1-р баг, Сайхан | Адуу | 10 | 40 | 70 | 40 | 30 | 50 | 70 | 170 | 160 |
| 2 | | Үхэр | - | 10 | 60 | 20 | 50 | 70 | 110 | 810 | 210 |
| 3 | | Тэмээ | - | - | - | - | - | - | - | - | - |
| 4 | | Хонь | 20 | 40 | 330 | 180 | 280 | 580 | 670 | 4300 | 1950 |
| 5 | | Ямаа | 20 | 30 | 240 | 100 | 290 | 300 | 480 | 4210 | 2650 |
| 6 | 2-р баг, Жаргалант | Адуу | 40 | 40 | 50 | 10 | 40 | 70 | 210 | 260 | 100 |
| 7 | | Үхэр | 30 | 10 | 30 | 20 | 100 | 50 | 120 | 1270 | 120 |
| 8 | | Тэмээ | - | - | - | - | - | - | - | - | - |
| 9 | | Хонь | 190 | 80 | 140 | 50 | 270 | 390 | 690 | 2320 | 290 |
| 10 | | Ямаа | 230 | 60 | 90 | 40 | 230 | 250 | 510 | 1810 | 260 |
| 11 | 3-р баг, Адарга | Адуу | 20 | 10 | 20 | 10 | 20 | 50 | 60 | 110 | 20 |
| 12 | | Үхэр | 40 | 10 | 50 | 20 | 50 | 130 | 220 | 670 | 70 |
| 13 | | Тэмээ | - | - | - | - | - | - | - | - | - |
| 14 | | Хонь | 80 | 260 | 120 | 50 | 290 | 530 | 1270 | 1590 | 560 |
| 15 | | Ямаа | 90 | 140 | 100 | 90 | 280 | 410 | 1030 | 1470 | 660 |
| 16 | 4-р баг, Дуурлиг | Адуу | 10 | 30 | 10 | 10 | 10 | 10 | 20 | 100 | 40 |
| 17 | | Үхэр | 20 | 20 | 10 | 20 | 30 | 70 | 40 | 340 | 80 |
| 18 | | Тэмээ | - | - | - | - | - | - | - | - | - |
| 19 | | Хонь | 30 | 120 | 170 | 250 | 140 | 510 | 230 | 1280 | 320 |
| 20 | | Ямаа | 20 | 80 | 80 | 140 | 70 | 200 | 250 | 720 | 250 |
| **21** | **Сумын нэр** | **Адуу** | **80** | **120** | **150** | **70** | **100** | **180** | **360** | **640** | **320** |
| **22** | | **Үхэр** | **90** | **50** | **150** | **80** | **230** | **320** | **490** | **3090** | **480** |
| **23** | | **Тэмээ** | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **24** | | **Хонь** | **320** | **500** | **760** | **530** | **980** | **2010** | **2860** | **9490** | **3120** |
| **25** | | **Ямаа** | **360** | **310** | **510** | **370** | **870** | **1160** | **2270** | **8210** | **3820** |
| **Нийт** | | | **850** | **980** | **1570** | **1050** | **2180** | **3670** | **5980** | **21430** | **7740** |

2018-2019 онд өвчнөөр хорогдсон малын тоо өндөр байсан бол 2020 онд эрс багассан ба 2021 оны байдлаар 41 толгой мал өвчнөөр хорогдсон байна.

*Хүснэгт 42. Өвчнөөр хорогдсон малын тоо*

| № | Багийн нэр | Малын төрөл | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020 | 2021 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 1-р баг, Сайхан | Тэмээ | - | - | - | - | - | - | - | - | - |
| 2 | | Адуу | - | - | 2 | 1 | 2 | 1 | 30 | 3 | - |
| 3 | | Үхэр | - | - | 8 | 3 | 15 | 4 | 68 | 19 | - |
| 4 | | Хонь | 1 | - | 37 | 32 | 49 | 49 | 62 | 12 | - |
| 5 | | Ямаа | 6 | 2 | 44 | 16 | 31 | 40 | 60 | 23 | - |
| 6 | 2-р баг, Жаргалант | Тэмээ | - | - | - | - | - | - | - | - | - |
| 7 | | Адуу | 3 | - | - | - | 2 | - | 1 | - | - |
| 8 | | Үхэр | 1 | 3 | 15 | - | 18 | 2 | 3 | - | 1 |
| 9 | | Хонь | 13 | 12 | 37 | 10 | 34 | 15 | 23 | 28 | 4 |
| 10 | | Ямаа | 8 | 6 | 17 | | 8 | 12 | 19 | 18 | 2 |
| 11 | 3-р баг, Адарга | Тэмээ | - | - | - | - | - | - | - | - | - |
| 12 | | Адуу | - | - | 1 | - | - | - | - | 2 | - |
| 13 | | Үхэр | - | - | 2 | 3 | 4 | 4 | 3 | 13 | - |
| 14 | | Хонь | 10 | - | 1 | - | 74 | 122 | 25 | 22 | - |
| 15 | | Ямаа | - | - | - | - | 29 | 107 | 31 | 20 | - |
| 16 | 4-р баг, Дуурлиг | Тэмээ | - | - | - | - | - | - | - | - | - |
| 17 | | Адуу | - | - | - | - | - | - | - | - | - |
| 18 | | Үхэр | 8 | 3 | 3 | - | 7 | 1 | 1 | - | 17 |
| 19 | | Хонь | 27 | 5 | 67 | 63 | 13 | 6 | 23 | - | 2 |
| 20 | | Ямаа | 17 | - | 30 | - | 5 | 14 | 27 | - | 15 |
| **21** | **Сумын нийт** | **Тэмээ** | **-** | **-** | **-** | **-** | **-** | **-** | **-** | **-** | **-** |
| **22** | | **Адуу** | **3** | **-** | **3** | **1** | **4** | **1** | **31** | **5** | **-** |
| **23** | | **Үхэр** | **9** | **6** | **28** | **6** | **44** | **11** | **75** | **32** | **18** |
| **24** | | **Хонь** | **51** | **17** | **142** | **105** | **170** | **192** | **133** | **62** | **6** |
| **25** | | **Ямаа** | **31** | **8** | **91** | **16** | **73** | **173** | **137** | **61** | **17** |
| **Нийт** | | | **94** | **31** | **264** | **128** | **291** | **377** | **376** | **160** | **41** |

***Малчин өрхийн малын тоо:*** Малчин өрхийн амьжиргааг тодорхойлох нэг үзүүлэлт бол малын тоо бөгөөд нэг малчин өрхөд оногдох малын тоо юм. Нийт өрхийн тоог багийн хэмжээгээр авч үзвэл Сайхан баг хамгийн их малчин өрхтэй бөгөөд 130 өрх байна.

Тайлант оны байдлаар малчин өрхийн тоо тогтмол өссөн үзүүлэлттэй байна.

*Хүснэгт 43. Малчин өрхийн тоо*

| Багийн нэр | 2014 | 2015 | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020 | 2021 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1-р баг, Сайхан | 100 | 80 | 100 | 110 | 120 | 110 | 130 | 130 |
| 2-р баг, Жаргалант | 80 | 90 | 100 | 100 | 110 | 100 | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3-р баг, Адарга | 80 | 80 | 80 | 90 | 90 | 90 | 100 | 100 |
| 4-р баг, Дуурлиг | 20 | 20 | 30 | 30 | 30 | 30 | 40 | 50 |
| **Нийт** | **280** | **270** | **310** | **330** | **350** | **330** | **370** | **380** |




*Диаграмм 17. Малчин өрхийн тоо*

Малын тоон үзүүлэлтийг баг бүрээр малын төрлөөр дараах хүснэгтээр үзүүллээ. Хүснэгтээс үзэхэд Баян-Адарга сумын мал сүргийн бүтцэд бог мал давуу байдаг. Тэр дундаа хонин сүргийн тоо толгой нэлээдгүй байдаг байна.

*Хүснэгт 44. Багийн малын тоо*

| Багийн нэр | Малын төрөл | 2014 | 2015 | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020 | 2021 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Сайхан | Адуу | 2786 | 2906 | 3059 | 3626 | 3992 | 4347 | 4385 | 4974 |
| | Үхэр | 2655 | 2922 | 3098 | 3403 | 3880 | 4320 | 4130 | 4799 |
| | Тэмээ | 31 | 28 | 32 | 25 | 34 | 37 | 40 | 38 |
| | Хонь | 18412 | 20841 | 22486 | 27280 | 30381 | 34075 | 34185 | 41579 |
| | Ямаа | 13133 | 14192 | 15978 | 19615 | 21512 | 23787 | 23089 | 26204 |
| ***Нийт*** | | ***37017*** | ***40889*** | ***44653*** | ***53949*** | ***59799*** | ***66566*** | ***65829*** | ***77594*** |
| Жаргалант | Адуу | 2445 | 2461 | 2704 | 3261 | 3626 | 3374 | 3011 | 3212 |
| | Үхэр | 3009 | 3339 | 3334 | 4197 | 4664 | 5050 | 4482 | 4651 |
| | Тэмээ | 32 | 26 | 24 | 33 | 31 | 29 | 27 | 24 |
| | Хонь | 14431 | 15569 | 18329 | 23819 | 25574 | 24370 | 24539 | 26617 |
| | Ямаа | 9756 | 10101 | 12593 | 15351 | 17143 | 18041 | 18201 | 18557 |
| ***Нийт*** | | ***29673*** | ***31496*** | ***36984*** | ***46661*** | ***51038*** | ***50864*** | ***50260*** | ***53061*** |
| Адарга | Бүгд | 21104 | 24892 | 28862 | 40631 | 45283 | 48844 | 46861 | 57187 |
| | Адуу | 1082 | 1239 | 1384 | 1908 | 1881 | 1955 | 2408 | 2703 |
| | Үхэр | 2614 | 3014 | 3222 | 4542 | 4825 | 5183 | 5485 | 6339 |
| | Тэмээ | 3 | 4 | 3 | 3 | 4 | 5 | | |
| | Хонь | 9353 | 11615 | 14010 | 20734 | 22803 | 24299 | 22584 | 29920 |
| | Ямаа | 8052 | 9020 | 10243 | 13444 | 15770 | 17402 | 16384 | 18225 |
| ***Нийт*** | | ***21104*** | ***24892*** | ***28862*** | ***40631*** | ***45283*** | ***48844*** | ***46861*** | ***57187*** |
| Дуурлиг | Адуу | 439 | 493 | 611 | 694 | 894 | 998 | 969 | 1195 |
| | Үхэр | 1881 | 2057 | 2161 | 2460 | 2742 | 2843 | 2533 | 3038 |
| | Тэмээ | | | 1 | 1 | 1 | | | |
| | Хонь | 9139 | 10123 | 10739 | 12268 | 13710 | 15918 | 13210 | 16447 |
| | Ямаа | 5518 | 5882 | 5742 | 7049 | 8886 | 9145 | 8448 | 9465 |
| ***Нийт*** | | ***16977*** | ***18555*** | ***19254*** | ***22472*** | ***26233*** | ***28904*** | ***25160*** | ***30145*** |




*Диаграмм 18. Багийн малын тоо*

## ДӨРӨВ. СУМЫН ГАЗРЫН ТОХИРОМЖТОЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

ГХГЗЗГ-ын даргын тушаалын 2015 оны 9-р сарын 9-ний өдрийн А/200 тоот “Газрын тохиромжтой байдлын үнэлгээний аргазүй, шалгуур үзүүлэлтүүд батлах тухай” тушаалд зааснаар Баян-Адарга суманд тариалангийн газрын болон аялал жуулчлалын газрын тохиромжтой байдлын үнэлгээг дараах шалгуур үзүүлэлтүүдээр хийсэн.




*Диаграмм 19. Тариалангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд*




*Зураг 24. Сумын тариалангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний зураг*




*Диаграмм 20. Аялал жуулчлалын газрын тохиромжтой байдлын үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд*




*Зураг 25. Сумын аялал жуулчлалын газрын тохиромжтой байдлын үнэлгээний зураг*

# ТАВ. БАЯН-АДАРГА СУМЫН ГАЗАР АШИГЛАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

## 4.1. ГАЗРЫН НЭГДМЭЛ САН

Баян-Адарга сумын нутаг дэвсгэрийн талбайн хэмжээ 2012 онд ГХГЗЗГ-аас хийгдсэн Засгийн газрын 2009 оны 25 дугаар тогтоол батлагдаж Солбицлын нэгдсэн тогтолцоо өөрчлөгдсөнтэй холбогдон 709.26 га-аар нэмэгдсэнээр сумын нийт талбай 302607.6 га болж байна.

*Хүснэгт 45. Сумын газрын нэгдмэл сангийн ангиллын талбайн зөрүү*

| Газрын нэгдмэл сангийн үндсэн ангилал | Хөдөө аж ахуйн газар | Хот тосгон бусад суурин газар | Ойн сан бүхий газар | Усны сан бүхий газар | Зам шугам сүлжээний газар | Улсын тусгай хэрэгцээний газар | Нийт |
|---|---|---|---|---|---|---|---|
| Газрын нэгдмэл сангийн тайлан | 284989.74 | 793.17 | 14827.7 | 735 | 552.78 | | 301898.4 |
| Хэмжилтээр | 267759.85 | 783.64 | 28922.28 | 665.23 | 479.51 | 3997.14 | 302607.6 |
| Зөрүү + - | -17229.89 | -9.53 | 14094.58 | -69.77 | -73.27 | 3997.14 | 709.2 |

Сумын нийт талбайн 88.58 хувь буюу 267759.85 га-г хөдөө аж ахуйн газар, 0.26 хувь буюу 783.64 га талбайг хот тосгон бусад суурин газар, 9.56 хувь буюу 28922.28 га талбайг ойн сан бүхий газар, 0,22 хувь буюу 665.23 га талбайг усны сан бүхий газар, 0,16 хувь буюу 479.51 га талбайг зам шугам сүлжээний газар эзэлж байна.




*Диаграмм 21. Баян-Адарга сумын газрын нэгдмэл сангийн ангилал*




*Зураг 26. Сумын газрын нэгдмэл сангийн зураг*

## 4.2. СУМЫН ГАЗАР АШИГЛАЛТЫН ОДООГИЙН БАЙДАЛ

Баян-Адарга сум нь бэлчээрийн мал аж ахуй давамгайлдаг учраас хөдөө аж ахуйн зориулалтаар ашиглагдаж байгаа газар нийт нутаг дэвсгэрийн 77.8 хувийг, сум багийн төвүүд буюу хот, тосгон бусад суурины газар 0.4 хувь, уул уурхай газар 1.2 хувь, аялал жуулчлалын зориулалтаар 0.05 хувь, зам шугам сүлжээний газар 0.3 хувь, ойн сан бүхий газар 20.2 хувийг тус тус эзэлж байна.

*Хүснэгт 46. Сумын газар ашиглалтын талбай*

| № | ГНС-ийн ангилал | Газар ашиглалтын төрөл | Талбай, га | Эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| 1 | Хөдөө аж ахуйн газар | Бэлчээр | 263095 | 86.9 |
| 2 | | Тариалан | 4494.2 | 1.4 |
| 3 | | Өвөлжөө хаваржаа | 225.3 | 0.07 |
| 4 | | Бэлчээр дэх уст цэг | 34.5 | 0.01 |
| 5 | Хот тосгон бусад суурин газар | Сум, багийн төв | 755.1 | 0.2 |
| 6 | | Уурхайн газар | 27.2 | 0.009 |
| 7 | | Аялал жуулчлал | 1.2 | 0.0004 |
| 8 | Зам шугам сүлжээний газар | Сайжруулсан шороон зам | 0.7 | 0.0002 |
| 9 | | Ердийн шороон зам | 179.7 | 0.06 |
| 10 | | Холбоо мэдээлэл дамжуулах хүлээн авах станц, шугам | 30.0 | 0.009 |
| 11 | | Эрчим хүч дамжуулах шугам станц | 179.9 | 0.06 |
| 12 | Ойн сан бүхий газар | Ойн нөхөрлөлд олгогдсон | 24584 | 8.1 |
| 13 | | Ашиглалтгүй ойн сан бүхий газар | 8335.4 | 2.7 |
| 14 | Усны сан бүхий газар | Гол горхи | 373.1 | 0.1 |
| 15 | | Булаг шанд | 0.007 | - |
| 16 | | Нуур, цөөрөм тойром | 292.0 | 0.9 |
| **Нийт** | | | **302608** | **100** |




*Зураг 27. Сумын газар ашиглалтын зураг*

### 4.2.1. Бэлчээр ашиглалт

Баян-Адарга сумын бэлчээр ашиглалт нь уламжлалт байдлаар ашиглаж байна. Сумын хэмжээнд нийт 314 улирлын байршил бүртгэгдсэн ба үүний нь 117 нь өвөлжөө, 89 нь хаваржаа байна. Сайхан баг нь хамгийн их өвөлжөө, хаваржаатай буюу 116 бүртгэгдсэн байна.

*Хүснэгт 47. Сумын улирлын байршлын бүртгэл*

| Багийн нэр | Адарга | Дуурлиг | Жаргалант | Сайхан | Нийт |
|---|---|---|---|---|---|
| Өвөлжөө | 30 | 3 | 25 | 59 | **117** |
| Хаваржаа | 18 | 1 | 24 | 46 | **89** |
| Өвөлжөө, хаваржаа | 30 | 10 | 21 | 0 | **61** |
| Зуслан | | 1 | 9 | 4 | **14** |
| Намаржаа | | | | 2 | **2** |
| Зулсан, намаржаа | 16 | 1 | 8 | 6 | **31** |
| 4 улирал | | 1 | | | **1** |
| **Нийт** | **94** | **17** | **87** | **116** | **314** |

Сумын бэлчээрийн даацыг баг бүрээр гаргасан ба Сайхан, Адрага, Дуурлиг багийн бэлчээрийн даац хэвийн даацдаа хүрээгүй бол Жаргалант багийн бэлчээрийн даац 8 хувиар хэтэрсэн байна.

*Хүснэгт 48. Сумын бэлчээрийн даац, багаар*

| Багийн нэр | Бэлчээрийн талбай, га | Га-ийн ургац | Бэлчээрийн малд идэгдэх өвсний хэмжээ | Багтаамж, хонь толгой | Малын тоо, хонин толгойд шилжүүлснээр | Даац, хувиар |
|---|---|---|---|---|---|---|
| Сайхан | 103155.2 | 4.78 | 493081 | 82180.31 | 74908 | 91.1 |
| Жаргалант | 67157.4 | 4.81 | 323027 | 53837.849 | 58380.8 | 108.4 |
| Адрага | 82301.8 | 4.87 | 393402.604 | 65567.101 | 41151 | 62.8 |
| Дуурлиг | 11116.4 | 4.78 | 54136.868 | 9022.811 | 7668.1 | 84.9 |




*Зураг 24. Сумын бэлчээрийн даацын зураг, багаар*

Нөлөөлөлд орсон бэлчээрийн судалгааг Баян-Адарга сумын бэлчээрийн газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажлын тайланг үндэслэн гаргасан бөгөөд сумын нийт бэлчээрийн 16.63 хувь нь буюу 50310.6 га бэлчээр ямар нэг хэмжээгээр нөлөөлөлд орсон бөгөөд үүний 0.84 хувь нь их талхлагдсан, 15.02 хувь нь дунд зэрэг талхлагдсан, 0.17 хувь нь автогений нөлөөлөлтэй, 0.6 хувь нь хортон мэргэчид орсон нөлөөлөлтэй байна.

*Хүснэгт 28. Сумын нөлөөлөлд орсон бэлчээрийн талбай*

| Нөлөөлөлд орсон бэлчээр | Талбай, га | Нийт бэлчээрийн талбайд эзлэх хувь |
|---|---|---|
| Дунд зэрэг талхлагдсан | 45459.8 | 15.0 |
| Их талхлагдсан | 2533.8 | 0.8 |
| Автогенийн нөлөөлөлтэй | 511.2 | 0.1 |
| Хортон мэргэчидтэй | 1805.8 | 0.6 |
| **Нийт** | **50310.6** | **16.6** |

Сайхан багт Шуусын гол, Сайхны хөндий, Цагаан нуур орчмын бэлчээр зуны улирлын бэлчээр дунд зэрэг талхлагдсан байна. Адрага багийн нутгаар Онон гол дагуу зуслангийн нутгаар талхлагдсан байна.




*Зураг 28. Сумын элэгдэл эвдрэлд орсон бэлчээрийн зураг*

### 4.2.2. Тариалангийн газар ашиглалт

Баян-Адарга сум нь одоогийн байдлаар нийт тариалангийн 4494.28 га талбай ашиглагдаж байгаагаас 731.92 га талбай нь атаршсан талбай байна.

*Хүснэгт 49. Сумын тариалангийн газрын ашиглалт*

<table>
<tr><th>№</th><th colspan="2">Тариалангийн талбайн төрөл</th><th>Талбай, га</th></tr>
<tr><td rowspan="3">1</td><td colspan="2">Тариалсан талбай</td><td>3762.4</td></tr>
<tr><td rowspan="2">Таримлын төрөл</td><td>Төмс, хүнсний ногоо</td><td>6.6</td></tr>
<tr><td>Үр тариа</td><td>3755.7</td></tr>
<tr><td>2</td><td colspan="2">Атаршсан талбай</td><td>731.9</td></tr>
<tr><td colspan="3">Нийт</td><td>4494.3</td></tr>
</table>




*Зураг 29. Сумын тариалангийн газрын ашиглалтын зураг*

### *4.2.3. Ойн сан бүхий газрын ашиглалт*

Сумын хэмжээгээр 12 нөхөрлөл, 1 компани ойн сан бүхий газрыг гэрээгээр эзэмшиж байгаа бөгөөд нийт ойн сан бүхий газрын 55.2 хувь буюу 20768 га талбайг нөхөрлөлд олгосон байна.

*Хүснэгт 50. Сумын ойн сан бүхий газрын ашиглалт*

| № | Нөхөрлөлийн нэр | Байгуулагдсан он | Талбай, га | Үйл ажиллагааны чиглэл |
|---|---|---|---|---|
| 1 | Алдар-Анд | 2008.12.01 | 6101 | Ойн |
| 2 | Хүүш | 2010.05.15 | 5970 | Ойн |
| 3 | Цагаан чулуут | 2010.05.15 | 4385 | Ойн |
| 4 | Өлзийт хайрхан | 2010.05.15 | 1170 | Ойн |
| 5 | Шуувуут ногоон | 2012.03.23 | 1710 | Байгаль хамгаалах |
| 6 | Гучит баялаг | 2010.05.15 | 215 | Байгаль хамгаалах |
| 7 | Шинэст-Онон | 2012.03.23 | 969 | Байгаль хамгаалах |
| 8 | Онон | 2010.05.15 | 44 | Байгаль хамгаалах |
| 9 | Байгалийн өгөөж | 2010.05.15 | 1707 | Байгаль хамгаалах |
| 10 | Баян хангай | 2012.03.23 | 2313 | Байгаль хамгаалах |
| 11 | Зүүн хужиртай | 2014 | | Ойн |
| 12 | Баруун хужиртай | 2014 | | Ойн |




*Зураг 30. Сумын ойн сан бүхий газрын ашиглалтын зураг*

### *4.2.4. Уул уурхайн ашиглалт*

Сумын хэмжээнд 2022 оны байдлаар тус сумын нутагт ашиглалтын 1, хайгуулын 8 тусгай зөвшөөрөл бүртгэлтэй байна.

*Хүснэгт 51. Сумын уурхайн зориулалттай газрын ашиглалт*

| № | Үйл ажиллагааны төрөл | Эзэмшигч | Байршил | Лицензийн төрөл |
|---|---|---|---|---|
| 1 | Жонш олборлох | “Талст-орчлон” ХХК | Сумын төвөөс зүүн тийш 8 км | 2014 А 12960 |
| 2 | Хайгуулын өнгөт металл | "Батшандас" ХХК | Сумын төвөөс баруун урагш 35 км | X 14236 |
| 3 | Хайгуул алт | "Сауд гоби гоулд" ХХК | Сумын төвөөс зүүн тийш 18 км | X 13867 |
| 4 | Хайгуул | "Харанга эрдэнэс" ХХК | Сумын төвөөс зүүн хойш 32 км | X 13867 |

Бусад үйл ажиллагаа: Сумын төвөөс урагш 35 км зайд 1-р багийн нутаг “Хөлийн холбоо”-д 2011 оноос 5 нөхөрлөл гар аргаар жонш олборлох үйл ажиллагаа явуулж байгаа. 2012 оны 8-р сард сумын ИТХ-ийн тэргүүлэгчдийн 29-р тогтоолоор 25.2 га талбайг орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан. 1980-аад оны дундуур тус газарт Бэрхийн уурхай ашиглалт явуулж байжээ.




*Зураг 31. Сумын уурхайн зориулалттай газрын ашиглалтын зураг*

### *4.2.5. Аялал жуулчлалын газрын ашиглалт*

Сумын хэмжээнд сүүлийн жилүүдэд аялал жуулчлал хөгжиж байгаа бөгөөд Хүннү, Чингисийн үеийн түүх дурсгалын олдворууд түгээмэл байдаг байна. Гол үйл ажиллагаа явуулж буй аялал жуулчлалын газар нь Монгол Хатадын Өргөө юм. Энэхүү өргөөг Монголын сүүлийн хаан VIII Богд Жавзандамба хутагтын хатан Ц.Дондогдулам, Н.Гэнэнпил нар төрж өссөн нутаг гэсэн утгаар барьж байгуулсан ба дотроо Монгол төрийн үе үеийн түүхийг бүтээлцсэн Их хатадад зориулсан хүндэтгэлийн өргөө цогцолбортой болно.

*Хүснэгт 52. Сумын аялал жуулчлал, амралтын зориулалттай газрын ашиглалт*

| № | Аялал жуулчлал эрхлэх ААН, иргэн | Байгуулагдсан он | Байршил | Хүчин чадал | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Гэр | Ор |
| 1 | Ю.Ариунжаргал | 2009 | Сумын төвөөс хойш 1,5км | 6 | 15 |
| 2 | М.Аварга-нэргүй | 2010 | Сумын төвөөс баруун тийш 1км | 10 | 20 |

### *4.2.6. Тусгай хамгаалалттай газар*

Баян-Адарга суманд улсын тусгай хамгаалалтай газар Онон-Балжийн голын сав газрын 9000 га талбай хамрагддаг бөгөөд аймгийн болон орон нутгийн тусгай хамгаалалтанд авсан нийт 4 газар бүхий 12199.36 га талбай байна.

*Хүснэгт 53. Сумын тусгай хамгаалалттай газрын ашиглалт*

| Баг | Газрын нэр | Тусгай хамгаалалтад авсан үндэслэл | Тусгай хамгаалалтад авсан он, тогтоол | Талбай, га |
|---|---|---|---|---|
| Адрага | Онон-Балжын голын сав газар | Байгалийн цогцолборт газар | 2001 | 9000 |
| Дуурлиг | Дуурлиг нарс | Байгалийн унаган төрх, түүх соёлын дурсгалт зүйлийг хамгаалах | 2014/04/30 9/2-р тогтоол | 1582 |
| Адрага | Шуусын боом | Байгалийн унаган төрх, түүх соёлын дурсгалт зүйлийг хамгаалах | 2014/04/30 9/2-р тогтоол | 683 |
| Адрага | Буурлын агуй | Байгалийн унаган төрх, түүх соёлын дурсгалт зүйлийг хамгаалах | 2014/04/30 9/2-р тогтоол | 688.36 |
| Жаргалант | Арангат, Хүйтэн | Байгалийн унаган төрх, түүх соёлын дурсгалт зүйлийг хамгаалах | 2014/04/30 9/2-р тогтоол | 246 |
| **Нийт** | | | | **12199.3** |




*Зураг 32. Сумын тусгай хамгаалалттай газрын байршлын зураг*

### 4.2.7. Амьтны тархалт

Баян-Адарга сумын нутгийн ой тайгад хүдэр, халиун буга, бор гөрөөс, зэрлэг гахай, нохой зээх, шилүүс гэх мэт амьтад байх ба тал хээрийн амьтдаас бор туулай, монгол тарвага, шивэр алаг даага, хярс, үнэг, мануул, дагуур зараа, дагуур зурам, нохой элбэнх зэрэг 6 багт хамрагдах 54 зүйл хөхтөн амьтад байдгийг тогтоожээ. Сүүлийн жилүүдэд эдгээр амьтдын тоо толгой, тархац нутаг нь эрс багсаж байгаа болно. Энд шувуудаас

ховор болсон цэн тогоруу, хошуу галуу, усны цагаан сүүлт бүргэд, хонин тоодог, хар өрөв тас, хан бүргэд, зээрд шонхор зэрэг шувууд өндөглөн зусдаг ба цагаан, хар тогоруу, байгалийн нугас зэрэг шувууд нүүдлийн үедээ дайрч өнгөрдөг байна. Онон Балжийн сав газар 12 овгийн 28 зүйл загас тархсан байна.

**Хүдэр:** Хүдэр нь бугын овог, салаа туурайтны багт хамаарах ба 6-7 төрлийн мал, амьтны шинж байдлыг агуулсан өвсөн тэжээлтэн юм. Сумын хэмжээнд 2327 га талбайд тархсан хүдэр нь агнахыг хориглосон дархан цаазтай амьтан.

1980 онд 44000 байсан бол одоо Алтай Хангайн бүсэд 300 хүрэхгүй болсон байна. 1996-2001 онд жил бүр 2500-3000 тоо толгойгоор агнагдаж цөөрсөн бөгөөд одоо бараг үзэгдэхээ больсон байна.

**Буга:** Монгол орны Хангай, Хэнтий, Хөвсгөл, Их Хянганы ой бүхий нутагт тархан амьдардаг. Туурайтны овогт багтах буга 85862.37га газар ойролцоогоо тархсан байна. Бугын тоо толгой 1980 онд Монгол орны хэмжээнд 140000 байсан бол өдгөө 8000 болж буурчээ

**Бор гөрөөс:** Бор гөрөөс бугын язгуурт багтдаг ба Монгол оронд Монгол Алтайн нуруу, Хангай, Хэнтий, Хянганы уулсын ойт хээр, ойн бүсийн шилмүүст болон хар мод холимог ойгоор тархан амьдардаг. Бор гөрөөс төрсөн, дасаж зохицсон нутагтаа идэш тэжээл элбэг байгаад байвал нүүдэл хийлгүй удаан суурьшин амьдардаг.

**Зэрлэг гахай:** Хос туурайтны багтдаг улаан номд орсон зэрлэг гахай нь ойн болон зэгсний гахай гэж хоёр зүйл байх ба сумын хэмжээнд 33349.5 талбайд тархсан зэрлэг гахай нь ойн гахай юм. Зэгсний гахай нь говь цөлийн Баянбүрд, голын татам, нуур эргийн зэгс шагшуурга, бутан ширэнгэ, шугуйд амьдардаг. Хар нуур, Булган гол, Ховд голын сав, Зэрэгийн хөндий, Шаргын говьд зэгсний гахай тархсан байдаг.

**Шилүүс: М**онголын мийн овгийнхноос биеийн хэмжээгээр ирвэсийн дараа орно. шилүүс гол төлөв бүрэнхий шөнийн идэвхтэй. Ганц нэгээр амьдарна. Шилүүс, туулай, чандага, бор гөрөөс, хүдэр, хар сүүлт зээр, янгирын ишиг, аргалийн хурга, тарвага, огдой, жижиг мэрэгчид, ятуу, хөтүү, хахилаг мэтийн дунд зэргийн биетэй шувуудаар хооллоно. Тэдний үүр модны үндэс орчмын хөндий, унанги модны доор, хад чулууны ангал, завсар байрлана.



**Тарвага:** Монгол оронд Алтай, Монгол гэсэн хоёр зүйл тарвага бий. Алтайн тарвага биеэр арай том, үс ноолуур нь өтгөн, сахлаг гоёмсог, дуу нь монгол тарваганаас нарийн

шингэн байдаг. Эрдэнэмандал сумын нутагт 45548.4 га талбайд тархсан тарвага нь Монгол тарвага юм. 2006 онд тарваганы хамгийн их тархацтай газруудыг хамруулаад Төв, Баянхонгор, Өвөрхангай аймагт судалгаа явуулахад 22000 байжээ.

**Мануул:** Мануул гол төлөв бүрэнхий, шөнийн идэвхтэй. Ганц нэгээр тохиолддог, нуугдмал амьдралтай. Мануул үлийн цагаан оготно, чичүүл, огдой, барагчин, зурам, шишүүхэй зэрэг жижиг хөхтөн амьтны зэрэгцээ мөндөл, туулайн бүжин, жижиг шувуугаар хооллоно. Тарваганы ээзэнгүй орхисон нүх, хад чулууны хонгил, ангал жижиг агуй зэрэгт үүрлэнэ. (Эх сурвалж: Ч.Буянбадрах "Монгол орны лавлах" эмхэтгэл ном).




*Зураг 33. Ан амьтны тархалтын зураг*

### *4.2.8. Түүх соёлын дурсгал*

Сумын хэмжээнд нийт 17 түүх соёлын дурсгалт газар байгаагаас Буурлын агуй, Шуусын боом, Дуурлиг нарсны дурсгалт газруудыг сумын ИТХ-ын 2014 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 9/2 дугаар тогтоолоор орон нутгийн тусгай хамгаалалтад авсан байна.



*Зураг 34. Чингисийн гэрэлт хөшөө, Буурлын агуй*

*Хүснэгт 54. Сумын түүх дурсгалын газар*

| № | Баг | Түүх соёлын үл хөдлөх дурсгал | Хамгаалалтад авсан тогтоол шийдвэр | Хамгаалалтын бүс |
|---|---|---|---|---|
| 1 | Адрага | Өлийн давааны энгэрийн дөрвөлжин булш | | Тогтоосон цэгээс хааш хаашаа 500 метр |
| 2 | Сайхан | Божирын энгэрийн хөшөө чулуу | | Тогтоосон цэгээс хааш хаашаа 500 метр |
| 3 | Адрага | Бунхант гацааны хөшөө чулуу | | Тогтоосон цэгээс хааш хаашаа 500 метр |
| 4 | Адрага | Асартын хийдийн туурь | | Тогтоосон цэгээс хааш хаашаа 500 метр |
| 5 | Адрага | Буурлын агуй | Сумын ИТХ-ын 2014 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 9/2 | Дунд буурал уулыг бүхэлд нь хамгаалалтад авсан. Хааш хаашаа 3 км |
| 6 | Адрага | Мэхээрчийн булангийн булш | | Тогтоосон цэгээс хааш хаашаа 500 метр |
| 7 | Адрага | Бага Адрагын өврийн булш | | Тогтоосон цэгээс хааш хаашаа 500 метр |
| 8 | Адрага | Шуусын боомтын дурсгалт газар | Сумын ИТХ-ын 2014 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 9/2 | Тогтоосон цэгээс хааш хаашаа 500 метр |
| 9 | Адрага | Уртын адгийн чихт толгойн дөрвөлжин булш | | Тогтоосон цэгээс хааш хаашаа 500 метр |
| 10 | Адрага | Адрага овоо | | Адрага уул бүхэлдээ |
| 11 | Адрага | Элсэн хүзүүвч чулуун зэвсгийн дурсгалт газар | | |
| 12 | Сайхан | Чингисийн хэрмэн зам | | Зүүн тийшээ Норовлин сум хүртэл 30 км, баруун болон хойд, урд талд 100 метр |
| 13 | Сайхан | Усан толгойн тахилын онгон | | Тогтоосон цэгээс хааш хаашаа 200 метр |
| 14 | Жаргалант | Хүйтний хөндийн гэрэлт хөшөө | Сумын ИТХ-ын 2014 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 9/2 | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 15 | Дуурлиг | Дуурлиг нарсны Хүннү булш | | Тогтоосон хилээр |
| 16 | Дуурлиг | Хатдын өргөө | | |
| 17 | Дуурлиг | Дуурлигийн хойд талын тахилын байгууламж | | Тогтоосон цэгээс хааш хаашаа 200 метр |




*Зураг 35. Сумын түүх дурсгалын газрын зураг*

## 4.3. АЖ АХУЙН ТӨРӨЛЖИЛТИЙН СУДАЛГАА

Баян-Адарга суманд байнгын эрчимтэй үйл ажиллагаа явуулж байгаа 14 аж ахуй нэгж байгаа бөгөөд үүний 7 нь худалдаа үйлчилгээ, 2 нь газар тариалангийн чиглэлээр эрчимтэй үйл ажиллагаа явуулж байна /2016 он/.

*Хүснэгт 55. Орон нутагт амжилттай үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж*

| № | Аж ахуйн нэгжийн нэр | Үйл ажиллагаа | Эрхэлсэн жил |
|---|---|---|---|
| 1 | М.Оюунжаргал | Газар тариалан | 12 |
| 2 | Ж.Оюунбат | Газар тариалан | 7 |
| 3 | Ж.Жаргалсүрэн | Худалдаа үйлчилгээ | 9 |
| 4 | С.Бүрэнцогт | Худалдаа үйлчилгээ | 2 |
| 5 | | Худалдаа үйлчилгээ | 15 |
| 6 | | Худалдаа үйлчилгээ | 8 |
| 7 | | Худалдаа үйлчилгээ | 12 |
| 8 | Ц.Намхай | Худалдаа үйлчилгээ | 15 |
| 9 | Б.Болор-Эрдэнэ | Худалдаа үйлчилгээ | 8 |
| 10 | Д.Батбилэг | Модон эдлэл | 10 |
| 11 | Б.Гүрцог | Гэрийн мод | 9 |
| 12 | Д.Цогтбаатар | Халуун ус, дугуй засвар | 10 |
| 13 | Ө.Осгондаваа | | 6 |
| 14 | | Сүү цагаан идээ | 10 |




*Диаграмм 22. Сумын одоогийн бизнесийн чиглэл*

# ЗУРГАА. ХЭЭРИЙН СУДАЛГАА

Хэнтий аймгийн Баян-Адарга сумын "Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөөгөө"-ний хээрийг судалгааг 2 үе шаттай хийж гүйцэтгэсэн. Эхний судалгаагаг 2022 оны 06-р сарын 06 өдрөөс 2022 оны 06-р сарын 09 өдрийн хооронд хийж гүйцэтгэсэн.

Хоёр дахь хээрийн судалгааг Баян-Адарга сумын "Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө"-ний хээрийн судалгаагаар Багийн Иргэдийн Нийтийн хуралаар 2022 оны 10-р сарын 03- өдрүүдэд Жаргалант, Сайхан багуудад, 2022 оны 10- р сарын 04 өдрүүдэд Дуурлиг, Адарга багийн хурлаар хэлэлцүүлж хээрийн судалгааг хийж гүйцэтгэсэн.

## 6.1. Эхний шатны хээрийн судалгааны ажил

Хээрийн судалгааны хүрээнд Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний ажилд иргэдийн оролцоог хангаж, иргэдийн санал, хүсэлтийг тусгах зорилгоор дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

1. Уулзалт, ярилцлага, хэлэлцүүлэг хийх;
2. Төлөвлөгөөний санал асуулга авах;
3. Статистик мэдээ цуглуулах;
4. Газар ашиглалтын өнөөгийн байдлыг тодорхойлох

### *6.1.1. Уулзалт, танилцуулга*

Сумын Засаг дарга, Засаг даргын орлогч, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга, төлөөлөгчид, газрын даамал, байгаль орчны улсын байцаагч, байгаль хамгаалагч, цаг уурын мэргэжилтэн, мал үржлийн тасгийн мэргэжилтэн /малын эмч/ болон сумын холбогдох мэргэжилтнүүдтэй уулзалт зохион байгуулсан. Уулзалтаар нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний талаар мэдээлэл өгч, санал солилцон, үүнээс гарах үр дүн, ач холбогдол, үр өгөөжийг танилцуулсан.


Баянадарга
Баянадарга ............. сумын хуралд оролцогчдын нэрс, албан тушаал
(удирдлага, мэргэжилтнүүд, иргэдийн төлөөлөл,
малчдын төлөөлөл аль нь болохыг зурах)
2022 оны 6. сар 7. өдөр

| № | Овог нэр | Нас | Хүйс | Эрхэлдэг ажил (ажилгүй бол ажилгүй гэж бичнэ) | Оршин суудаг газар /Сумын төв, багийн харьяалал/ | Утасны дугаар | Гарын үсэг |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | [illegible] | 56 | Эр | [illegible] | Сумын төв. | 3883559/ | [illegible] |
| 2 | [illegible] | 38 | Эр | [illegible] | [illegible] | 9920222 | [illegible] |
| 3 | [illegible] | 32 | эр | [illegible] | [illegible] | 98112592 | [illegible] |
| 4 | [illegible] | 32 | Эм | [illegible] | [illegible] | 98971099 | [illegible] |
| 5 | [illegible] | 26 | Эр | [illegible] | [illegible] | 89006833 | [illegible] |
| 6 | [illegible] | 33 | эр | [illegible] | [illegible] | 93205550 | [illegible] |
| 7 | [illegible] | 44 | эр. | [illegible] | [illegible] | 95222586 | [illegible] |
| 8 | | | | | | | |

*Зураг 36. Сумын уулзалтад оролцсон хүмүүсийн бүртгэлийн хуудас*

*Хүснэгт 56. Уулзалт хэлэлцүүлэгт хамрагдсан иргэдийн тоо*

| № | Хурал, уулзалтын нэр | Оролцогчдын тоо | Хүйс | | Насны бүлэг | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Эр | Эм | 16-25 | 26-35 | 36-45 | 46-60 | 60 дээш |
| 1 | Баян-Адарга хэлэлцүүлэг | 7 | 6 | 1 | | 4 | 2 | 1 | |
| 2 | Санал асуулга | 90 | 46 | 44 | 7 | 23 | 19 | 37 | 4 |
| 3 | Сумын багийн хурал | 121 | 65 | 56 | 5 | 19 | 33 | 50 | 14 |
| **Нийт** | | **218** | **117** | **101** | **12** | **46** | **54** | **88** | **18** |

### 6.1.2. *Ярилцлага, хэлэлцүүлэг*

Тус сумын газар ашиглалтын өнөөгийн нөхцөл байдалд нөлөөлж буй дотоод, гадаад хүчин зүйлийг үнэн зөв тодорхойлох, газрын хэрэгцээ болон газар ашиглалтын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж газар ашиглалтын онцлогийг тодруулах үүднээс баг тус бүрээр ажиллаж зохих хэмжилт судалгааг хийлээ. Сумын иргэдийн төлөөллөөс зохих маягтын дагуу санал авч төлөвлөгөөнд тусгасан. Үүнд:

1. Малчид;
2. Газар тариалан эрхлэгчид
3. Аж ахуйн нэгж байгууллага
4. Төрийн албан хаагчид
5. Ахмад настан
6. Залуучууд;
7. Зорилтод бүлгүүд
   7.1. Сумын Засаг даргын тамгын газрын ажилтан /Удирдах болон гүйцэтгэх түвшний албан хаагчид/
   7.2. Төрийн үйлчилгээний ажилчид /Багш, эмч, туслах үйлчилгээний ажилтан гэх мэт/

7.3. Банк, санхүү, үйлдвэрлэл, үйлчилгээ, аж ахуй эрхлэгчид;

7.4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өрх толгойлсон иргэд, амьжиргааны түвшнээс доогуур орлоготой өрх

Хэлэлцүүлэгт оролцогчдоор газар, байгалийн нөөц эдэлбэрийн зүй ёсны эрх эдлэгчдийн хил заагийг тэдний харилцан зөвшилцлөөр баталгаажуулж, тогтоосон. Мөн нийгэм, эдийн засгийн эрэлт, хэрэгцээнд тулгуурлан шинээр бий болгох жуулчны бааз, отог, амралт, сувиллын газрын байршлыг тогтоох, зураглах болон тухайн сумын онцлогоос хамаарсан бусад асуудлуудыг нэмж тодорхойлж, зурагласан.

Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулахад нутгийн иргэдийн оролцоо хамгаас чухал. Төлөвлөгөө боловсруулахдаа иргэдийн оролцоог хангаж орон нутгийн хэрэгцээт байдлын үнэлгээг гаргах үүднээс малчин, тариалан эрхлэгчид, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид, мөн зорилтод бүлгийг судалгаанд хамруулсан болно.

Мөн тухайн сумын нийгэм-эдийн засаг, байгалийн нөөц, баялгийн ашиглалт, газар ашиглалттай холбоотой ярилцлага, хэлэлцүүлэг, санал асуулгын судалгаанд сумын төв суурин багийн иргэд, аж ахуйн нэгж байгууллага зэргээс түүвэрлэн санал авсан. Саналыг арга зүйн дагуу иргэд, олон нийтийн оролцоог хангаж чадахуйц хувиас авсан.





*Зураг 37. Иргэдээс авсан саналын хуудас*

### *6.1.3. Статистик мэдээ цуглуулах*

Хээрийн судалгааны үе шатанд хийгдэх нэг томоохон ажил нь төлөвлөлтийн арга хэмжээнүүдэд шаардлагатай нийгэм, эдийн засгийн мэдээг цуглуулах юм. Нийгэм эдийн засгийн мэдээний үзүүлэлтүүдийг сүүлийн 5-10 жилээр байрлалд суурилуулан авсан. Нийгэм, эдийн засгийн мэдээллийг нарийвчлалаас нь хамааруулсан цуглуулсан ба илүү нарийвчилсан мэдээллийг холбогдох аргачлал, зааврын дагуу тооцоолж авсан.

Нийгэм эдийн засгийн мэдээг арга зүйн зааврын дагуу 10 үндсэн хэсэг болон түүнийг дэд хэлбэрээр авсан

1. *Хүн ам зүй*: "Хүн амын статистикийн үндсэн үзүүлэлт тооцох аргачлал"-ын дагуу тогтоосон мэдээллийг цуглуулсан.

2. *Хөдөлмөр эрхлэлт, амьжиргааны түвшин:* "Хүн амын статистикийн үндсэн үзүүлэлт тооцох аргачлал"-ын дагуу тогтоосон мэдээллийг цуглуулсан.

3. *Мал аж ахуй:* Мал аж ахуйн салбарын мэдээ болон бэлчээр ашиглалтын мэдээ, Бэлчээрийн даац, багтаамж, тэжээл хангамж, Хадлан, тэжээлийн ургамал, таримал бэлчээр түүнээс авч буй хадлан авч буюу иргэн, аж ахуйн, нэгжийн тоо, тэдгээрийн ашиглаж буй талбайн хэмжээ, тухайн аж ахуйн орлого, зарлагын дүнгийн мэдээ болон хураан авч буй ургацын хэмжээний мэдээллийг авсан.

4. *Газар тариалан:* Мал аж ахуй, газар тариалангийн статистик үзүүлэлтүүдийг "ХАА-н салбарын статистик үзүүлэлтийг тооцох" аргачлалын дагуу тогтооно.

5. *Материаллаг бус орлого бүхий газар ашиглалт:* Материаллаг бус орлогоор суманд оруулдаг Аялал жуулчлал, амралт сувиллын газар, түүх, соёлын дурсгалт газрын мэдээг "Аялал жуулчлалын статистикийн үзүүлэлт, тооцох аргачлал"-ын дагуу авсан.

6. *Үйлдвэр үйлчилгээ:* Нийтийн үйлчилгээ, жижиг дунд үйлдвэрлэл, бизнесийн байгууллага тэдгээрийн үйл ажиллагаа чиглэл орлого, зарлага болон бусад мэдээг цуглуулсан.

7. *Уул уурхайн үйл ажиллагаа:* Уул уурхайн ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөлтэй газар, мөн түгээмэл болон ховор тархацтай ашигт малтмал олборлолтын талаарх мэдээлэл цуглуулсан.

8. *Аялал жуулчлал:* Аялал жуулчлал, түүх, соёлын дурсгалт газрыг иргэд, аж ахуйн нэгж ашиглалт түүний ажиллагааны хэлбэр, байршлын мэдээллийг нэгтгэж цуглуулсан.

9. *Байгалийн дагалт баялгийн ашиглалт:* Байгалийн дагалдах баялаг болох жимс жимсгэнэ, самар, ан, амьтан, загас агнуур болон бусад баялаг ашиглаж байгаа иргэд, бүлэг, хэсэг, нөхөрлөл, аж ахуйн нэгжийн байршил, ашиглаж буй нөөц, баялгийн хэмжээ, орлогын хэмжээг цуглуулсан.

10. *Газрын харилцаа:* Тухайн суманд хэрэгжиж буй газар зохион байгуулалтын төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэхээр гаргасан шийдвэр, газар ашиглагч, эзэмшигч, өмчлөгчийн тоо, зүй ёсны эрхийн тоо, олж буй орлого, газрын төлбөр, татвартай холбоотой мэдээ авсан.

Дээрх цуглуулсан нийгэм, эдийн засгийн мэдээ цуглуулахдаа бэлтгэл ажлын хүрээнд бэлтгэсэн хэвлэмэл хуудас, асуулга, зургийн дагуу авсан.




Зураг 38. Нийгэм, эдийн засгийн мэдээний схем

### 3. *Хүн ам зүйн судалгаа*

- Хүн амын тоо, хүйс, насны бүлгээр, хот, хөдөөгийн хүн амаар /Сүүлийн 11 жилээр/

| | | 2011 | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020 | 2021 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Нийт | Тоо | | **2453** | **2409** | **2410** | **2408** | **2394** | **2496** | **2524** | **2462** | **2483** | **2527** |
| Хүйс | Эрэгтэй | | | **1197** | **1220** | **1224** | **1211** | **1262** | **1279** | **1254** | **1275** | **1300** |
| | Эмэгтэй | | | **1212** | **1190** | **1184** | **1183** | **1234** | **1245** | **1208** | **1208** | **1227** |
| | Харьцаа | | | **50/51** | **51/50** | **51/49** | **50/50** | **51/50** | **51/50** | **51/50** | **51/50** | **52/49** |
| Сумын төвийн иргэд | | **960** | **950** | **922** | **1264** | **1231** | **1132** | **945** | **863** | | **2462** | **2483** |
| Хөдөө | | | **1503** | **1487** | **940** | **985** | **1160** | **1249** | **1661** | | | **1689** |

- Хүн амын жилийн дундаж өсөлт /Сүүлийн 11 жилээр/

| | | 201 1 | 201 2 | 201 3 | 201 4 | 201 5 | 201 6 | 201 7 | 201 8 | 201 9 | 202 0 | 202 1 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Нийт | Өсөлтийн хувь | | | | | | | | | | | |
| | цэвэр өсөлт/бууралт | | | | | | | | | | | |

- Хүн амын тоо насны бүлэг хүйсээр /Сүүлийн 6 жилээр/

| Баг, хороо | | Сумын нийт | | 1-р баг | | 2-р баг | | 3-р баг | | 4-р баг | | ___-р баг | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Бүгд | | Эр | Эм | Эр | Эм | Эр | Эм | Эр | Эм | Эр | Эм | Эр | Эм |
| | 0-4 | 156 | 134 | 38 | 44 | 30 | 18 | 46 | 35 | 37 | 35 | | |
| | 0 | 33 | 29 | 9 | 8 | 8 | 5 | 5 | 4 | 12 | 9 | | |

### 4. *Мал аж ахуйн судалгаа*

- Сумын малын тоо өрхөөр бүрээр /А дансаар/
- Сум, багийн малын тоо/Сүүлийн 11 жилээр/

| Огноо | Төрөл | 1-р баг | 2-р баг | 3-р баг | 4-р баг | Сумын нийт |
|---|---|---|---|---|---|---|
| 2012 | Адуу | 2450 | 2170 | 1210 | 280 | 6110 |
| | Үхэр | 2070 | 2360 | 2030 | 1470 | 7930 |
| | Тэмээ | 40 | 50 | 0 | 0 | 90 |
| | Хонь | 14090 | 9690 | 6540 | 5910 | 36230 |
| | Ямаа | 9700 | 7980 | 5670 | 3610 | 29960 |
| | Нийт | 28330 | 22250 | 15450 | 11270 | 6150 |
| 2013 | Адуу | 2680 | 2190 | 940 | 340 | 6150 |
| | Үхэр | 2260 | 2570 | 2350 | 1480 | 8660 |
| | Тэмээ | 30 | 50 | 0 | 0 | 80 |
| | Хонь | 14460 | 11840 | 7850 | 7080 | 41230 |
| | Ямаа | 10890 | 8430 | 680 | 4350 | 24350 |
| | Нийт | 30310 | 17940 | 17940 | 13250 | 79440 |
| 2014 | Адуу | 2786 | 2445 | 1082 | 439 | 6752 |
| | Үхэр | 2655 | 3009 | 2614 | 1881 | 10159 |
| | Тэмээ | 31 | 32 | 3 | 0 | 66 |
| | Хонь | 18412 | 14431 | 9353 | 9139 | 51335 |
| | Ямаа | 13133 | 9756 | 8052 | 5518 | 36459 |
| | **Нийт** | **37017** | **29673** | **21104** | **16977** | **104771** |

8..3. Цэцэрлэгийн бүртгэл /Сүүлийн 6 жилээр/

| | Хэмж/нэгж | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020 | 2021 |
|---|---|---|---|---|---|---|---|
| Цэцэрлэгийн тоо | тоо | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 |
| Хүүхдийн тоо | тоо | 120 | 125 | 125 | 130 | 130 | 129 |

8..4. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын ажилчид /Сүүлийн 6 жилээр/

| Үзүүлэлт | 2015 | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020 | 2021 |
|---|---|---|---|---|---|---|---|
| СӨБ-ийн нийт ажиллагчид | 18 | 18 | 18 | 19 | 19 | 20 | 20 |
| Үндсэн багш | 5 | 5 | 5 | 6 | 6 | 7 | 7 |
| Туслах багш | 5 | 5 | 5 | 5 | 5 | 5 | 5 |
| Бусад ажилтан | 8 | 8 | 8 | 8 | 8 | 8 | 8 |

8..5. Сургуулийн мэдээлэл /Сүүлийн 6 жилээр/

| ЕБСургууль | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020 | 2021 |
|---|---|---|---|---|---|---|
| Сургуулийн багш | 26 | 25 | 24 | 24 | 24 | 24 |
| Нийт суралцагсад | 375 | 370 | 366 | 370 | 384 | 425 |
| Сургууль төгсөгчид | 42 | 54 | 40 | 38 | 26 | 51 |
| 1-р ангид элсэн суралцагч | 35 | 48 | 53 | 50 | 46 | 65 |
| Сурагч багшийн харьцаа | | | | | | |

*Зураг 39. Баян-Адарга статистик мэдээ цуглуулсан ажлын зураг*

### *6.1.4. Хил зааг, байршил тогтоох, зураглах*

Хээрийн хэмжилтийн ажлаар дараах мэдээллийг тодруулж зохих хэмжилт зураглалыг хийлээ. Үүнд:

- Өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржаа, 4-н улирлын байршлыг тулгалт хийж зурагт тэмдэглэсэн.
- Бэлчээр дэх уст цэгийн тооллого, ашиглалтын байдлын судалгааг Хөдөө аж ахуй болон байгаль орчин хариуцсан мэргэжилтнээс авч, шинээр нэмэгдсэн худаг, уст цэгийн байршлыг газар дээр нь очиж тогтоон, зурагт тэмдэглэсэн.
- Улирлын бэлчээрийн заагийг тогтоон зурагласан.
- Бэлчээр ашиглалтын улирлын хуваарийг тодорхойлж, зурагласан.
- Эрчимжсэн, хагас эрчимжсэн мал аж ахуй эрхэлж буй байдлыг зураглах цаашид эрхлэх боломжтой газрыг газар дээр нь очиж тодорхойлж, зурагласан.
- Хөдөө аж ахуйн зориулалттай барилга, байгууламжийн зориулалтаар ашиглаж буй газрын заагийг зураглах. Хөдөө аж ахуйн зориулалтаар ашиглагдаж байгаа барилга, байгууламжийн байршил, хэмжээ, зориулалтыг тулган шалгах, одоогийн ашиглалтын байдлыг тодорхойлж, бүрэн бүтэн эсэх, эвдэрч тоногдсон эсэх, байгууламжийг барьж байгуулсан огноо, хүчин чадал, багтаамж, хариуцдаг этгээд зэрэг мэдээллийг тодруулсан.
- Усжуулах шаардлагатай бэлчээрийн байршлыг тодорхойлж, зурагласан.
- Хортон мэрэгчид идэгдсэн бэлчээр, талхлагдсан бэлчээрийг тогтоон хэмжиж зурагласан.
- Амралт, сувиллын газруудын байршлыг тогтоож, аялал жуулчлал хөгжүүлэх боломжтой аяллын маршрутыг зурагласан. Мөн шинээр амралт, сувилал, жуулчны бааз бий болгох боломжтой газруудын байршлыг зуран тэмдэглэсэн.
- Аялал жуулчлалын газар, жуулчны бааз, амралт, сувиллын газар, хүүхдийн зуслан, түүх, соёлын дурсгалт газар, соёлын өв бүхий газрын байршлыг тогтоож, хил заагийг зурагласан.
- Байгалийн үзэсгэлэнт газар, түүх, соёлын дурсгалт газар, үнэт ховор үзмэр бүхий газруудыг тэмдэглэн, зурагласан.
- Улсын болон орон нутгийн тусгай хэрэгцээний газрын мэдээлэл
- Шинээр бий болсон жуулчны бааз, отог, амралт, сувиллын газрын байршил, хил заагийг тогтоон, зурагласан.
- Шашны ач холбогдолтой дурсгалт газрын байршлыг тодорхойлсон.

- Уул уурхайн нөлөөгөөр эвдэрч, доройтсон газрыг бүртгэж, газар дээр нь хил заагийг тогтоосон.
- Уст цэгийн төрөл, байршил, ашиглалт, хүчин чадлыг тодорхойлно.
- Хөв цөөрмийн байршил, хөв цөөрөм байгуулах боломжтой газрын судалгаа, саналыг тодорхойлж зурагласан.
- Шинжлэх ухаан, технологийн сорилт, туршилтын болон байгаль орчин, цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын талбайн хил заагийг зурагласан.
- Аймгийн болон сумын орон нутгийн тусгай хэрэгцээний газрын байршил, заагийг зурагласан.
- Авто замын газрын зориулалтаар ашиглаж байгаа газрын байршил, заагийг зурагласан. Үүнд:
  - Хатуу хучилттай зам
  - Засаж, сайжруулсан зам
  - Хээрийн хөрсөн зам
- Цахилгааны шугам газрын байршил, заагийг зурагласан.
- Харилцаа, холбооны шугам сүлжээний газрын байршил, заагийг зурагласан.
- Эмийн болон ховор ургамлын байршил, нөөцийг тодорхойлно.
- Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын талбайн мэдээлэл
- Түгээмэл болон ховор тархацтай ашигт малтмалын байршил, нөөцийг тодорхойлно.
- Урьд өмнө болж байсан байгалийн гамшиг, аюулт үзэгдлийн улмаас эвдэрч, өөрийн төрөлх хэв шинжийг алдсан болон ямар нэгэн байдлаар хортой, аюултай нөхцөл байдал үүсч байсан буюу ийм байдалд байгаа газрын байршил, хил заагийг хэмжиж, талбайгаар болон цэгээр зураглана /Газар хөдлөл, үер, цас их унадаг, нөөлөг салхи, хөрсний бохирдол, гулсалт болон бусад гамшиг, аюулт үзэгдлүүд/.
- Мал, амьтны гоц халдварт өвчний голомттой газар Мал, амьтны гаралтай гоц халдварт өвчнүүд гарч байсан голомт бүхий газруудын байршлыг тэмдэглэх, тархцыг тодорхойлох, малын сэг, зэм устгалын газрыг тэмдэглэсэн
- Хог хаягдлын цэг, уурхайн болон ахуйн аюултай хог хаягдал, оршуулгын газрын байршлыг тодорхойлсон.



*Зураг 40. Сумын мэргэжилтнүүдтэй уулзалт хийж, ажлын зурагт тулгалт хийгдсэн*



*Зураг 41. Баян-Адарга сумын хээрийн судалгааны ажлын зураг*

### 6.1.5. Баян-Адарга сумын судалгааны нэгтгэл

Хэнтий аймгийн Баян-Адарга сумын нутаг дэвсгэрийн төлөвлөгөө, аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд ямар арга хэмжээ тусгаж төлөвлөх шаардлагатай байгааг илрүүлэх зорилгоор сумын хэмжээнд иргэд олон нийтийн санал авах ажлыг зохион байгуулав.

***Хүйсийн харьцаа, насны бүлэг:*** Баян-Адарга сумын хэмжээнд иргэдээс санал авах судалгаанд нийт 90 иргэн хамрагдсан.




*Диаграмм 23. Судалгаанд хамрагдсан иргэдийн хүйсийн харилцаа*

Нийт судалгаанд оролцогчдын 51.1 хувь буюу 46 нь эрэгтэй, 45.6 хувь буюу 41 нь эмэгтэй байна. Судалгаанд оролцсон иргэдийг насны бүлгээр харуулбал 4.4 хувь нь 60+ насны иргэд, 7.8 хувь нь 16-25 насны иргэд, 25.6 хувь нь 26-35 насны иргэд, 21.1 хувь нь 36-45 насны иргэд, 40 хувь нь 46-60 насны иргэд байгаагаас асуултад хариулахаас татгалзсан 1.1 хувь хамрагдсан байна.




*Диаграмм 24. Судалгаанд хамрагдсан насны ангилал*

***Ам бүлийн байдал:*** Судалгаанд нийт 90 хүн оролцсоны ам бүлийн байдлыг дараах диаграммаар харуулав. Сумын хэмжээнд нийт судалгаанд хамрагчдын 3.3 оролцогч ганц бие, 7.8 оролцогч нь хоёулаа, 18.9 оролцогч гурвуулаа, 30.0 оролцогч дөрвүүлээ, 11.1

оролцогч тавуулаа гэх мэтчилэн амьдардаг байна. Судалгаанд оролцогсдын дийлэнх хувь буюу 77.8 хувь нь 3-6 ам бүлийн гишүүнтэй гэж хариулсан байна. Харин 5 оролцогч ам бүлийн гишүүнээ хариулахаас татгалзсан байна.




*Диаграмм 25. Судалгаанд хамрагдсан иргэдийн ам бүлийн тоо*

***Боловсролын түвшин***: Судалгаанд оролцогчид боловсролын түвшингээ дараах байдлаар хариулсан байна. Нийт судалгаанд оролцогчдын 1.1 хувь буюу 1 нь бага боловсролтой, 5.6 хувь буюу 5 нь бүрэн бус дунд боловсролтой, 34.4 хувь буюу 31 нь бүрэн дунд боловсролтой, 10.0 хувь буюу 9 нь тусгай дунд боловсролтой, 46.7 хувь буюу 42 нь дээд боловсролтой, 2.2 хувь буюу 2 нь хариулт өгөөгүй байна.




*Диаграмм 26. Судалгаанд хамрагдсан иргэдийн боловсролын түвшин*

***Хөдөлмөр эрхлэлт:*** Хөдөлмөр эрхлэлтийн талаар судалгаанд хамрагдсан нийт оролцогчдын 41.1 хувь нь төрийн байгууллагад, 21.1 хувь нь хувийн хэвшилд, 12.2 хувь нь хувиараа хөдөлмөр эрхэлдэг, 20.0 хувь нь малчин, 3.3 хувь нь бусад гэж хариулсан байна. Үүнээс ажиглахад салбар бүрийн төлөөлөл судалгаанд хамрагдаж чадсан байна.




*Диаграмм 27. Судалгаанд хамрагдсан иргэдийн ажил эрхлэлтийн байдал*

**Судалгааны үр дүнгээс /жишээгээр/**

***Газрын эрх баталгаажуулалт:*** Газар өмчлөлийн хууль хэрэгжиж багагүй хугацаа өнгөрч байгаа хэдий ч зарим иргэд газрын эрхээ баталгаажуулаагүй байдаг билээ. Иймээс иргэд газар өмчлөх, эзэмших ашиглах эрхээ баталгаажуулсан эсэхийг мэдэх зорилгоор газрын эрхээ баталгаажуулсан эсэх талаар санал асуулгад оруулсан билээ. Судалгаанд оролцогч нийт иргэдийн буюу 71.1 хувь нь газрын эрхээ баталгаажуулж 13.3 хувь нь үгүй гэж хариулж 15.6 хувь нь хариулахаас татгалзсан хариу өгсөн байна.




*Диаграмм 28. Газрын эрхээ баталгаажуулсан эхэх асуултад хариулсан байдал*

***Газрын эрхийн төрөл:*** Газрын эрхийн баталгаажуулалтын төрөл ямар байгааг нийт судалгаанд оролцогч 90 иргэний 46 буюу 51.1 хувь буюу өмчлөх эрх, 29 буюу 32.2 хувь нь эзэмших эрх, 1 буюу 1.1 хувь нь ашиглах эрхээ баталгаажуулж авсан байна. Харин 14 буюу 15.6 хувь нь энэхүү асуултад хариулахаас татгалзсан байна.




*Диаграмм 29. Судалгаанд хамрагдсан иргэдийн газрын эрхийн төрөл*

***E-gazar газрын цахим систем:*** Сүүлийн жилүүдэд техник технологи хөгжиж цахим орчинд ажиллаж амьдрах хэв маяг руу шилжиж газрын салбар ч e-gazar.mn системийг нэвтрүүлж байна. Энэхүү цахим системийг сурталчлах, хэрэглэж хэвших асуудал чухал бөгөөд цахим системийн хэрэглэж буй эсэхийг мэдэх зорилготойгоор e-gazar системийн талаар асуусан билээ. Судалгаанд хамрагдсан нийт 90 оролцогчдын 51 нь оролцогч мэдэхгүй, 29 оролцогч нь мэднэ гэхдээ хэрэглэгч биш, 9 оролцогч нь мэднэ, хэрэглэгч мөн гэж хариулсан байна. Харин 1 оролцогч нь хариулахаас татгалзсан хариу өгчээ. Үүнээс харахад газрын цахим системийн тухай ойлголт бага, хэрэглэгч маш бага хувьтай байна.




*Диаграмм 30. Судалгаанд хамрагдсан иргэд E-gazar газрын цахим системийг мэдэх эсэх*

***Газрын төрх байдал***: Судалгаанд оролцогчдоор ашиглаж байгаа газрынх нь төрх байдлыг өөрсдөөр нь үнэлүүлсэн бөгөөд нийт оролцогчдын 51 буюу 56.7 хувь нь сайн, 33 буюу 36.7 хувь нь дунд, 3 буюу 3.3 хувь нь муу гэж дүгнэжээ. Харин 3 буюу нийт оролцогчдын 3.3 хувь асуултад хариулахаас татгалзсан байна. Өөрсдийн үнэлгээгээр оролцогчид өөрсдийн газраа сайн гэж талаас илүү хувь нь хариулсан.




*Диаграмм 31. Судалгаанд хамрагдсан иргэдийн өөрийн газрын төрх байдлаа үнэлсэн байдал*

***Газар нутгийн доройтол:*** Монгол орны нийт газар нутгийн 70 орчим хувь нь ямар нэг хэмжээгээр өөрчлөлтөд орсон гэдэг судалгааг сүүлийн үед ярих бичих болсон билээ. Нутгийн иргэд газар нутаг нь доройтсонтой санал нийлэх эсэх талаар тодруулах зорилгоор танай газар нутаг доройтсон гэдэгтэй санал нийлэх үү гэсэн асуулт тавьж хариултыг авлаа. Нийт санал асуулгад орсон 90 иргэдийн 57 буюу 63.3 хувь нь тийм, 29 буюу 32.2 хувь нь үгүй гэж хариулжээ. 4 буюу 4.4 хувь нь хариулаагүй байна. Орон нутгийн иргэдийн багагүй хувь нь өөрийн орон нутгийн газар нутаг доройтсон гэдэгтэй санал нийлж байна.




*Диаграмм 32. Газар нутаг доройтсон гэдэгтэй санал нэгдэх эсэх*

***Аймаг/сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд өгөх санал:*** Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд иргэд олон нийтийн саналыг аль болох боломжийн хэмжээгээр авах нь хамгаас чухал. Судалгаанд оролцогчдоос аймаг сумын газар зохион

байгуулалтын төлөвлөгөөнд өгөх саналтай юу гэсэн усуултад нийт оролцогчдын 55 буюу 61.1 хувь нь тийм, 31 буюу 34.4 хувь нь үгүй, 4 буюу 4.4 хувь нь хариулаагүй байна.




*Диаграмм 33. Судалгаанд хамрагдсан иргэдээс газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд өгөх санал байгаа эсэх*

## 6.2. Хоёр дахь шатны хээрийн судалгааны ажил

Хоёр дахь хээрийн судалгааг "Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө"-ний ажлын хүрээнд Багийн Иргэдийн Нийтийн хурлаар 2022 оны 10-р сарын 03- өдрүүдэд Жаргалант, Сайхан багуудад, 2022 оны 10- р сарын 04 өдрүүдэд Дуурлиг, Адарга багийн багийн нийт иргэдийг хэсэгчлэн хуралдуулан иргэдийн санал авсан.

Эхний хээрийн судалгаанд гарахад суурин боловсруулалтын үе шатанд цуглуулсан мэдээллийг үндэслэн боловсруулж ажлын зураг бэлдсэн. Баян-Адарга сумын газар ашиглалтын болон нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний зураг, зэргийг сум, баг бүрээр хэвлэж бэлтгэн хээрийн хэмжилт судалгаанд ашигласан.




*Зураг 42. Баян-Адарга сумын ажлын зураг*




*Зураг 43. Баян-Адарга сумын төлөвлөгөөний ажлын зураг*

Хоёр дахь хээрийн судалгааны судалгаагаар 2022 оны 10-р сарын 03 өдрөөс 2022 оны 10-р сарын 04 өдөр баг тус бүр дээр гурван хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг гарч ажилласан. Ингэхдээ “Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө”-ний ажилд багийн иргэдийн оролцоог хангаж, иргэдийн санал хүсэлтийг тусгах зорилготой ажиллалаа.



№ Т22/065

..Шуурай. овогтой

. НАРАН-ОЧИР. нь

“Хэнтий аймгийн зарим сумдын “Нутаг дэвсгэрийн төлөвлөгөө боловсруулах” ажлын багийн ИНХ-аар хэлэлцүүлэг хийх, хээрийн хэмжилт судалгааны ажлаар 2022 оны 10-р сарын 2 өдрөөс 7 хоног ажиллахаар томилогдсон болно.

ЗАХИРАЛ Ш.НАРАН-ОЧИР

АЖИЛЛАСАН ТЭМДЭГЛЭЛ

| № | Ажилласан газар | Огноо | | Гарын үсэг |
|---|---|---|---|---|
| | | Очсон | Буцсан | |
| 1 | Баян-Адарга | 10/3 | 10/4 | |
| 2 | Норовлин | 10/5 | 10/6 | |
| 3 | [illegible] | 10/7 | 10/8 | |
| 4 | | | | |



№ Т22/067

..Тогтбаатар. овогтой

.БУЯНДЭЛГЭР. нь

“Хэнтий аймгийн зарим сумдын “Нутаг дэвсгэрийн төлөвлөгөө боловсруулах” ажлын багийн ИНХ-аар хэлэлцүүлэг хийх, хээрийн хэмжилт судалгааны ажлаар 2022 оны 10-р сарын 2 өдрөөс 7 хоног ажиллахаар томилогдсон болно.

ЗАХИРАЛ Ш.НАРАН-ОЧИР

АЖИЛЛАСАН ТЭМДЭГЛЭЛ

| № | Ажилласан газар | Огноо | | Гарын үсэг |
|---|---|---|---|---|
| | | Очсон | Буцсан | |
| 1 | Баян-Адарга | 10/3 | 10/4 | |
| 2 | Норовлин | 10/5 | 10/6 | |
| 3 | [illegible] | 10/7 | 10/8 | |
| 4 | | | | |



№ Т22/066

..Батсүх. овогтой

.БААСАНСҮРЭН. нь

“Хэнтий аймгийн зарим сумдын “Нутаг дэвсгэрийн төлөвлөгөө боловсруулах” ажлын багийн ИНХ-аар хэлэлцүүлэг хийх, хээрийн хэмжилт судалгааны ажлаар 2022 оны 10-р сарын 2 өдрөөс 7 хоног ажиллахаар томилогдсон болно.

ЗАХИРАЛ Ш.НАРАН-ОЧИР

АЖИЛЛАСАН ТЭМДЭГЛЭЛ

| № | Ажилласан газар | Огноо | | Гарын үсэг |
|---|---|---|---|---|
| | | Очсон | Буцсан | |
| 1 | Баян-Адарга | 10/3 | 10/4 | |
| 2 | Норовлин | 10/5 | 10/6 | |
| 3 | [illegible] | 10/7 | 10/8 | |
| 4 | | | | |

*Зураг 44. Хээрийн судалгааны томилолт*

Сумын багийн иргэдийн нийтийн хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлж санал авлаа.

1. Хөдөө аж ахуйн газрын хуваарилалт төлөвлөгөөгөө хэлэлцүүлсэн
    a. Улирлын бэлчээр
    b. Бэлчээр сайжруулах
    c. Сумын хадлангийн газар
    d. Сумын тарианлангийн газар
    e. Усжуулах шаардлагатай бэлчээр
    f. Хөдөө аж ахуйн барилга байгууламжийн газар
2. Шинээр байгуулах хот тосгон, бусад суурины газрыг хэлэлцүүлсэн
    a. Сумын төвийг тэг гортигийг тэлэх
    b. Аялал жуулчлалын газар
3. Шинээр тавих боломжтой зам, шугам сүлжээний газрыг хэлэлцүүлсэн
    a. Шинээр барих хатуу хучилттай зам
    b. Холбоо мэдээлэл, дамжуулах станц
4. Ойн сан бүхий газрын төлөвлөлтийн хэлэлцүүлэг
    a. Ойжуулалт хийх газар
    b. Мод үржүүлгийн газар
5. Усны сан бүхий газрын төлөвлөлтийн хэлэлцүүлэг
    a. Усжуулах газар
    b. Засварлах худаг
    c. Хаших булаг, горхи
6. Шинээр тусгай хамгаалалтад авах газрын саналыг хэлэлцүүлсэн
    a. Шинээр орон нутгийн тусгай хамгаалалтад авах газар
    b. Шинээр улсын тусгай хамгаалалтад авах газар
7. Зүй ёсны эрхийг бүртгэн баталгаажуулах саналыг хэлэлцүүлсэн

## 6.3. Сумын БИНХ хэлэлцүүлэх, санал авах

Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний ажлын хүрээнд 2022 оны 10-р сарын 03-ний өдөр Баян-Адарга сумын Жаргалант, Сайхан багийн иргэдийн нийтийн хурлаар багийн иргэдийн оролцоог хангаж, санал хүсэлтийг авч ажиллав.

Жаргалант багийн хувьд багийн иргэдийн нийтийн хуралд 31 хүний ирцтэй байснаас 13 эмэгтэй, 18 эрэгтэй иргэн оролцсон байна.

Сайхан багийн хувьд багийн иргэдийн нийтийн хуралд 44 хүний ирцтэй байснаас 22 эмэгтэй, 22 эрэгтэй иргэн тус тус идэвхтэй оролцсон байна.









Зураг 45. Баян-Адарга сумын Жаргалант багийн иргэдийн нийтийн хурал



Баян-Адарга "Жаргалант" багийн хуралд оролцсон иргэдийн нэрс

| № | Оролцогчийн нэр | Нас | Хүйс | Сум болон багийн нэр |
|---|---|---|---|---|
| 1 | [illegible] | 41 | Эм | Жаргалант |
| 2 | [illegible] | 33 | Эм | Жаргалант |
| 3 | [illegible] | 48 | Эр | Жаргалант |
| 4 | [illegible] | 31 | Эр | Жаргалант |
| 5 | [illegible] | 25 | Эр | Жаргалант |
| 6 | [illegible] | 58 | Эм | Жаргалант |
| 7 | [illegible] | 84 | Эр | Жаргалант |
| 8 | [illegible] | 24 | Эр | Жаргалант |
| 9 | [illegible] | 40 | Эр | Жаргалант |
| 10 | [illegible] | 42 | Эр | Жаргалант |
| 11 | [illegible] | 35 | Эм | Жаргалант |
| 12 | [illegible] | 31 | Эр | Жаргалант |
| 13 | [illegible] | 46 | Эм | Жаргалант |
| 14 | [illegible] | 46 | Эм | Жаргалант |
| 15 | [illegible] | 52 | Эр | Жаргалант |
| 16 | [illegible] | 57 | Эм | Жаргалант |
| 17 | [illegible] | 44 | Эм | Жаргалант |
| 18 | [illegible] | 69 | Эм | Жаргалант |
| 19 | [illegible] | 37 | Эр | Жаргалант |
| 20 | [illegible] | 48 | Эм | Жаргалант |
| 21 | [illegible] | 47 | Эм | Жаргалант |
| 22 | [illegible] | 38 | Эр | Жаргалант |
| 23 | [illegible] | 49 | Эр | Жаргалант |
| 24 | [illegible] | 52 | Эм | Жаргалант |
| 25 | [illegible] | 21 | Эр | Жаргалант |
| 26 | [illegible] | 41 | Эр | Жаргалант |
| 27 | [illegible] | 44 | Эр | Жаргалант |
| 28 | [illegible] | 60 | Эр | Жаргалант |
| 29 | [illegible] | 43 | Эм | Жаргалант |
| 30 | [illegible] | 42 | Эм | Жаргалант |
| 31 | [illegible] | | Эр | Жаргалант |

Зураг 46. Баян-Адарга сумын Жаргалант багийн иргэдийн нийтийн хуралд оролцогчидын нэрс



Зураг 47. Баян-Адарга сумын Сайхан багийн иргэдийн нийтийн хурал



Баян-Адарга "Сайхан" багийн хуралд оролцсон иргэдийн нэрс

| № | Оролцогчийн нэр | Нас | Хүйс | Сум болон багийн нэр |
|---|---|---|---|---|
| 1 | [illegible] | 31 | эм | Баян-Адарга |
| 2 | Жаргалмаа | 49 | эм | Баян-Адарга |
| 3 | Мягмарсүрэн | 34 | эр | Баян-Адарга |
| 4 | Тунгалаг | 43 | эм | Баян-Адарга |
| 5 | [illegible] | 38 | эм | Баян-Адарга |
| 6 | Навчаа | 42 | эм | Баян-Адарга |
| 7 | [illegible] | 58 | эм | Баян-Адарга |
| 8 | Отгон | 68 | эм | Баян-Адарга |
| 9 | [illegible] | 30 | эм | Баян-Адарга |
| 10 | [illegible] | 67 | эм | Баян-Адарга |
| 11 | Оюунбат | | эр | Баян-Адарга |
| 12 | Сарантуяа | 36 | эм | Баян-Адарга |
| 13 | [illegible] | 47 | эр | Баян-Адарга |
| 14 | [illegible] | 37 | эр | Баян-Адарга |
| 15 | Баянмөнх | 44 | эр | БА - Сайхан |
| 16 | [illegible] | 59 | эр | БА - Сайхан |
| 17 | [illegible] | 59 | эр | БА - Сайхан |
| 18 | [illegible] | 29 | эр | БА - Сайхан |
| 19 | [illegible] | 57 | эр | БА - Сайхан |
| 20 | Лхагвасүрэн | 33 | эр | БА - Сайхан |
| 21 | Чулуунбаатар | 43 | эр | БА - Сайхан |
| 22 | Алтанцэцэг | 46 | эм | БА - Сайхан |
| 23 | [illegible] | 45 | эм | БА - Сайхан |
| 24 | [illegible] | 56 | эм | БА - Сайхан |
| 25 | [illegible] | 65 | [illegible] | БА - Сайхан |
| 26 | [illegible] | 65 | эр | БА - Сайхан |
| 27 | [illegible] | 64 | эм | БА - Сайхан |
| 28 | [illegible] | 56 | эр | БА - Сайхан |
| 29 | Мөнхбаатар | 35 | эр | БА - Сайхан |
| 30 | Чойжамц | 34 | эр | БА - Сайхан |
| 31 | [illegible] | 28 | эм | БА - Сайхан |
| 32 | [illegible] | 51 | эр | БА - Сайхан |
| 33 | [illegible] | 26 | эр | БА - Сайхан |
| 34 | [illegible] | 57 | эр | БА - Сайхан |
| 35 | [illegible] | 43 | [illegible] | БА - Сайхан |
| 36 | [illegible] | 52 | эр | БА - Сайхан |
| 37 | Баянзул | 40 | эм | БА - Сайхан |
| 38 | [illegible] | 39 | эр | БА - Сайхан |
| 39 | [illegible] | 26 | эр | (98211133) [illegible] |
| 40 | [illegible] | 48 | эм | БА - Сайхан |
| 41 | [illegible] | 50 | эм | БА - Сайхан |
| 42 | Бух-Очир | [illegible] | эр | БА - Сайхан |
| 43 | [illegible] | 26 | эм | БА - Сайхан |
| 44 | Өлзийсайхан | 28 | эм | БА - Сайхан |
| 45 | | | | |

*Зураг 48. Баян-Адарга сумын Сайхан багийн иргэдийн нийтийн хуралд оролцогчидын нэрс*

Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний ажлын хүрээнд 2022 оны 10-р сарын 04-ний өдөр Баян-Адарга сумын Адарга, Дуурлиг багийн иргэдийн нийтийн хурал болон Даян Дэлхийн байгаль хамгааллын сангийн “Дорнод-Монголын хуурай хээр”-ийн төслийн мэргэжилтнүүд, Хэнтий аймгийн ГХБХБГ-ийн мэргэлжилтэн болон сумын ажлын хэсгийн зарим мэргэжилтнүүдтэй ярилцаж, санал хүсэлтийг авч ажиллав.

Адарга багийн хувьд багийн иргэдийн нийтийн хуралд 30 хүний ирцтэй байснаас 14 эмэгтэй, 16 эрэгтэй иргэн оролцсон байна.

Харин Дуурлиг багийн хувьд Даян Дэлхийн байгаль хамгааллын сангийн “Дорнод-Монголын хуурай хээр”-ийн төслийн мэргэжилтнүүд, Хэнтий аймгийн ГХБХБГ-ийн мэргэлжилтэн болон сумын ажлын хэсгийн зарим мэргэжилтнүүд оролцлоо.



*Зураг 49. Баян-Адарга сумын Адарга багийн иргэдийн нийтийн хурал*

.......Адарга........ багийн хуралд оролцсон иргэдийн нэрс

| № | Оролцогчийн нэр | Нас | Хүйс | Сум болон багийн нэр |
|---|---|---|---|---|
| 1 | Н. Чимэг | 53 | Эм | Адарга |
| 2 | Ц. Цэнд-Аюуш | 60 | Эм | Адарга |
| 3 | [illegible] | 53 | Эм | Адарга |
| 4 | Л. [illegible] | 59 | Эм | Адарга |
| 5 | [illegible] | 59 | Эм | Адарга |
| 6 | Д. [illegible] | 70 | Эм | Адарга |
| 7 | Л. Лхагва | 64 | Эм | Адарга |
| 8 | Л. Ариунаа | 57 | Эм | Адарга |
| 9 | Э. Гантуяа | 47 | Эм | Адарга |
| 10 | П. [illegible] | 49 | Эм | Адарга |
| 11 | [illegible] | 42 | Эр | Адарга |
| 12 | Жавхлан | 48 | Эр | Адарга |
| 13 | [illegible] | 53 | Эр | Адарга |
| 14 | Д. [illegible] | 49 | Эр | Адарга |
| 15 | Д. [illegible] | 46 | Эр | Адарга |
| 16 | Б. [illegible] | 62 | Эр | Адарга |
| 17 | М. [illegible] | 44 | Эр | Адарга |
| 18 | Т. [illegible] | 25 | Эр | Адарга |
| 19 | Р. [illegible] | 63 | Эр | Адарга |
| 20 | Л. Мөнхбат | 59 | Эр | Адарга |
| 21 | П. [illegible] | 65 | Эр | Адарга |
| 22 | А. [illegible] | 45 | Эм | Адарга |
| 23 | Ш. [illegible] | 44 | Эм | Адарга |
| 24 | Ц. [illegible] | 50 | Эм | Адарга |
| 25 | Ц. [illegible] | 68 | Эр | Адарга |
| 26 | Г. [illegible] | 47 | Эр | Адарга |
| 27 | О. Даваасүрэн | 38 | Эр | Адарга |
| 28 | А. [illegible] | 25 | Эр | Адарга |
| 29 | Ч. [illegible] | 31 | Эр | Адарга |
| 30 | С. [illegible] | 51 | Эм | Адарга |
| 31 | | | | |

Зураг 50. Баян-Адарга сумын Адарга багийн иргэдийн нийтийн хуралд оролцогчидын нэрс




Зураг 51. Дуурлиг багийн холбогдох албан хаагч, мэргэжилтэн



"Дуурлиг" сумын төв ........ багийн хуралд оролцсон иргэдийн нэрс

| № | Оролцогчийн нэр | Нас | Хүйс | Сум болон багийн нэр |
|---|---|---|---|---|
| 1 | [illegible] | 51 | эр | [illegible] |
| 2 | [illegible] | 44 | эр | [illegible] |
| 3 | [illegible] | 48 | эр | [illegible] |
| 4 | [illegible] | 44 | эр | [illegible] |
| 5 | [illegible] | 32 | эр | [illegible] |
| 6 | [illegible] | 26 | эр | [illegible] |
| 7 | [illegible] | 37 | эр | [illegible] |
| 8 | [illegible] | 38 | эр | [illegible] |
| 9 | [illegible] | 40 | эр | [illegible] |
| 10 | [illegible] | 26 | эм | [illegible] |
| 11 | | | | |

*Зураг 52. Дуурлиг багийн уулзалтад оролцсон хүмүүсийн бүртгэлийн хуудас*

### 6.3.1. Хөдөө аж ахуйн газрын төлөвлөгөө

***Бэлчээрийн улирлын ашиглалтын төлөвлөгөө:*** Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлд “Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн нутгийн онцлог, бэлчээрийг ашиглаж ирсэн уламжлал, зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх шаардлагыг харгалзан өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржаа, отрын нөөц нутаг гэсэн ерөнхий хуваарийн дагуу газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган батална.” гэж заасан байдаг.

*Хүснэгт 57. Улирлын бэлчээрийн төлөвлөгөө*

| № | Бэлчээрийн хуваарь | Талбай, га | Эзлэх % |
|---|---|---|---|
| 1 | Зун, намрын бэлчээр | 51742 | 17.1 |
| 2 | Хаврын бэлчээр | 21686.8 | 7.2 |
| 3 | Өвөл, хаврын бэлчээр | 194313 | 64.2 |
| 4 | Өвлийн бэлчээр | 34865.5 | 11.5 |
| **Нийт** | | **302607.6** | **100** |




*Диаграмм 34. Улирлын бэлчээрийн эзлэх хувь*




*Зураг 53. Улирлын бэлчээрийн төлөвлөгөө*

***Бэлчээр сайжруулах төлөвлөгөө:*** Сумын хэмжээнд нийт 11978.7 га бэлчээрийг сайжруулхаар төлөвлөж байна. Үүнээс сэлгэн өнжөөх 11290.4 га, тордон сайжруулах 688.3 га байна.

*Хүснэгт 58. Бэлчээр сайжруулах төлөвлөгөө*

| № | Багийн нэр | Газрын нэр | Талбай, га | Эзлэх % | Төрөл |
|---|---|---|---|---|---|
| 1 | Сайхан | Сайханы хөндий | 7575.3 | 63.2 | Сэлгэн өнжөөх |
| 2 | Сайхан | Шуус, Сайханы бэлчир | 2788.8 | 23.3 | Сэлгэн өнжөөх |
| 3 | Дуурлиг | Батын булаг, төхөм | 926.3 | 7.7 | Сэлгэн өнжөөх |
| 4 | Жаргалант | Арангатын адаг | 688.3 | 5.7 | Тордон сайжруулах |
| **Нийт** | | | **11978.7** | **100** | - |




*Диаграмм 35. Бэлчээр сайжруулах газрын эзлэх хувь*




*Зураг 54. Бэлчээр сайжруулах газрын төлөвлөгөө*

**Усжуулах бэлчээр:** Сумын хэмжээнд нийт 2 багийн 8 байршилд 3189.4 га газрыг усжуулахаар төлөвлөсөн. Энэ нь нийт нутаг дэвсгэрийн 1.0 хувийг эзэлж байна.

*Хүснэгт 59. Усжуулах бэлчээрийн төлөвлөгөө*

| № | Багийн нэр | Газрын нэр | Талбай, га | Эзлэх % |
|---|---|---|---|---|
| 1 | Сайхан | Бага бургасны ам | 303.7 | 9.5 |
| 2 | Сайхан | Зүүн булаг | 432.6 | 13.6 |
| 3 | Сайхан | Зүүн даваа | 300.1 | 9.4 |
| 4 | Сайхан | Зүүн салаа | 261.9 | 8.2 |
| 5 | Сайхан | Их Бургасны ам | 340.1 | 10.7 |
| 6 | Сайхан | Товог | 564.8 | 17.7 |
| 7 | Жаргалант | Нарстын ам | 611.8 | 19.2 |
| 8 | Жаргалант | Шаргын нарийн хөндий | 374.4 | 11.7 |
| **Нийт** | | | **3189.4** | **100** |




*Диаграмм 36. Усжуулах бэлчээрийн эзлэх хувь*




*Зураг 55. Усжуулах бэлчээрийн төлөвлөгөө*

**Хадлангийн газар:** Сумын хэмжээнд нийт 2 багийн 2 байршилд 615.5 га талбайг хадлангийн газрын нөөцөөр бүртгэхээр төлөвлөсөн.

*Хүснэгт 60. Хадлангийн газрын төлвөлгөө*

| № | Багийн нэр | Газрын нэр | Талбай, га | Эзлэх % |
|---|---|---|---|---|
| 1 | Сайхан | Бор хоолой | 251.4 | 40.8 |
| 2 | Адарга | Хамхагтын ам | 364.1 | 59.2 |
| **Нийт** | | | **615.5** | **100** |




*Зураг 56. Хадлангийн газрын төлөвлгөө*

**Тариалангийн газар:** Сумын хэмжээнд Жаргалант багийн 1 байршилд 244.1 га атаршсан талбайг эргэлтэд оруулахаар төлөвлөсөн.




*Зураг 57. Тариалангийн газрын төлөвлөгөө*

**Хөдөө аж ахуйн барилга байгууламжийн газар:** Сумын хэмжээнд нийт 3 багийн 4 байршилд мал угаалгын цэг шинээр барихаар төлөвлөсөн.

*Зураг 58. Хөдөө аж ахуйн барилга байгууламжийн газрын төлөвлөгөө*

| № | Багийн нэр | Газрын нэр | Уртраг | Өргөрөг |
|---|---|---|---|---|
| 1 | Жарналант | Өндөр толгой | 111°05'21.4" | 48°22'45.1" |
| 2 | Сайхан | Сайнцагаан | 111°39‘21.1" | 48°28'43.1" |
| 3 | Адарга | Өвлийн өвөр | 111°18'22.2" | 48°33'10.7" |
| 4 | Адарга | Уртын булаг | 111°25'35.9" | 48°37'44.5" |




*Зураг 59. Хөдөө аж ахуйн барилга байгууламжийн газрын төлөвлөгөө*

### 6.3.2. Хот тосгон, бусад суурин газрын төлөвлөгөө

Орон нутгийн санал, хэрэгцээ шаардлагыг үндэслэн сумын төвийн 757.3 га суурьшлын бүсийг шинээр тогтоон тэг гортигийг 1239.9 га болгон тэлсэн.




*Зураг 60. Шинээр үүсгэх суурьшлын бүсийн төлөвлөгөө*

**Амралт, аялал жуулчлалын газар:** Хэнтий аймгийг аялал жуулчлалыг гол бүс нутаг болгон хөгжүүлэх бодлогыг үндэслэн Баян-Адарга сумын нийт 2 багийн 4 байршилд аялал, жуулчлал хөгжүүлэхээр төлөвлөсөн. Мөн аймгийн болон сумын аялал жуулчлалын маршрут Биндэр – Баян-Адарга – Дадал гэсэн маршрутаар дайран өнгөрхөөр төлөвлөлөө.

*Хүснэгт 61. Амрал, аялал жуулчлалын газрын төлөвлөгөө*

| № | Багийн нэр | Газрын нэр | Уртраг | Өргөрөг |
|---|---|---|---|---|
| 1 | Дуурлиг | Онон | 111°03'26.2" | 48°34'31.6" |
| 2 | Дуурлиг | Онон | 111°02'50.1" | 48°33‘08.6" |
| 3 | Адарга | Шуусын ам | 111°27'47.5" | 48°42'31.6" |
| 4 | Адарга | Гүүрний баруун тал | 111°14‘06.3" | 48°41'54.6" |

*Хүснэгт 62. Аялал, жуулчлалын үзвэрийн цэг*

| № | Багийн нэр | Газрын нэр | Уртраг | Өргөрөг | Төрөл |
|---|---|---|---|---|---|
| 1 | Дуурлиг | Дуурлиг Нарсны хүнну булш | 111°04'41. 9" | 48°32'20.4" | Түүхэн аялалын маршрут |
| 2 | Дуурлиг | Монгол хатадын өргөө | 111°04'10. 0" | 48°33'11.4" | Түүхэн аялалын маршрут |
| 3 | Адарга | Бууралын агуй | 111°05'22. | 48°46'38.6" | Түүхэн аялалын |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | 5" | | маршрут |




*Зураг 61. Аялал, жуулчлалын газрын төлөвлөгөө*

### 6.3.3. Зам, шугам сүлжээний газрын төлөвлөгөө

**Авто замын газар:** Сумын аялал, жуулчлал, эдийн засаг, бүтээн байгуулалт хөгжих хамгийн гол тулгуур нь авто зам бөгөөд Биндэр – Баян-Адарга, Баян-Адарга – Дадал гэсэн маршрутын дагуу 38.9 км хатуу хучилттай замыг төлөвлөсөн.

Мөн сумын нийт 4 байршилд гүүр, даваа шинээр барих, засварлахаар төлөвлөсөн.

*Хүснэгт 63. Автозамын барилга байгууламжийн газрын төлөвлөгөө*

| № | Багийн нэр | Газрын нэр | Төрөл |
|---|---|---|---|
| 1 | Сайхан | Тэмээн хүзүүвч | Гүүр |
| 2 | Сайхан | Элстийн үзүүр | Гүүр |
| 3 | Сайхан | Зүүн даваа | Даваа засах |

| | | | |
|---|---|---|---|
| 4 | Дуурлиг | Баруун даваа | Даваа засах |




*Зураг 62. Автозамын газрын төлөвлөгөө*

**Холбоо мэдээлэл дамжуулах станц**: Аймгийн бодлогын хүрээнд түүхэн аялал жуулчлалын маршрутын дагуу утасны сүлжээ таслахгүй байх бодлого баримталж байгааг харгалзан сумын хэмжээнд нийт 3 багийн 7 байршилд холбоо мэдээлэл дамжуулах станц төлөвлөсөн.

*Хүснэгт 64. Холбоо мэдээлэл дамжуулах шугам, станцын төлөвлөгөө*

| № | Багийн нэр | Газрын нэр | Уртраг | Өргөрөг |
|---|---|---|---|---|
| 1 | Жаргалант | Их Барчгайт уул | 111°01'16.5" | 48°17'23.8" |
| 2 | Жаргалант | Нямын Өндөр уул | 111°02'36.1" | 48°11'45.0" |
| 3 | Сайхан | Хангайн уул | 111°11'46.8" | 48°21'51.5" |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 4 | Сайхан | Хар Чулуут уул | 111°22'40.9" | 48°28'11.3" |
| 5 | Адарга | Цагаан Өндөр уул | 111°04'47.0" | 48°50'16.2" |
| 6 | Адарга | Хар овоот уул | 111°12'50.3" | 48°41'21.4" |
| 7 | Адарга | Алаг уул | 111°20‘04.7" | 48°35'28.3" |




*Зураг 63. Холбоо мэдээлэл дамжуулах станцын төлөвлөгөө*

### 6.3.4. Усны сан бүхий газрын төлөвлөгөө

**Хөв цөөрөм:** УГЗБЕТөлөвлөгөөний саналыг үндэслэн сумын хэмжээнд нийт 5 байршилд хөв цөөрөм байгуулахаар төлөвлөсөн.

*Хүснэгт 65. Хөв цөөрөм байгуулах газрын төлөвлөгөө*

| № | Багийн нэр | Газрын нэр | Уртраг | Өргөрөг |
|---|---|---|---|---|

| | | | | |
|---|---|---|---|---|
| 1 | Адарга | Таван толгойт ам | 111°32‘01.2" | 48°39'38.7" |
| 2 | Жаргалант | Булштын ам | 111°00'56.8" | 48°21'14.8" |
| 3 | Жаргалант | Арангатын тасаг | 110°58'38.0" | 48°27'39.4" |
| 4 | Сайхан | Сүүл ухаа | 111°20‘10.4" | 48°24'57.6" |
| 5 | Сайхан | Сайханы хоолой | 111°36'32.7" | 48°26'11.0" |




*Зураг 64. Хөв цөөрөм байгуулах газрын төлөвлөгөө*

**Булгийн эхийг хашаалж хамгаалах:** Булгийн эхийг хашиж, хамгаалах, тохижуулах ундны усан хангамжийг сайжруулж хамгаалах зориолгоор нийт 17 байршилд төлөвлөлт хийсэн.

*Хүснэгт 66. Булгийн эхийг хашаалж хамгаалах газрын төлөвлөгөө*

| № | Багийн нэр | Газрын нэр | Уртраг | Өргөрөг |
|---|---|---|---|---|

| | | | | |
|---|---|---|---|---|
| 1 | Жаргалант | Хонхорын булаг | 110°51'37.9" | 48°25'48.7" |
| 2 | Жаргалант | Өвдөгийн булаг | 110°50‘08.9" | 48°24'15.4" |
| 3 | Жаргалант | Арангатын рашаан | 110°54'32.6" | 48°24'49.0" |
| 4 | Сайхан | Сайханы булаг | 111°18'49.3" | 48°19'54.6" |
| 5 | Сайхан | Дунд булаг | 111°25'58.3" | 48°20'58.3" |
| 6 | Сайхан | Зүүн булаг | 111°29'10.2" | 48°22'26.7" |
| 7 | Сайхан | Баруун булаг | 111°18'39.8" | 48°15'53.4" |
| 8 | Сайхан | Их Бургасны булаг | 111°19'45.6" | 48°27'53.8" |
| 9 | Сайхан | Лонхтын булаг | 111°23'26.6" | 48°30'15.0" |
| 10 | Дуурлиг | Батын булаг | 111°11'59.3" | 48°33'59.8" |
| 11 | Дуурлиг | Хав шивэрийн булаг | 111°08'51.8" | 48°31'58.0" |
| 12 | Дуурлиг | Нарстын булаг | 111°06'34.3" | 48°33'45.2" |
| 13 | Адарга | Модны булаг | 111°04'25.2" | 48°48'11.5" |
| 14 | Адарга | Зүүн булаг | 111°02‘36.3" | 48°39'52.9" |
| 15 | Адарга | Дунд булаг | 111°01'48.1" | 48°39'15.1" |
| 16 | Адарга | Баруун булаг | 110°59'42.2" | 48°39'24.1" |
| 17 | Адарга | Уртын булаг | 111°26'55.4" | 48°37'33.1" |




*Зураг 65. Булгийн эхийг хашиж, хамгаалах газрын төлөвлөгөө*

### *6.3.5. Ойн сан бүхий газрын төлөвлөгөө*

**Ойжуулалт хийх газар:** “Тэр бум мод” үндэсний хөдөлгөөнөөр шинээр ойжуулалт хийх газрыг УГЗБЕТөлөвлөгөөний саналаар нийт 1908 га газарт таримал ой бий болгохоор төлөвлөсөн.

**Мод үржүүлэг:** Сумын хэмжээнд нийт 4 байршилд мод үржүүлгийн газар байгуулахаар төлөвлөсөн.

*Хүснэгт 67. Мод үржүүлгийн газрын төлөвлөгөө*

| № | Багийн нэр | Газрын нэр | Уртраг | Өргөрөг |
|---|---|---|---|---|
| 1 | Жаргалант | Нарстын ам | 111°01'16.4" | 48°27‘04.1" |
| 2 | Сайхан | Багийн төв | 111°19'47.6" | 48°22'48.4" |
| 3 | Дуурлиг | Сумын ард | 111°04'58.2" | 48°33'59.4" |
| 4 | Дуурлиг | Нарстын булаг | 111°06'51.9" | 48°33'40.8" |




*Зураг 66. Ойн сан бүхий газрын төлөвлөгөө*

### *6.4.6. Тусгай хамгаалалттай газрын төлөвлөгөө*

**Улын тусгай хэрэгцээний газар:** Улсын тусгай хэрэгцээнд Улз голын эх, Хурх хүйтний хөндийн байгалийн нөөцийн газраар тусгай хэрэгцээнд авахаар төлөвлөсөн.

**Орон нутгийн тусгай хамгаалалтад авах**: Сумын хэмжээнд орон нутгийн тусгай хэрэгцээнд Сайхан, Жаргалант багийн Сайханы хоолой, Ням өндөр, Шийр орчмийн 50.3 мян.га газрын Цагаан зээрийн цөм нутгийг хамгаалах, уул уурхайн олборлолтоос сэргийлэх зорилгоор авхаар төлөвлөсөн.




*Зураг 67. Тусгай хамгаалалтад авах газрын төлөвлөгөө*

# АШИГЛАСАН НОМ, БҮТЭЭЛИЙН ЖАГСААЛТ


1 Д.Доржготов “Монгол орны хөрс” УБ, 2003 он

2 БНМАУ-ын уур амьсгал, гадаргын усны нөөцийн атлас, (1985)

3 Ш.Цэгмид. Монгол орны физик газар зүй, УБ-1967

4 “Хэнтий аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний тайлан” Хэнтий аймгийн засаг даргын тамгын газар газрын алба

5 Г. Цолмон “Монгол орны бэлчээр хадлангийн ангилаа” ГБХ.1993

6 Ш.Баясгалан Д.Даваадорж . Монгол орны ХАА-н уур амьсгалын лавлах.1996.

7 Г.Пүрэвцэрэн., Ж.Наранцацралт. Газрын менежментийн онолын үндэс. 2000 он

8 Г.Пүрэвцэрэн Газрын сангийн менежмент, 2000 он

9 Р.Цэрэндулам. Тэжээлийн шимт чанарын хүрд, 1980 он

10 Газрын нэгдмэл сангийн үндсэн ангиллын тайлан. ГХГЗЗГ. 2012, 2013, 2014 он

11 Монгол орны гадаргын усны тооллого, 2011 он

12 Л.Уранбилэг “Нийслэл орчимд сүүний эрчимжсэн аж ахуй хөгжүүлэхэд тохиромжтой газар нутгийн агро экологийн үнэлгээ” сэдэвт магистрын ажил, 2003 он

13 Хэнтий аймгийн статистикийн эмхэтгэл, 2014 он

14 Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний сүлжээ, түүний үнэлгээ. 2003 он.

15 Хэнтий аймгийн бэлчээрийн төлөв байдал, улсын чанарын хянан баталгааны судалгааны тайлан, 2010 он

16 Баян-Адарга сумын хот, тосгон бусад суурин газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны тайлан, 2012 он

17 Баян-Адарга сумын тариалан болон атаршсан газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны тайлан, 2011 он

18 Хэнтий аймгийн Баян-Адарга сумын төвийн дахин төлөвлөлтийн тайлбар бичиг, 2014 он

19 Онон Балжийн байгалийн цогцолборт газрын орчны бүсийн менежментийн төлөвлөгөө. Хэнтий аймаг, Баян-Адарга сум, 2011-2015 он

***Хууль тогтоомж, дүрэм журам***


1. Газрын тухай хууль. Байгаль орчны тухай Монгол Улсын хуулиуд, 1997 он
2. Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль.
3. Газрын хэвлийн тухай хууль. Байгаль орчны тухай Монгол Улсын хуулиуд, 1997 он
4. Хот байгуулалтын тухай хууль 1998 он
5. Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм, дүрэм. 2004 он
6. “Аймаг, Нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах аргазүйн заавар” УБ, 2008 он
7. “Сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал” УБ, 2011 он
8. Монгол улсын жижиг гол, усны хамгаалалтын бүсийн дүрэм
9. Монгол улсын стандарт MNS 4652-28
10. Монгол улсын стандарт MNS 4628-98 “Шатахуун түгээх станц, барилга байгууламж, тоног төхөөрөмжийн техникийн ерөнхий шаардлага” УБ, 1998 он
11. “Харилцаа холбооны тухай хууль”, Засгийн газрын 2001 оны 263 дугаар тогтоол
12. "Авто замын тухай хууль"-ийн 12.2 зүйл
13. “Ойн тухай хууль” 2012 оны 5-р сарын 17
14. “Аялал жуулчлалын тухай хууль”  2000 оны 5-р сарын 5